

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2023 оны оны жилийн эцсийн байдлаар/

2023.12.28

Эрдэнэт хот

№	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
									Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5		6	7	8	9	10	11	12	13
НЭГ.ЭРҮҮЛ МЭНД, БИЕИЙН ТАМИР, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО													
ЭРҮҮЛ МЭНД													
1	1.1Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, үр нөлөөг дээшлүүлэн ажиллах	2021-2024	ЭМГ	ЭМБ	Улс болон олон улсын төсөл хөтөлбөр	133.0	Хөтөлбөр үүдийн хэрэгжилтийн дундаж 83%	Хэрэгжилтийн хувь 86%-д хүрсэн байна.	30.0	Орон нутгийн төсөв 243.0 ЭМДС 29.5	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын тушаалаар 9 арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж хэрэгжилт 2021 онд 84.5 хувь, 2022 онд 83.8 хувь, 2023 оны байдлаар дунджаар 88.1 хувийн хэрэгжилттэй буюу өмнөх оноос 4.3 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд тус арга хэмжээнүүдийн хүрээнд: - Орон нутгаас төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд 243.0 сая, эрүүл мэндийг дэмжих сангаас 29.5 сая төгрөг, ДЭМБ төслөөс 10.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж үйл ажиллагаанд зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад санхүүжилт 1.1 дахин нэмэгдсэн байна. - Арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд нийт 184182 буюу 34.5 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 хувиар нэмэгдсэн. Тайлант хугацаанд 20 удаагийн өдөрлөг, аян, 110 удаагийн сургалтад 7750 иргэнийг хамруулж, 50 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн телевизүүдтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн байна.	100%
2		Хүн амын дунд эрүүл мэндийн суурь судалгааг хийж, түүнд түшиглэсэн эрүүл	2022	ЭМГ	Аймгийн ЗДТГ ЭМБ	Олон улсын төсөл хөтөлбөр	50.0	Суурь судалгааны тоо, үр дүн-1	Тандалт судалгаанд хүн амын 1%-ийг	50.0	Орон нутгийн төсөв 4.0	Эрдэм шинжилгээний бага хурлыг жил тутам зохион байгуулж ирсэн бөгөөд 2021-2022 онд 66 илтгэл хэлэлцүүлсэнээс улсын хэмжээнд 2 илтгэл хэлэлцүүлэгдэж, 3 суурь судалгаа хийгдсэн. 2023	100%

		мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх				орон нутгийн төсөв			хамруулсан байна.			оны байдлаар эрдэм шинжилгээний бага хурлаар 30 илтгэл хэлэлцүүлэгдсэн. Тайлант хугацаанд 3 судалгаа хийгдсэнээс: - Эрүүл мэндийн салбарын 21 байгууллагын 405 эмч эмнэлгийн мэргэжилтний ажлаас халшрах хам шинжийг илрүүлэх судалгаагаар үйлчлүүлэгчдийг сэтгэлээрээ мэдрэх чадвар буурах шинжийн хувьд 36.9% өндөр, 22.5% дунд, хувь хүний бүтээмж буурах байдал 31.2% өндөр, 17.6% нь дунд, бие хүний сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийн шинжээрээ 13.4% нь өндөр түвшинд, 25% нь дунд үүнээс 4% нь ажлаас халшрах хам шинжтэй, 3.7% ажлаас халшрах хам шинжид өртөх магадлал өндөр байна. Судалгааны дүнд дүгнэлт хийж, сэтгэл зүйн сургалт, ярилцлага зохион байгуулан 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Одоогийн байдлаар: - Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний 6-р судалгаанд 288 иргэний хоол тэжээлийн үнэлгээ, - “Зөвийг дадал болгоё” төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн 200 хүүхэд, 600 эцэг эхийг хамруулсан амны хөндийн эрүүл ахуйн талаарх мэдлэг хандлага дадлыг үнэлэх судалгаагаар асран хамгаалагчийн мэдлэг 87.2%, хандлага 75.9%, дадал 64.7%-тай байна.	
3		“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгүүдэд элэгний вирусийг эрт илрүүлж, өвчлөлийг бууруулах, эмчлэх ажлыг зохион байгуулах	2021-2024	ЭМГ	СӨЭМТ	Эрүүл мэндийг дэмжих сан Улс, Орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр	120.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 83.4%	Хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.	30.0	-	2020 онд “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийт 72205 иргэнийг хамруулахаас 52952 иргэнийг хамруулж хамралт 73.3 хувьтай улсад тэргүүлж нийт илрүүлэгт хамрагдсан иргэнээс 4129 хүн буюу 7.8 хувьд нь С вирус, 3825 хүн буюу 7.2 хувьд нь В вирус илэрч, 64.3 хувь нь баталгаажуулах шинжилгээнд хамрагдан вирусийн эсрэг эмчилгээнд 1326 хүн хамрагдаж эдгэрсэн үр дүнтэй хэрэгжиж дууссан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар тушаалаар батлагдсан “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан. Тайлант онд элэгний В, С вирусийн илрүүлэх шинжилгээнд 6163 иргэн хамрагдсанаас 195 хүн буюу 3.2 хувьд нь С вирус, 153 хүн буюу 2.5 хувьд нь В вирус илэрч, 65 хүн эмчилгээнд хамрагдсан. Нярайн төрсний дараа 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 99.7 хувь, 2 настай хүүхдийн А вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 100 хувьтай байна. В вирусийн эсрэг тархвар судлалын заалтаар	85.8%

											дархлаажуулалтад 516 иргэн хамрагдсан. Элэгний В, С вирусээс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг таниулах 7 төрлийн зурагт хуудсыг цахимаар 8081 хүнд түгээж, 88 хүнийг сургалтад хамруулсан байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын 231 эмч буюу нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 26.4 хувийг хамруулсан байна. Тайлант хугацаанд вируст гепатитын 8 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.7 промилл байна. 2023 онд элэгний хорт хавдрын нас баралт 36 тохиолдол буюу 10000 хүн амд 3.6 промилл байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 промиллоор буурсан, элэгний хатуурлын нас баралт 15 тохиолдол буюу 10000 хүн амд 1.4 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 промилл буурсан. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хэрэгжилт 85.8 хувьтай байна.		
4		Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг (хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх) үзлэгийг эрчимжүүлэх	2021-2024	ЭМГ	ЭМБ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	45.0	Эрт илрүүлэг 60.4%	Эрт илрүүлгийг 2%-иар нэмэгдүүлсэн байна.	15.0	-	Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн дундаж хувь 2021 онд 47 хувь, 2022 онд 31.4 хувь, 2023 онд 95.4 хувь болж өмнөх оны мөн үеэс 62.9 хувиар нэмэгдсэн байна. Үүнд: - Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-аас дээш насны нийт 52703 буюу хамрагдвал зохих хүн амын 99.3 хувийг эзэлж, өмнөх оноос 36.5 хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 0.9 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 40- өөс дээш насны нийт 29409 буюу хамрагдвал зохих хүн амын 117.7 хувийг эзэлж, өмнөх оноос 39.5 хувиар өсч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувь нь онош батлагдсан байна. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 3082 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 111.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 82.9 хувиар өссөн. Пап шинжилгээнд нийт 1525 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 17501 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 92.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 43.0 хувиар өссөн байна.	100%

												- Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт 908 хүн буюу 56.0 хувь нь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 47.3 хувиар нэмэгдсэн байна. Хүн амын нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгээр 60 хавдрыг эрт үед нь илрүүлж, эмчлэн эрүүлжүүлсэн байна. Эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад 20 байгууллагын 80 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг, “Иргэн бүр зүрхээ хайрлая” аяныг зохион байгуулж орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийг зарцуулан төрийн болон хувийн хэвшил, анхан шатны байгууллагын 100 эмчийг тус тус сургалтад хамруулж, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер, зөвлөмжийг 3200 иргэнд, цахимд 131 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 443651 иргэнд хүргэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 24 удаагийн ярилцлагыг иргэдэд хүргэсэн.	
5		Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	БОЭТ	Орон нутгийн төсөв	280.0	Дэмжлэгт хамрагдсан хувь 16.8%	Дэмжлэгт хамрагдсан хувь 17.2%-д хүрсэн байна.	70.0	Орон нутгийн төсөв 69.8	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 2021 онд 128 иргэнд 60.0 сая төгрөг, 2022 онд 177 иргэнд 69.8 сая төгрөг, 2023 онд 162 иргэнд 69.8 сая төгрөгийг тус тус олгосон байна. Тайлант хугацаанд хавдрын 214 тохиолдол бүртгэгдэж, хяналтад орсноос эмийн болон эмчилгээний дэмжлэгт 75.7 хувь нь хамрагдсан байна.	100%
6		“Эрүүл хамт олон” ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	ТББ	Орон нутгийн төсөв	24.0	ЭМДБ-ын тоо 66	0.5%-иар нэмэгдсэн байна.	6.0	Орон нутгийн төсөв 10.0	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэн ажилласны дүнд 2021 онд 2 байгууллага, 2022 онд 2 байгууллага, 2023 онд 5 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон. Тайлант хугацаанд: - 21 төрийн байгууллагын 1180 албан хаагчийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулж, “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд жин бууруулах 1 сарын уралдааныг 10 байгууллагын 60 хүнийг хамруулж зохион байгуулснаар аяны хугацаанд оролцогчид нийт 93.4 кг жин хаяжээ. - Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 81 байгаагаас боловсролын салбарын 45, эрүүл мэндийн салбарын 14, үйлдвэр аж ахуйн нэгж 12, бусад 10 байгууллага байна.	100%

												Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийг шийдүүлэн ажилласан.	
7	1.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар сэргийлж болох өвчлөл, нас баралтыг бууруулна	БОЭТ-ийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ БОЭТ	ЭМБ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	400.0	-	Үйл ажиллагаа тогтмолжсон байна.	-	-	БОЭТ-ийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төв нь нийт 320 м2 талбай бүхий стандартын шаардлага хангасан байранд үйлчлүүлэгчдэд эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус төв нь байгуулагдсанаас хойш нийт 10941 иргэнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулснаас ходоод, улаан хоолойн 45 хавдар оношлогдсоны 77.7 хувийг эрт үед нь илрүүлэн орон нутагт ходоодны салст хуулах хагалгаанд 16, Хавдар судлалын үндэсний төвд 29 тохиолдлыг илгээсэн үзүүлэлттэй байна. 2023 онд 4 насны багцаар 17879 хүнийг хамруулснаас 8016 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 2044 буюу 35.5 хувь нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин, 1621 буюу 20.2 хувь нь дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, 281 буюу 3.5 хувь нь шээс бэлгийн тогтолцооны өвчин, 2067 буюу 25.7 хувь нь зүрх судасны тогтолцооны өвчин, 95 буюу 1.1 хувь нь амьсгалын тогтолцооны өвчлөл бүртгэгдсэн нь тэргүүлэх шалтгаан болж нийт өвчлөлийн сэжигтэй тохиолдлын 76 хувийг эзэлж байна.	100%
8	1.2.1.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн менежментийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг нэмэгдүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна.	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологийг нутагшуулах	2021-2024	ЭМГ БОЭТ	Аймгийн ЗДТГ	Улс болон орон нутгийн төсөв	380.0	-	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологи нэвтэрч үйл ажиллагаа тогтмолжсон байна.	50.0	Орон нутгийн төсөв 80.0	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэдрэл, дотор, эрчимт эмчилгээний тасагт хийгдэх бүлэн хайлуулах эмчилгээг нутагшуулах ажлын хүрээнд: - 1 эмч, 1 сувилагч сургагдаж бэлтгэгдсэн. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын тушаалаар Тархины харвалтын нэгж байгуулагдаж, мэдрэлийн тасагт 2 ор, эрчимт эмчилгээний тасагт 2 ор, дотрын тасагт тархины харвалтын нэгж байгуулсан. - Тайлант хугацаанд судсан дотуурх оношилгоо эмчилгээг 182 хүнд хийж, зүрхний цочмог шигдээс өвчний нас баралтыг өнгөрсөн оноос 11 тохиолдлоор буюу 1 промиллоор бууруулсан байна. - Эрүүл мэндийн даатгалаас тус өндөр өртөгт хагалгааны зардалд нэг иргэнд 4.9 сая төгрөгийг төлж байна. Орон нутгийн төсвөөс 80.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 12 ширхэг бүлэн хайлуулах РЭПИ/актилизе/-р хангасан байна. Тайлант хугацаанд бүлэн уусгах эмчилгээ 5	100%

												үйлчлүүлэгчид амжилттай хийгдэж, эмчилгээнд хамрагдсан 5 үйлчлүүлэгчийн гар хөлийн саа 1-4 цагийн дотор сэргэсэн үр дүнтэй байна.	
9	1.2.2.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэл зүй, эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг сайжруулна.	Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, стандартын хэрэгжилтийг хангуулан, тогтвортой үйл ажиллагааг дэмжих	2021-2024	ЭМГ	Эм ханган нийлүүлэх байгууллага Эмийн сан Эм холбоо	-	-	Эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сангуудын стандартын хэрэгжилт 88%	Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилтийг 95%-д хүрсэн байна.	-	-	Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 79 эмийн сан, 8 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 5 эмийн сан шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, 11 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцлан, 4 эмийн сан үйл ажиллагааг нь түр түдгэлзүүлсэн. Эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт 2021 онд дунджаар 88.9 хувь, 2022 онд 88.1 хувь, 2023 онд дунджаар 93.5 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 5.4 хувиар нэмэгдсэн байна. Үүнд: - “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 93.15%-тай үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 1.25%-аар сайжирсан байна. - Эм ханган нийлүүлэх байгууллагын стандартын шаардлага 92.5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 1.1%-аар сайжирсан байна. Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/108 тоот тушаалаар “Эмийн чанар, аюулгүй байдлын орон тооны бус салбар зөвлөл” 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эмийн чанар, эмийн гаж нөлөөний сургалтад 86 эрхлэгчийг хамруулж, “Антибиотик эмийг жороор олгоё” 3 сарын аянд 79 эмийн сан нэгдэн антибиотекийг 100 хувь жороор олгон, 111 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулан гарын авлагаар ханган, антибиотикийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөмжийг 2516 хүнд өгсөн байна. Зайлшгүй шаардлагатай эмийн 8-р жагсаалт дахь зохих эмийн хангамж эм ханган нийлүүлэх байгууллагуудад дунджаар 89 хувьтай болж өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна.	97.4%
10		Эмнэл зүйн эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалд	2021-2024	ЭМГ	Эм ханган нийлүүлэх	Улс болон орон нутгийн төсөв	-	Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээ	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.	-	-	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 115 эм зүйч, 121 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 2.6 хувь, эм найруулагч 4.8 хувиар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 4 клиник эм	82.1%

		тохируулан нэвтрүүлэх			байгуу лага Эмийн сан Эм холбо о			2 эмнэл зүйн эм зүйч ажиллуул ах				зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 9 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5%-иар нэмэгдсэн байна. Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 52.5-62 хувьд тарилгыг хийж, 39-46.5 хувьд уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 5.5 хувиар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 2.6-3.8 хувиар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилт 83.5 хувь болж 0.9 хувиар нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээ алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар буурсан байна. Эмнэлзүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 82.1 хувьтай байна.	
11	1.2.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, үйлчлүүлэгчийг нэг дороос бүх төрлийн тусламжийг авах нөхцөлийг бүрдүүлсэн төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлнэ.	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	ХХЭМ Б	Орон нутгийн төсөв	92.0	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо 1	Гэрээт үйлчилгээг 1-ээр нэмэгдүүлсэн байна.	25.0	Орон нутгийн төсөв 30.0	Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиниктэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 102605 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 13.9 хувийг, 18753 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 49.1 хувийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиникүүд оролцож 16-49 насны 1895 эмэгтэйг үзлэгт хамруулан 354 буюу 77.5 хувийг бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 457 эмэгтэйг илгээсэн байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх 90 хувьтай байна. Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулахаар орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэн, сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулан эрүүлжүүлсэн.	90%

12		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг дэмжих	2021-2024	Хувийн хэвшлийн байгууллагууд	Аймгийн ЗДТГ ЭМГ	Олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв Төр, Хувийн хэвшлийн түншлэл	-	Төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлж буй байгууллага-2	Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн хүний нөөцийн чадавхыг сайжруулах.	-	-	Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал, Баян-Өндөр мед эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн ортой клиникүүд төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан ба хүний нөөцийн хангалт 90 хувьтай байна. Хувийн хэвшлийн ор бүхий 8 клиник амбулатори, 105 оронд өдрийн эмчилгээ хийж үйлчилсэн. Сум, 8 өрхийн эрүүл мэндийн төвүүд өдрийн эмчилгээний гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт авч байгаа нь дотор, мэдрэлийн чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэх ачааллыг бууруулж ажилласан. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын оношилгооны чадавх 90 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар нэмэгдсэн. Хүн амд дотор, мэдрэлийн тусламж үйлчилгээ эрэлттэй байгаа ба үйлчлэх хүрээний хүн ам, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, зорилтот бүлгийн хүн амын тоог нарийвчлан гаргаж, тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг тооцсон. Тайлант хугацаанд Ачит клиникт уламжлалтын тусламж үйлчилгээ, шинээр 3 эмийн сан, хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээ 1, нүүр ам, судлалын тусламж үйлчилгээ 1, бэлгийн замаар дамжих халдвар, эмэгтэйчүүд, арьсны хавсарсан тусламж үйлчилгээний 1 клиникт 5 жилээр тусгай зөвшөөрлийг олгосон байна.	100%
13	1.2.4.Хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эх, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг бууруулна.	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМГ	БОЭТ ХХЭМБ		Улс болон орон нутгийн төсөв Олон улсын төсөл хөтөлбөр	47.0	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулсан хувь 10%	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт 18 хувийг хамруулсан байна.	12.0	Орон нутгийн төсөв 20.0	“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуурын хэрэгжилт 88.5 хувьтай байна. Тайлант хугацаанд: - Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 2 албан тоот, 1 албан даалгавар, 4 мэдээллийг хүргүүлэн хяналт хийн зөвлөмж өгсөн. - Томуу, томуу төст өвчний алаг цоог дэгдэлтийн үед 150-200 ор нэмэлтээр дэлгэж, гэрийн эргэлт, уртасгасан цагийн зохицуулалтаар өрхийн 75 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулан тусламж үйлчилгээний ачаалал, чирэгдлийг бууруулсан. - Сум, өрхийн эрүүл мэндийн төв, БОЭТ-ийн эх хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний стандарт, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн хангалт, чанар хүртээмжид үнэлгээ хийн зөвлөмжөөр хангасан.	83.9%

										- Эрт илрүүлэг үзлэгт 0-17 насны хүүхдийн 69 хувь нь хамрагдаад байна. - ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭМГ-аас зохион байгуулсан сургалтаар давхардсан тоогоор нийт 305 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. - Хүүхдийн эрхийг хамгаалах хороо 2 удаагийн хурлаар эрх нь зөрчигдсөн 2 кейсийг хэлэлцэж, СЭМҮТ-д өсвөр насны 1 хүүхдийг илгээн түр хамгаалах байранд 2 хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлсэн. - Жирэмсний эрт үеийн хяналт 98.5 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.1 хувиар нэмэгдсэн. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хангалт 75.8 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар нэмэгдсэн. - Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт 16-49 насны 1895 эмэгтэй буюу 94.7 хувийг хамруулан өвчлөлтэй илэрсэн 354 буюу 77.5 хувийг бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 457 эмэгтэйг илгээсэн байна. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2446 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 88.3 хувийг эзэлж байна. - Аймгийн хэмжээнд нийт 25684 нөхөн үржихүйн насны эмэгтэй байдаг ба тайлант хугацаанд өсвөр үе болон нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдийн 15.1 хувь нь үзлэгт хамрагдсан байна.			
14		Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт аминдэмд хамруулах	2021-2024	ЭМГ	БОЭТ СӨЭМ Т	Улсын төсөв Орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр	23.0	Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн хөхүүл эхийг аминдэмээр хангасан хувь 10%	Нийгмийн халамж шаардлагатай жирэмсэн хөхүүл эхчүүдийн 15%-ийг аминдэмээр хангасан байна.	6.0	Орон нутгийн төсөв 10.0	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны А/195 дугаар захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20100 ширхэг аминдэмийг хуваарилан 689 эхийг 100% амин дэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 689 эхээс цус багадалттай 264 эх байгаа нь 38.3 хувийг, нийгмийн халамж дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн 128 эх, эх барихын ужиг дутагдалтай 297 эхийг аминдэмжүүлж, эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Эхийн аминдэмийн төсөв өмнөх онтой харьцуулахад 42 хувиар, аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.4 дахин нэмэгдсэн.	100%

15		Нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2021-2024	ЭМГ БОЭТ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	176.0	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийн хувь 33.5%	Нярайн эндэгдэлд эзлэх амьсгал хямралын хам шинжийг 27.5% болгож бууруулна.	44.0	ЭМД-аас гүйцэтгэлийн санхүүжилт ээр 12.0	Орон нутагт нярайн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи сурфактант эмчилгээг 2015 оноос эхлэн нэвтрүүлж 2021 онд 12 нярайд сурфактант эмчилгээг хийж 59 хувийн үр дүн, 2022 онд 15 нярайд сурфактант эмчилгээг хийж 86.6 хувийн үр дүн өгсөн. Тайлант хугацаанд: - Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 16 нярайд хийж 70 хувийн үр дүн өгсөн байна. - Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг төрсөн 2234 нярайд 100 хувь үзүүлсэн. - Нярайн тандалт скрининг шинжилгээнд төрсөн нярай бүрийг 100% хамруулж байгаа бөгөөд дутуу нярайн нүдний эвэрлэгийн эмгэг судасжилт илрүүлэх шинжилгээг 67 дутуу нярайд хийснээс 4 нярайг лавлагаа шатлалд илгээсэн. Мөн 1810 нярайн сонсгол шалгаж, 16 нярайд давтан үзлэг хийж, чих хамар хоолойн эмчид 2 нярайг илгээсэн. Нярайн төрөлхийн анхдагч гипотиреоз өвчнийг илрүүлэх шинжилгээг нийт 1004 нярайд хийж, сорьцыг ЭХЭМҮТ-д илгээсэн. Тайлант хугацаанд нялхсын эндэгдэлд эзлэх нярайн эндэгдэл 66.6 хувь байгаагаас амьсгал хямралын хам шинжийн шалтгаант эндэгдэл 2 бүртгэгдсэн нь нийт нярайн эндэгдлийн 16.6 хувийг эзэлж байна.	100%
16	1.2.5.Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт,	БОЭТ-ийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	2021-2024	Аймгийн ЗДТГ БОЭТ	ЭМГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	2.100.0	БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 75%	Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	1.000.0	Улсын төсөв 602.0 Орон нутгийн төсөв 210.0	2021 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 90%, 2022 онд 92%, 2023 онд 92.5 хувьтай байна. Тайлант хугацаанд орон нутгийн 210.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвд зүрхэн дотор цахилгаан сэдэл өгөх аппарат, зүрхний холтер зэрэг аппаратууд нийлүүлэгдэн тусламж үйлчилгээнд ашиглагдаж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 602.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	100%

17	чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	БОЭТ-ийн барилга их засвар, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ БОЭТ	ЭМГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	1.000.0	БОЭТ-ийн барилга их засвар	Лаборатори, амбулаторийн их засвар.	350.0	ЭМД-аас гүйцэтгэлийн санхүүжилт ээр төсөв 647.6 Орон нутгийн төсөв 20.0	2021 онд эрүүл мэндийн салбарын байгууллагуудад 2.1 тэрбум төгрөгийн барилга, засварын ажил, 2022 онд 335.0 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн. 2023 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн өргөтгөлийн барилгын зураг төсөвт орон нутгаас 20.0 сая төгрөг батлагдаж зураг бүрэн зурагдсан. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь лабораторийн тасгийн засварыг 274.8 сая төгрөг, амбулаторийн 3, 4-р давхрын засварыг 372.8 сая төгрөгийн байгууллагын санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ.	100%
18		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай лабораторийн болон бусад тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ	Жаргалант сумын ӨЭМТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	1.500.0	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 85%	2 өрхийн эрүүл мэндийн төв, сумын ЭМТ-ийн лабораторийн чадавхыг сайжруулах	240.0	Улсын төсөв 5.1 ЭМД-аас гүйцэтгэлийн санхүүжилт ээр 29.0	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2021-2022 онд дунджаар 93.5%, 2023 онд тоног төхөөрөмжийн хангалт 96% болж өмнөх оноос 2.5 хувиар нэмэгдсэн байна. Тайлант онд нийт 34.1 сая төгрөгийг зарцуулж 8 Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд билиметр 4 ширхэг, хүчилтөрөгчийн аппарат 2, танита аппарат 1, ус нэрэх аппарат 1 ширхэг, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн 5.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар автоклав, ус нэрэгч, дижитал дэлгэцтэй электрон жин олгон ашиглаж байна. Одоогийн байдлаар Өрхийн эрүүл мэндийн төвүүд цусны дэлгэрэнгүй шинжилгээний анализатор, биохимийн аппарат, шээсний шинжилгээний аппарат, центрифугээр 100% хангагдсан. Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 17, дефибриллятор 9, билиметр 9 байна.	100%
19		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болгож ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	2021, 2023	Аймгийн ЗДТГ ЭМГ Жаргалант сумын ЗДТГ	Жаргалант сумын ӨЭМТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр Орон нутгийн төсөв	2.150.0	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн Сум, өрхийн эрүүл мэндийн төв-7	Жаргалант сумын ЭМТ-ийн засвар	100.0	Орон нутгийн төсөв 20.0	Өрхийн 8 эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байртай болгосноор ажиллах орчин нөхцөл 100 хувь сайжирсан. Жаргалант сумын Эрүүл мэндийн төвд Жаргалант сумын төсвөөс 20.0 сая төгрөг шийдвэрлэн стандартын дагуу болгож засварлах урсгал засвар хийгдсэн. Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээр шинээр баригдаж буй Зэст багийн нэгдсэн байрны 2 дугаар давхрыг өрхийн эрүүл мэндийн төвийн зориулалт, стандартын дагуу засварлах шаардлагатай төсвийг төсвийн нэмэлт тодотголд оруулах саналыг хүргүүлсэн. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж 100% стандартын шаардлага хангасан. 2021 онд Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга 500.0 сая, Энхжихмандариваа өрхийн эрүүл мэндийн төвийн барилга 1.2 тэрбум, Мөнхийн Гэгээ өрхийн эрүүл	100%

												мэндийн төвийн гадна фасадны их засварын ажлууд хийгдсэн. 2022 онд Цагаанчулуут багийн Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төвийн газрын асуудлыг шийдвэрлүүлсэн.	
20	1.3.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	19.0	Хариу арга хэмжээний чадавх 75%	Аймгийн хэмжээнд чадавхжуулах дадлага сургуулилтыг зохион байгуулах.	5.5	Орон нутгийн төсөв 25.0	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 2021 онд 85%, 2022 онд 90%, 2023 онд 95% болж өмнөх оноос 5%-аар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавх нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хариуцсан 40 мэргэжилтэн бэлтгэгдэж, эрүүл мэндийн 3 байгууллагад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандарт эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO31000:2018 стандарт нэвтрэн, томуу, томуу төст өвчний дэгдэлтийг хүндрэл бэрхшээлгүй даван туулсан. ХӨСҮТ-д нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээ хийх төвийн сургалтад ЭМГ-аас 2 мэргэжилтнийг хамруулж чадавхжуулсан. ОБЕГ-аас зохион байгуулсан Стратеги команд штабын сургуулилтад эрүүл мэндийн албаны 15 гишүүн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэргэжлийн ангийн 55 бие бүрэлдэхүүн оролцож, 2 удаагийн жагсаалын бэлтгэл хийн, Онцгой байдлын газраас өгөгдсөн 7 удаагийн цагийн байдалд хариу арга хэмжээ авч ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 95% байна.	100%
21		Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	60.0	Нөөц бүрдүүлэлт 50%	Эрүүл мэндийн байгууллагын удын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна.	20.0	Улсын төсөв 19.0 Орон нутгийн төсөв 30.0	Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт 2021 онд 75-80%, 2022 онд 90%, 2023 онд 95 хувьтай болж нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд: - Эрүүл мэндийн яамнаас нийт 3 удаагийн татан авалтаар 9 нэр төрлийн 19.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгслийн хангалтыг хийж нөөцийг нэмэгдүүлсэн. - ЭМГ-ын гамшгийн нөөцөөс 8 нэр төрлийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, эм, эмнэлгийн хэрэгслийг сумын болон өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв. Эрдэнэт Медикал төрөлжсөн	100%

											төв эмнэлэгт хүлээлгэн өгч, нөөцийг нэмэгдүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 95%-тай байна.		
22	1.4.Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах үйлчилгээг нэвтрүүлнэ.	Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо, телемедицинний техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	2021-2024	Аймгийн ЗДТГ ЭМГ БОЭТ	Эрүүл мэндийн байгууллагууд Олон улсын байгууллагууд	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Зайн оношилгоо о-2 чиглэлээр хэрэгжиж байна. Алсын зайн оношилгоо, телемедицинний техник тоног төхөөрөмжийн хангалт 17%	Цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгооны төрлийг нэмэгдүүлэх	-	-	Алсын зайн оношилгоо, телемедицинний техник тоног төхөөрөмжийн хангалт 2021-2022 онд 33 хувьд хүрч, суурь үзүүлэлтээс 16 хувиар нэмэгдсэн. Тайлант хугацаанд телемедицинний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: - БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуультай хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар тус их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төвийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинээр байгуулагдан 18 өвчтөнд телемедицинээр зөвлөгөө авсан. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн. - Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулахаар туршилтын хурлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд 22 өвчтөний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж лавлагаа шатлалын эмнэлгүүдээс оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан байна.	100%
23		Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерыг үе шаттайгаар шинэчлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ БОЭТ	Улсын төсөв олон улсын төсөл хөтөлбөр	-	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 10%-д компьютерыг шинэчлэл хийгдсэн.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 70%-д компьютерыг шинэчилсэн байна.	-	Орон нутгийн төсөв 174.6	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 2021-2022 онд 90%, 2023 онд 95%-тай болж 5%-аар нэмэгдсэн. - Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн 8 төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвүүд нь 2 mb/ps хурдтай интернетэд холбогдсон. - “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20 ширхэг таблет олгосон. Сум, өрх эрүүл мэндийн төвүүдэд 126 компьютер ашиглагдаж байгаа ба тайлант хугацаанд 60 компьютерыг шинэчлэх болон, ssd hard тавьж хурдыг сайжруулсан.	100%

24	1.5.Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэн тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих, “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	520.0	Эмч хөтөлбөрийн хэрэгжилт 95.3%	Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийгдэх	150.0	Орон нутгийн төсөв 175.0	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр аймгийн ИТХ-ын 2021 оны 08-р тогтоолоор “Эмч” хөтөлбөрийг батлуулж, 2021-2022 онуудад нийт 250.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдан 818 эрүүл мэндийн ажилтан сургалт болон эрүүл мэндийн чиглэлээр дэмжлэгт хамрагдсан байна. 2023 оны “Эмч” хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 175.0 сая төгрөгийн төсвийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд: - Төгсөлтийн дараах сургалтад 112, ажлын байран дахь сургалтад 2221 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. - “UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж нийт 35 эмч оролцлоо. - Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж нийт 30 илтгэл хэлэлцүүлэв. - Өндөр хөгжилтэй оронд нийт 60 эмч, мэргэжилтэн суралцаж, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр нийт 47 удаагийн соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 2257 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна. Тайлант хугацаанд 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн. - Эрүүл мэндийн салбарын 40 наснаас дээш нийт 400 ажилтныг бамбай булчирхайн дааврын шинжилгээнд хамруулан 49 ажилтан өөрчлөлттэй гарсныг эмчлэн, эрүүлжүүлж байна. - Эрүүл мэндийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулагдсан 4 төрөлт спортын наадамд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын баг тамирчид амжилттай оролцон 2-р байр эзэллээ. Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 13.1, нийгмийн дэмжлэгт хамрагдалсан хувь 24.4 -тэй болсон ба тус хөтөлбөрийн хэрэгжилт 97.5%-тай байна.	97.5%
25		Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн чадавхыг	2021-2024	ЭМГ	Аймгийн ЗДТГ	Улсын болон орон	-	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдс	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан	-	-	2021-2022 онд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад 26 эмч, 14 сувилагч, тусгай	93.6%

		сайжруулж нэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттай сургах				нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөр		ан хувь 12.5%	хувь 14%-д хүргэсэн байна.			мэргэжилтэн, мэргэжил олгох сургалтад 10 сувилагч тус тус суралцсан. 2022-2023 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 112 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байгаагаас төрийн сангийн санхүүжилтээр 18.1% нь суралцсан. Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт эмч, мэргэжилтний 81 хувийг эзэлж байна. Төвийн болон орон нутагт зохион байгуулсан ажлын байранд дадлагажуулах 10 удаагийн сургалтад 185 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт томуу томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой өрхийн эрүүл мэндийн төвийн давхардсан тоогоор нийт 75 эмчийг ажлын байранд сэлгэн ажиллуулсан. Өндөр хөгжилтэй оронд нийт 60 эмч, мэргэжилтэн суралцаж, мэдлэг, чадвараа дээшлүүлснээс 54 эмч “Эмч” хөтөлбөрөөс дэмжлэг авсан байна. Тайлант хугацаанд нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 74.9% нь ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдсан байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар 2 резидент эмч, эрчимт эмчилгээний сувилахуй”, Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 6 сувилагч суралцаж байна. Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 13.1 хувь нь хамрагдсан байна.	
БИЕИЙН ТАМИР, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТ													
26	1.6.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн	Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубын тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	ЭМД-ын сан	-	Магадлан итгэмжлэгдсэн клубын тоо 3	Магадлан итгэмжлэгдсэн клубын тоо 4	-	-	Аймгийн хэмжээнд 2021 онд 13 фитнес клубт 1650 иргэн, 2022 онд 14 фитнес клуб 1800 иргэн тогтмол хичээллэдэг байсан. Тайлант онд үйл ажиллагаа хэвийн явагдаж буй фитнес клуб 14, хичээллэгсдийн тоог өмнөх оноос 100-аар нэмэгдүүлж, 1900 иргэн тогтмол хичээллэж байна. Эдгээр фитнес клубуудээс 3 клуб нь магадлан итгэмжлэгдэн ажиллаж байсан ч магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан тул дахин итгэмжлэлийг сунгуулахаар Биеийн тамир, спортын улсын хороонд хүсэлтээ хүргүүлээд байна.	75%

27	спорт, баг тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ.	Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл материалаар хангах	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Тамирчдын тоо 140	Тамирчдын тоо 182	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 75.0 Улсын төсөв 32.9 Хувийн хэвшил 10.0	Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортыг төрлүүдийг жил бүр 1, тамирчдын тоог 14-өөр тус тус нэмэгдүүлж 2022 онд 15 төрөлд 168 тамирчин хичээллэж байсан. Тайлант онд сагсан бөмбөгийн 3х3, 5х5 төрөлд 28 хүүхэд, байт харваа 5, гимнастик 8, цана 16, хөлбөмбөг 20, бадминтон 5, бокс 10, буудлага 8, таеквондо 10, ширээний теннис 4, самбо, жүдо 18, чөлөөт бөх 12, волейбол 20, шатар 2, хөнгөн атлетик 16 тамирчин тус тус хичээллэж нийт спортын 16 төрөлд 182 тамирчин бэлтгэл сургуулилтаа тогтмол хийж байна. Шигшээ багийн тамирчдын ур чадварыг сайжруулах зорилгоор өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 17 төрлөөр зохион байгуулж, нийт 2764 сурагчид хамрагдсан. Өсвөрийн улс, бүс, аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах, оролцоход нийт 135.8 сая төгрөг зарцуулагдсан. Үүнээс: Орон нутгийн төсвөөс 92.9 сая төгрөг, улсын төсвөөс 32.9 сая төгрөг, ивээн тэтгэгч байгууллагаас 10.0 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн. Тайлант онд өсвөрийн шигшээ багийн тамирчид "Монголын хүүхдийн спортын VII их наадам", улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 142 медаль хүртсэнээс алт 43, мөнгө 43, хүрэл 56 авсан амжилтыг үзүүлсэн. 2023 онд өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж буй гадаад улсын буцалтгүй тусламжаар гүйлтийн цана 20 ширхэгийг хүлээн авч, цанын өсвөрийн шигшээ багийг хэрэглэл материалаар хангасан.	100%
28		Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв, Спортын холбоод болон ААНБ-ын хандив	Батлагдсан төсвийн хүрээнд	Зохион байгуулсан тэмцээний тоо 2	Зохион байгуулсан тэмцээний тоо 4	Батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсөв 275.0 Орон нутгийн төсөв 152.4	Орон нутагтаа улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг зохион байгуулах ажлын хүрээнд 2021 онд улсын аварга шалгаруулах тэмцээн 2 удаа, 2022 онд улсын аварга шалгаруулах тэмцээн 5 удаа, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 удаа тус тус зохион байгуулж 3142 тамирчин хамруулж, орон нутгийн төсвөөс 160 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд улсын аварга шалгаруулах тэмцээн 7, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 2 удаа тус тус зохион байгуулж ажилласан нь өмнөх оноос улсын аварга шалгаруулах тэмцээнийг 3-аар, оролцсон тамирчдын тоог 498-аар нэмэгдүүлж, 3640 тамирчдыг хамруулан зохион байгуулсан. Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион	100%

											байгуулахад улсын төсвөөс 275.0, орон нутгийн төсвөөс 152.4 сая төгрөг нийт 427.4 сая төгрөгийг зарцуулж, Орхон аймагт 1300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлсэн. Улсын аварга шалгаруулах тэмцээнээс дурьдвал: - Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг тус тус аймагтаа амжилттай зохион байгуулсан. Тус наадмуудад 13 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. -Байт харвааны заалны улсын аварга шалгаруулах 15 дахь удаагийн тэмцээнд 24 аймаг, дүүрэг, клуб оролцсон. Тэмцээнд 2 төрөлд нийт 307 тамирчин 57 багц медалийн төлөө өрсөлдсөн. -2023 онд хэрэглэлтэй Пауэрлифтингийн 17 дахь удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 30 аймаг, дүүрэг, клуб оролцсон. Тэмцээнд өсвөр, насанд хүрэгчдийн ангилалд нийт 230 тамирчин 148 багц медалийн төлөө өрсөлдсөн. -Авто спортын "SPRINT RALLY" улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 ангилалд 45 тамирчин оролцлоо. -Монгол улсын Усанд сэлэлтийн 32 дахь удаагийн өсвөр, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 27 клубын 378 тамирчид, -Хэт бартаат замын улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 төрөлд 33 багийн 71 тамирчин тус тус хамрагдсан.		
29		Үндэсний болон багийн спортын төрлүүдээр иргэдийн спортын их наадмыг шат дараатай зохион байгуулж, төрлүүдийн тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Спортын 5 төрөл	Спортын 8 төрөл	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 20.0	Үндэсний болон багийн спортын төрлүүдээр "Иргэдийн спортын наадам"-ыг 2021 онд спортын 3 төрлөөр (сагсан бөмбөг, волейбол, олс таталт) зохион байгуулж, 900 иргэн хамруулсан бол 2022 онд спортын 6 төрлөөр зохион байгуулж 897 иргэнийг хамруулж, 12.8 сая төгрөг зарцуулсан. 2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран "Иргэдийн спортын наадам"-ыг үндэсний болон багийн спортын 8 төрлөөр зохион байгуулж сагсан бөмбөгийн төрөлд 308, волейболын төрөлд 384, олс таталтын төрөлд 184, ширээний теннисний төрөлд 46, үндэсний бөхийн төрөлд 69, буудлагын төрөлд 92, дартсын төрөлд 46, Мас-рестлинг /Модон барилдаан/-ны төрөлд 32 иргэн тус тус оролцож нийт 1143 иргэн хамрагдсан. Тэмцээний үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулсан.	100%

30		Спортын хэрэгслийн (ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр) түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих	2021-2024	НБХ	БТСГ ХЗА	Орон нутгийн төсөв	-	-	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдсэн байна.	-	-	2021 онд 2 байршилд 2 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан боловч Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа явагдаагүй. 2022 онд 4 байршилд 3 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 6700 гаруй хүүхэд залууст хүргэж ажилласан. Тайлант онд 6 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, цахилгаан дугуй /скүүтер/, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 7200 гаруй хүүхэд залууст хүргэж ажиллалаа. Үүнд: -"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Сархиа цанын баазад чарга, уулын цана, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 2000 иргэн, - 19-р сургууль /орос сургууль/ дахь мөсөн талбайн тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 500 иргэн, -А.Амарын талбай, "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн", "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн"-д ердийн болон гэр бүлийн дугуйн түрээсийн үйлчилгээнд нийт 3200 иргэн, -Хот доторх авто замд "Erdenet jet" ХХК-аас 230 ширхэг цахилгаан дугуй/скүүтер/-аар түрээсийн үйлчилгээг нэвтрүүлж өдөрт дунджаар 40-50 иргэнд, сард 1200-1500 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлсэн.	100%
31	1.7.Хүн амын зорилтот бүлгүүд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.	Ахмадуудад спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хичээллэгсдийн тоо 750	Хичээллэгсдийн тоо 900	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Аймгийн ахмадууд софт волейбол, шатар, хөл бөмбөг, волейбол, граунд гольф, дартс, ширээний теннис, бадминтон, хөнгөн атлетикийн төрлүүдээр Биеийн тамир спортын газрын А, Б заал, Баян-Өндөр сумын спорт заал, аймгийн ЗДТГ-ын спорт заал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Спорт цогцолборын заалуудад үнэ төлбөргүй 7 хоногт 2 цагаар хичээллэдэг. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүд, аймгийн ахмадын хорооны чийрэгжүүлэлтийн танхимд хийн дасгалаар тогтмол 472 ахмад хичээллэж байна. 2021 онд 1 удаагийн тэмцээн, 2022 онд спортын 9 төрлөөр 12 удаагийн арга хэмжээг зохион байгуулж нийт 850 ахмад хамрагдсан бол 2023 онд 10 төрөлд 15 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 1089 ахмадыг хамрууллаа. Аймгийн хэмжээнд 6 спортын зааланд 1000 гаруй ахмадыг үнэ төлбөргүйгээр хичээллүүлж байна.	100%

32		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулах уралдаан тэмцээний төрлийг нэмэгдүүлэх	2021-2024	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хичээллэгсдийн тоо 250	Хичээллэгсдийн тоо 350	Батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсөв 2.7 Орон нутгийн төсөв 10.0	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд биеийн тамир, спортын газрын А, Б зааланд долоо хоногт 2 удаа үнэ төлбөргүйгээр хичээллэдэг бөгөөд 2021 онд спортын 3 төрлөөр 3 удаа тэмцээн зохион байгуулж 112 иргэн, 2022 онд спортын 9 төрлөөр 12 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 509 иргэдийг хамруулж байсан бол <i>тайлант онд</i> пара хөнгөн атлетик, 3х3 сагсан бөмбөг, буухиа, дартс, ширээний дуут бөмбөг, волейбол, хонхот бөмбөг, суугаа волейбол, бочи зэрэг 9 төрлөөр 360 иргэн тогтмол хичээллэж байна. Тамирчдын оролцсон 11 удаагийн томоохон уралдаан тэмцээнээс дурдвал: -Хонхот бөмбөгийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй, эмэгтэй төрөлд 8 тамирчин оролцож тусгай байр, -Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын хонхот бөмбөгийн төрөлд эрэгтэй ангилалд 4 тамирчин алтан медаль, пара хөнгөн атлетикийн төрөлд 1 алт, 1 хүрэл медаль, -Бочигийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 60 тамирчин оролцож багийн дүнгээр 2 дугаар байр эзэлж тус тус оролцсон.	100%
33	1.8.Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн өрнүүлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж, спортын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аяныг аймгийн иргэд болон ААНБ-уудын дунд өрнүүлэх	2021-2024	БТСГ БШУГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хамрагдах иргэдийн тоо 8000	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 10.0	"Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аянд 2021 онд 15954, 2022 онд 44856 иргэн тус тус хамрагдсан. 2023 онд аяны хүрээнд "Нэг анги-Нэг өглөө" өглөөний дасгалын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын 11 сургуулийн 12632 сурагч, 2597 эцэг эх давхардсан тоогоор нийт 15229 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан байна. Мөн БТСГ-ын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж 8 сургуулийн 506 сурагч, спортын холбоодын багш, дасгалжуулагчид, өсвөрийн шигшээ багийн тамирчид зэрэг 254 иргэнийг хамруулсан. Аяны хүрээнд төрийн албан хаагчдын дунд ажлын байрны дасгалын уралдааныг зохион байгуулж 750 гаруй албан хаагчид хамрагдсан. Ингэснээр иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, дасгал хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл амьдралын дадлыг олгох нөхцөл бүрдсэн.	100%
34		Биеийн тамир, спортоор хичээллэх заал	2021-2024	Аймгийн ЗДТГ	БТСГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	33	Жил бүр 1 талбай нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 1200.0	2021 онд Жаргалант сумын ЗДТГ-ын спорт заал, 2022 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Энэрэл төв"-ийн спорт заал тус тус ашиглалтад орсон. 2023 онд шинээр орон нутгийн төсвийн	100%

		талбайг нэмэгдүүлэх		ын НБХ			хүрээ нд					хөрөнгө оруулалтаар Үйлдвэрчний эвлэлийн хорооны спорт заал ашиглалтад орсноор аймгийн хэмжээнд төрийн өмчит байгууллагууд болон хувийн хэвшил, ерөнхий боловсролын сургуулиудад нийт 35 спорт заал ашиглагдаж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 3, 16-р сургуулийн спорт заал, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Сансар худалдааны төвийн хажуу талд спорт заал бүхий цогцолбор тус тус баригдаж байна. Шинээр баригдаж буй спорт заалнууд ашиглалтад орсноор аймгийн 1 хүнд ногдох спорт заалны хүртээмжийн индекс 2022 онд 0.13м ² байсан бол 2023 онд 0.15м ² болж өмнөх оноос 0.02м ² –аар нэмэгдсэн.	
35	1.9.Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, боловсон хүчин болон материаллаг баазаар ханган хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.	Өвлийн спортын дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2023	БТСГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хэрэгжилтийн хувь 10%	Хэрэгжилтийн хувь 100%	Батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсөв 275.0 Орон нутгийн төсөв 284.0 Хандив тусламж 20.0	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн биелэлт 2021 онд 76 хувь, 2022 онд 86.5 хувь, 2023 онд 92.5 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд спортын 7 төрлөөр 10 удаагийн нээлттэй тэмцээнийг зохион байгуулж 560 гаруй иргэнийг хамруулсан. Тамирчид тив, улс, бүсийн аварга шалгаруулах 32 тэмцээнд оролцож 280 медаль авсан амжилтыг үзүүлсэн. Мөн биатлоны Монгол улсын шигшээ багт 5, хоккейн улсын шигшээ багт 14 тамирчин шалгаран тус тус бэлтгэл сургуулилтаа хийж байна. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэхэд орон нутгийн төсвийн 220.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цана 17 ширхэг, тэшүүр 14 ширхэг, цас буудагч буу, цасны мотоцикль, усны шланг зэргийг авсан. Швейцарын холбооны улс, Бүгд найрамдах Франц улсын өвлийн спортын үндэсний төвүүдтэй хамтран ажиллаж 200ш хоккейн тэшүүр, 13 цана хандиваар авч цана, тэшүүрийн тамирчдыг бэлтгэл сургуулилтаа хийхэд хэрэглэл материалаар ханган ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд шинээр 2 мөсөн талбай байгуулж өвлийн спортын мөсний сур харваа, мөсөн шагай, тэшүүр, шорт трекийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр хичээллэгсдийн тоо 600-аар, тамирчдын тоо 342-оор тус тус нэмэгдэж нийт 2532 иргэн хичээллэдэг болсон. 2023 онд орон нутагтаа анх удаа Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII	92.5%

											наадмыг нэгэн зэрэг өндөр түвшинд зохион байгуулж 12 аймаг, 7 дүүргээс 700 гаруй дасгалжуулагч, тамирчид, зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж зочид буудал, хоол үйлдвэрлэл, бэлэг дурсгал, хэвлэл мэдээлэл, бусад үйлчилгээний байгууллагуудаас Орхон аймагт нийт 1.0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн байна. Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Орхон аймаг багийн дүнгээр 2-р байрт шалгарсан.		
36		“Эрдэнэт-Спорт амралтын хүрээлэн” болон ЕБС-иудын гаднах талбайд өвлийн спортоор хичээллэх орчин бүрдүүлэх	2021-2024	БТСГ БШУГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Мөсөн талбайн тоо 3	Жил бүр 1 талбай нэмэгдсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 15.0	2021 онд мөсөн талбай 2, цанын зам 1, 2022 онд мөсөн талбай 3, цанын зам 1 -ийг тус тус байгуулсан. 2023 онд 7 зам талбай байгуулж спортын 8 төрлөөр /биатлон, гүйлтийн цана, уулын цана, снөүбоард, гүйлтийн тэшүүр, шорт трек, хоккей, мөсний сур харваа, мөсөн шагай/ 532 тамирчин хичээллэж, бэлтгэл сургуулалт хийх, тэмцээн уралдаан зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан нь өмнөх онтой харьцуулбал цана, тэшүүрийн зам талбайг 3-аар нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна. -"Эрдэнэт спорт, амралтын хүрээлэн"-д гүйлтийн тэшүүр 400м мөсөн талбай, -"Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д шорт трекийн зам талбай, -Сархиа цанын баазад гүйлтийн цана, уулын цана, снөүбоардын 3 зам, -Сархиа цанын баазын мөсөн талбай, -19-р сургуулийн хоккейн талбайд цана, чарга, тэшүүрийн түрээсийн үйлчилгээг явуулж 2000 орчим иргэнийг хамруулсан.	100%
ХОЁР.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН БОДЛОГО													
	ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД, АХМАД НАСТАН												
37	2.1.1.Гэр бүлд суурилсан салбар дундын уялдаа холбоог сайжруулан идэвхэжсэн хандлага оролцоог дэмжинэ.	Зорилтот гэр бүлд чиглэсэн ажил, үйлчилгээг сайжруулах	2021-2024	ГБХЗ ХГ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв	60.0	Зорилтот гэр бүлийн 10%	Зорилтот гэр бүлийн 25%	15.0	Орон нутгийн төсөв 40.0	2021 онд зорилтот бүлгийн өрхийн 14.2%, 2022 онд 8.6%-д үйлчилгээ үзүүлж ажилласан бол тайлант онд бүртгэлтэй 952 өрхийг “Халамжаас хөдөлмөрт” хөтөлбөрт хамруулж зорилтот өрхийн тоо 47.6 хувиар буурсан байна. 2023 онд нийт 66 өрхөд хүнсний тусламж үзүүлж, сургалт нөлөөллийн ажилд 20 өрхийг хамруулсан. Гэр бүл цуцлалтын шалтгааныг судалсан судалгаанд хамрагдагсдын 44.3% нь гэр бүлийн зан харилцаа таарахгүй шалтгаан байснаас үндэслэн Орхон аймаг дахь Шүүхийн Тамгын газартай хамтран "Гэр төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд гэрлэгчдэд сэтгэл зүйн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, үүлзалт хийх, гэр	100%

												бүлийн хөгжил боловсрол, тогтвортой байдлыг дэмжиж сургалт, зөвлөгөөг явуулах, гэр бүл цуцлалтын тоог бууруулах чиглэлээр ажилласны үр дүнд шүүхийн шатнаас 32 гэр бүлийг эвлэрүүлсэн үр дүн гарсан. Мөн гэр бүлийг дэмжих, хөгжүүлэх, хамгаалах, чадавхжуулах, хямралыг даван туулахад нь туслах, холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх чиглэлээр “Алхам алхмаар” хөтөлбөр хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн 20 иргэнийг архины донтох эмгэгээс ангижруулах эмчилгээ, үйлчилгээнд хамруулж байна. Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр аймгийн хэмжээний нийт 8405 зорилтот өрхийн 2353 нь буюу 28 хувь нь гэр бүлд чиглэсэн арга хэмжээнд хамрагдсан байна.	
38		Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Улсын төсөв	20.0	Нийт өрхийн 15%	Нийт өрхийн 30%	5.0	Улсын төсөв 3.0 Орон нутгийн төсөв 30.0	2021 онд гэр бүлийн боловсрол олгох, сургалт нөлөөллийн ажлыг 9 сэдвийн хүрээнд 23 удаагийн сургалтад 5800 өрх буюу аймгийн нийт өрхийн 19%-ийг хамруулж, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн 1 телевизтэй хамтран хуулийн цаг 5 удаагийн нэвтрүүлгийг олон нийтэд хүргэсэн. 2022 онд хамтарсан багуудаар дамжуулан 56 удаагийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээнд нийт 2607 иргэд хамрагдсан. Дэлхийн гэр бүлийн өдрөөр Гэр бүлийн өдөрлөг, Гэр бүлийн чуулган, Онол практикийн бага хурал, гэр бүлийн гишүүдийг оролцуулсан уралдаан тэмцээн зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж, 8539 гэр бүлийг оролцуулан, аймгийн нийт өрхийн 30.0%-ийг хамруулсан. Тайлант онд "Бүх хайраа гэр бүлдээ" уриан дор өдөрлөг, сургалт, нэвтрүүлэг зэрэг олон талт арга хэмжээг 2 сарын хугацаанд зохион байгуулсан. "Гэр төсөл"-ийн хүрээнд шийдвэр гүйцэтгэх газарт 7-30 хоногийн баривчилгаанд байгаа иргэдэд зориулсан хувь хүний сэтгэл зүйн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 7 хоног бүр тогтмол явуулж 528 иргэн хамрагдсан байна. Гэр бүлийн чиглэлээрх сургалт нөлөөллийн ажил өнгөрсөн оноос 13 буюу 23%-иар нэмэгдэж нийт 69 байгууллагын 704 хүнийг хамруулан ажилласан. "Гэр бүлийн харилцаа", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Байгууллагын эцэг эхийн зөвлөл байгуулах" сургалтыг нийт 17 байгууллагын 329 албан хаагчдад, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүд буюу нийт 52	100%

												байгууллагын 375 хүнд тус бүр ажлын байран дээр нь зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Дээрх нийт 10 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 9125 өрхийг хамруулсан нь аймгийн нийт өрхийн 32%-ийг эзэлж байна.	
39		Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэй харилцах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Улсын төсөв	20.0	Эцэг эхчүүдийн 10%	Эцэг эхчүүдийн 25%	5.0	Улсын төсөв 45.0	2021 онд улсын хэмжээнд зохион байгуулсан "Хүмүүжлийн эерэг арга" сургалтад 10 багш, мэргэжилтэн хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн. Эдгээр сургагч багш нар 11 удаагийн сургалтыг зохион байгуулж, 3251 хүн буюу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт эцэг эхчүүдийн 15 хувийг хамруулсан. 2022 онд нийт 5 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 12681 эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүдийг хамруулан ажилласан. Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэй харилцах эв дүй, хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан зохион байгуулж ЕБС, цэцэрлэгийн эцэг, эхчүүдийн 20 хувийг хамруулсан. Урлаг соёл, спортын арга хэмжээнд нийт 1350 гаруй иргэд хамрагдсан. "Гэр бүлийн үнэ цэнтэй харилцаа" сургалтыг албан байгууллагууд болон сурагчдын эцэг эхэд зохион байгуулж, нийт 53 байгууллагын 2800 гаруй ажилтан албан хаагчид, эцэг эх асран хамгаалагч оролцсон. Тайлант онд хүмүүжлийн эерэг арга, хандлагын талаар, эцэг, эхийн боловсрол олгох зэрэг сэдвээр 8 шторк, 60 постер мэдээлэл, 5 удаагийн лайв мэдээлэл хийж ажиллаж нийт 37000 гаруй хандалт авсан байна. Тухайлбал байгууллагын эцэг эхийн зөвлөлд "Гэрэлт ирээдүйд гар бүү хүр" уриатай хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрөөр 10 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 219 хүн, "Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд" хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх нь сургалтыг 89 байгууллагын 21500 гаруй иргэнийг хамруулан зохион байгуулсан. "Харилцаагаа усалж-Хайраар гэрэлтүүл" өдөрлөгийг 50 гэр бүлийг хамруулан зохион байгуулсан. Нийт 15 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 15800 гаруй эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан нь нийт эцэг эхийн 24.5 хувь хамрагдсан байна.	98%
40		Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд чиглэсэн төсөл	2021-2024	ГБХЗ ХГ	НБХ	Орон нутгийн төсөв	-	-	Хөтөлбөрийн хэрэгжилти	Батлагдсан	Орон нутгийн төсөв 88.0	2021 онд "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-ын 61 дүгээр тогтоолоор баталсан. Эмэгтэйчүүдэд чиглэсэн сургалт,	100%

		хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх							йн 60%-д хүрсэн байна.	төсвийн хүрээнд		нөлөөллийн ажилд 6639 охид, эмэгтэйчүүд хамрагдаж, "Гэр бүлийн харилцаа" сэдвээр эрдэмтэн, докторуудын илтгэлийг эмхэтгэн 200 ширхэг гарын авлага, номыг хэвлүүлэн гэр бүлүүдэд хүргэсэн. 2022 онд "Жендэрт суурилсан хүний эрхийг хүндэтгэе" 3 сарын аяны хүрээнд "Эмэгтэйчүүдийн хөгжил оролцоо" чуулган, "Өрхийн аж ахуйг хэрхэн амжилттай эрхлэх тухай" сургалт, "Эмэгтэйчүүдийн ёс зүй-нөлөөлөл хөгжлийн гарц болох нь" сэдэвт сургалт уулзалт, Өрхийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах зорилгоор "Урам зоригтой эмэгтэйчүүд" төсөл, "Эмэгтэйчүүдийн манлайлал ба харилцааны ур чадвар" сэдэвт сургалт, Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулган зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж 800 гаруй эмэгтэйчүүд хамрагдсан. Тайлант онд Эрдэнэтийн ээжүүдийг чадавхжуулах холбоотой хамтран гар урлаачдыг сургах, хөгжүүлэх өрхийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах "Гэрэл" төсөл, "Гэр бүлийн үнэ цэнтэй харилцаа" сургалт нөлөөллийн цуврал лекц, "Бидний дуу хоолой"-2023" охидын чуулган зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулсан. Түүнчлэн Шүүхийн тамгын газартай хамтран гэрлэгчдэд сэтгэл зүйн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, уулзалт хийх, гэр бүлийн хөгжил-боловсрол, тогтвортой байдлыг дэмжиж сургалт, зөвлөгөөг явуулах чиглэлээр "Гэр төслийг хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээнд давхардсан тоогоор 8500 гаруй охид, эмэгтэйчүүд хамрагдсан. Хөтөлбөр 92 хувийн хэрэгжилттэйгээр аймгийн Засаг даргын болон ИТХ-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.	
41	2.1.2.Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж, салбар дундын үйл ажиллагааг сайжруулна.	Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах	2021-2024	ГБХЗ ХГ	Аймгийн ГХУС АЗСЗ	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	40.0	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 40%	Хамтарсан багийн гишүүдийн хамрагдалт 60%-д хүрсэн байна.	10.0	Улсын төсөв 2.5 Орон нутгийн төсөв 13.3	2021 онд хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 4 сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт гишүүдийн 77.7 хувийг хамруулж, хүүхэд хамгааллын үйлчилгээнд 1458 хүүхэд хамрагдсан нь зорилтот бүлгийн хүүхдийн 59.3 хувийг эзэлж байна. 2022 онд хамтарсан багийн 30 кейс үйлчилгээнд дэмжлэг үзүүлж, 22 багийн нийгмийн ажилтнуудыг "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сургалтын гарын авлагаар хангасан. Багийн ажлын албанаас иргэдэд сургалт зохион байгуулж, 5200 орчим иргэдийг хамруулсан. Аймгийн хэмжээнд нийт 28 хамтарсан баг 202 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.	100%

												Тайлант онд хамтарсан баг, хүүхдийн элч, ЕБС-ийн хүүхэд хамгааллын баг, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийг чадавхжуулах 8 удаагийн сургалт зохион байгуулснаас 2 удаагийн сургалтад нь хамтарсан багийн гишүүдийг 100 хувь хамруулсан. Хамтарсан багийн гишүүдийг ажлын байран дээр нь чадавхжуулах, арга зүйгээр хангах, зөвлөн туслах үйлчилгээг 3 удаа зохион байгуулж нийт гишүүдийн 80 гаруй хувийг хамрууллаа. Хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын 37 кейсд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхэд 2.5 сая төгрөгийг зарцуулагдсан.	
42		Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах (108 утас, бусад хүсэлт, гомдол)	2021-2024	ГБХЗ ХГ	Хамтарсан багууд	Улсын төсөв	60.0	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 90%	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 98%-д хүрсэн байна.	15.0	Улсын төсөв 15.0	2021 онд 108 утсанд 192 дуудлага ирсний 88.5 хувийг, 2022 онд 265 дуудлага ирснээс 95.2 хувийг шийдвэрлэсэн байна. Ирсэн дуудлагын 90 гаруй хувь нь хүүхэд хамгааллын дуудлага эзэлж байна. Тайлант онд 275 дуудлага ирснээс 260 дуудлага буюу 94.6 хувь нь шийдвэрлэгдсэн, 15 дуудлага буюу 5.4 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэлтийн шатанд байна. Үүнээс хүүхэд хамгааллын дуудлага 97.4 хувь, нийт дуудлагын 87.9 хувь нь гэр бүлийн хүрээнд гарсан дуудлага байна. Хүүхдийн тусламжийн 108 утас"-ны дуудлагын шийдвэрлэлтийн чанар, хэрэгжилт, гүйцэтгэл дээр чанартай ажиллах төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын "Хүүхдийн тусламжийн 108 утас"-ны үйлчилгээний төвийн ажилтнуудтай хамтран практикт суурилсан сургалтыг Баян-Өндөр сумын 27 багийн нийгмийн ажилтныг хамруулан зохион байгуулж, дуудлага тус бүрийг шууд багийн нийгмийн ажилтан хүлээн авч, түргэн шуурхай үйлчилгээг хүргэн ажиллах арга зүйд суралцсан. Мөн "Хүүхдийн тусламжийн 108 утас"-ны үйлчилгээ, хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалдаг талаар сурталчлан таниулах зорилгоор сургуулийн нийгмийн ажилтан, хүүхэд төлөвшлийн менежер, цэцэрлэгийн эрхлэгч нарт сургалт хийсэн. Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлагыг 2 сум, 26 багийн нийгмийн ажилтнууд шууд хүлээн авч хариу үйлчилгээг шуурхай үзүүлж, дуудлагыг хааж, шийдвэрлэдэг болсон нь үр дүнтэй байна. Хүүхдийн тусламжийн 108 утас"-нд ирсэн дуудлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дуудлагын тоо 5 дуудлагаар буюу 4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	96.5%

											Тайлант онд хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр хамтарсан багийн үйл ажиллагааг чадавхжуулах 7 удаагийн сургалт, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажил зэрэг нийт 8 төрлийн 14 арга хэмжээг зохион байгуулсан.		
43		Эрсдэлийн программд бүртгэгдсэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг хөгжлийн үйлчилгээнд хамруулах	2021-2024	ГБХЗ ХГ	БТСГ	Улсын төсөв	40.0	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 6% хамруулсан.	Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 10% хамруулсан байна.	10.0	Улсын төсөв 10.0	2021 онд улсын хэмжээнд хэрэгжүүлдэг эрсдэлийн программд манай аймгаас өндөр эрсдэлтэй 225 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 18 хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулсан. 2022 онд бүртгэлтэй эрсдэлт нөхцөлд байгаа 144 хүүхдэд нөхцөл байдлын дахин үнэлгээ хийж, 29 хүүхдэд кэйс менежментийн төлөвлөгөө гарган хариу үйлчилгээг үзүүлсэн. Тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай 100 хүүхдэд дархлаа сэргээх эрүүл мэндийн багцыг олгосон. Хүүхдийн ордны хөгжлийн хөтөлбөрийн ардын бүжиг, хар уран зураг, шатар, төгөлдөр хуур, математик соробан сампин зэрэг дугуйланд нийт 18 хүүхдийг хамруулан ажилласан. Тайлант онд нийт 569 хүүхэд бүртгэгдсэнээс судалгааг дахин шинэчилж 426 хүүхдийг илрүүлэн бүртгэлжүүлж, тусламж дэмжлэгт 186, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зөрчлийн асуудалд 35, эрүүл мэндийн үйлчилгээнд 28, эцэг эхийг нь ажилд зуучилсан 5, архины хамааралтай гэр бүлд амьдарч байгаа 29 хүүхдэд сэтгэл зүйн болон халамжийн үйлчилгээнүүдийг үзүүлж, нийт 283 хүүхдийг хамруулсан нь эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн 66.4 хувийг эзэлж байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 4 хүүхдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн. Мөн гэрийн эргэлтээр байнгын хяналтад 93 хүүхэд байна. Номин даатгалтай хамтран 258 хүүхдийг даатгалд хамруулсан.	100%
44		Түр хамгаалах байрны үйл ажиллагааг сайжруулах	2022-2024	ГБХЗ ХГ	ХЭЗХ ЦГ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Үйлчлүүлсэн иргэдийн тоо	Хамгаалах байрны тоног төхөөрөмжөөр хангагдаж, үйл ажиллагаа	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 35.6	Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжих, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг ГБХЗХГ-тай хамтран ажиллуулж, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2021 онд түр хамгаалах байраар 69 хүн үйлчлүүлсний 22 нь насанд хүрэгч эмэгтэй, 47 нь хүүхэд нийт 375 ор хоног үйлчилгээ авсан байна.	90%

									эхэлсэн байна.			2022 онд 35 үйлчлүүлэгч хүлээн авсныг гэр бүл тус бүрээр нь кейс, бүртгэл нээн хооллох, хувцаслах, усанд оруулах зэрэг үйлчлүүлэгчийн суурь хэрэгцээг хангаж үйлчилгээ үзүүлсэн. "Түр хамгаалах байр"-аар үйлчлүүлсэн 16 өрхөд эргэн хяналтыг хийж ажилласан. 2023 онд түр хамгаалах байранд 67 хүнийг хүлээн авч түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр 10 төрлийн үйлчилгээг үзүүлж, тус ажилд орон нутгийн төсвөөс 35.6 сая төгрөгийг зарцуулсан. Түр хамгаалах байраар үйлчилгээ авсан хүний тоо өнгөрсөн оноос 28 хүнээр буюу 80%-иар нэмэгдсэн байна. Үйлчлүүлсэн иргэдийн 10 нь насанд хүрэгчид, 53 нь хүүхэд байна. Түр хамгаалах байранд ирсэн дуудлага мэдээллийг ангилан үзвэл: Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 22, үл хайхрах хүчирхийллийн дуудлага мэдээлэл 15, бэлгийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл-1, сэтгэл санааны хүчирхийллийн дуудлага мэдээлэл 11, бие махбодийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 7, үүнээс давхардсан тоогоор-3, бусад-2, эдийн засгийн хүчирхийлэл-1, дуудлагууд тус тус бүртгэгдэж тухайн дуудлага бүрт нээж ажилласан кейс 22 байна. Дээрх үйлчлүүлсэн иргэдээс Ахмад настан, тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүн байхгүй болно.	
45	2.1.3.Залуучуудад чиглэсэн арга хэмжээ, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхжүүлж, тэдний оролцоог дэмжинэ.	Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг сайжруулах	2021-2024	ГБХЗ ХГ	Баян-Өндөр сумын ЗДТГ	Улсын төсөв	32.0	Залуучуудын хамрагдалт 25%	Залуучуудын хамрагдалт 40%-д хүрсэн байна.	8.0	Улсын төсөв 8.0 Орон нутгийн төсөв 150.0	2021 онд өсвөр үе залуучуудад зориулсан онлайн болон танхимын 30 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 1530 өсвөр үе, залуучууд хамрагдсан. 2022 онд сургалт, нөлөөллийн 20 багц арга хэмжээний хүрээнд 9000 гаруй залуучуудыг хамруулсан. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд амьдрах ухааны сургалт буюу амьдрах ухааны 12 модуль сургалтыг ШШГГ-ын 437-р хорих анги, зан үйлийн сургалтад хамрагдаж буй өсвөр насны хүүхдүүд, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутан, сурагчдад нийт 50 удаагийн сургалт явуулж 1000 хүн хамруулсан. 2023 онд "Сэтгэл нэмье" төслийн хүрээнд Updated хөвгүүдэд зориулсан сургалтыг "Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог, хайрцаглагдсан эр хүн" сэдвээр ерөнхий боловсролын сургуулийн 15,16,17,1-р сургуулийн ахлах ангийн 200 гаруй хөвгүүд, Макреме сүлжмэл, эсгий гутал хийх	91.3%

											сургалт, сүлжмэл тоглоом хийх, гар урлалын сургалтад 80 залуу, Жаргалант сумын 200 өсвөр үеийн хүүхэд, залуучуудад ганцаарчилсан сэтгэл зүйн болон бүлгийн уулзалт зөвлөгөө, “Мэргэжил сонголт”, “Сайн дурын ажилд залуусаа манлайлцгаая”, “Аз жаргалтай гэр бүлийг бүтээцгээе”, “Ажлын байрандаа эерэг соёл бүтээцгээе”, “Хаа ч байсан хайртай аав ээж байя”, “Эрүүл мэндээ хамгаалцгаая” зэрэг сэдэвт сургалтуудыг төрийн 10 байгууллага, үйлдвэрийн 4 газар, хувийн хэвшлийн 1, ерөнхий боловсролын 8 сургуульд нийт 3500 залуучуудыг хамруулан тус тус зохион байгуулсан. “Сэтгэл Нэмье” гэр бүлийн өдөрлөгийг 11 удаа зохион байгуулж 60 гэр бүлийн хос оролцсон. Нөхөн үржихүйн боловсрол олгох сургалтыг Орхон аймгийн ерөнхий боловсролын нийт 15 сургуульд зохион байгуулж 1000 орчим өсвөр үеийн хөвгүүд хамрагдсан. Залуучуудад хүргэх үйлчилгээг анхан шатны нэгжид хүргэх, гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн харилцаа, хандлагын талаарх нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар залуу гэр бүлийн оролцоо идэвх дээшилж байна. Сургалт, олон талт нөлөөллийн үйл ажиллагаанд нийт 10250 хүн хамруулсан нь нийт залуучуудын 36.5 хувийг эзэлж байна. Амьдрах ухаан, нөхөн үржихүйн чиглэлийн 231 постер зөвлөмжийг хийж, цахимаар өсвөр үе залуучуудад сурталчилсан нь 34650 хандалт авсан.		
46		Залуучуудын ордны үйл ажиллагааг тогтмолжуулах	2021-2024	ГБХЗ ХГ	Залуучуудын ордон	Улсын болон орон нутгийн төсөв	-	Тохижилт хийгдсэн байна.	Үйл ажиллагаа жигдэрсэн байна.	224.0	Орон нутгийн төсөв 339.6	2021 онд залуучуудын ордны үйл ажиллагааны зардал болон гадна тохижилтын ажилд орон нутгмйн төсвөөс 457.0 сая төгрөг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр лед дэлгэц, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх дундын оффис байгуулсан. 2022 онд 60 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, 16000 гаруй залуучуудыг хамруулж, цахим хандалт 42740 байсан. Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 156.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, үйл ажиллагааны зардалд 183.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Давхардсан тоогоор 12000 залуучууд Залуучуудын ордноос үйлчилгээ авсан. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй	100%

											залуучуудад чиглэсэн урлаг, спорт, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нийгэмд эзлэх байр суурь зохих түвшинд дээшилсэн. Мөн тусгай шалгуурын дагуу 8 оюутан сургалтын тэтгэлэгт хамрагдаж, сурч боловсрох, хөгжих боломжоор дэмжин ажилласан байна. Залуучуудын ордонд сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх өрөөг тохижуулж, “Сэтгэл нэмье” төслийг хэрэгжүүлж, нийгэмд эерэг мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, 250 гаруй эрчүүдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хүргэсэн. Мөн дартсын Эрчим клуб, Анза дуу бичлэгийн студи, бүжгийн Social dance клуб, шагай харваа, бийрэн бичиг, 1 амьд хөгжмийн хамтлагийг дэмжин дэргэдээ авч, хамтран ажиллаж, 11 сонирхлын клуб үйл ажиллагаа явуулж, бүртгэлтэй 200 гишүүн хамрагдаж байна. Тайлант хугацаанд 134 арга хэмжээнд 17760 залуучуудыг хамруулсан нь аймгийн хэмжээний нийт залуучуудын 59 хувь нь хамрагдсан байна.		
47		Сайн дурын ажилд залуучуудын оролцоог дэмжих, сайн дурын ажилтнуудыг бүртгэлжүүлэх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах	2021-2024	ГБХЗ ХГ	ХХҮГ	Улсын төсөв	4.0	Сайн дурын ажилд хамрагдагсдын тоо 25	Сайн дурын ажилд хамрагдагсдын тоо 40	1.0	-	2021 онд сайн дурын ажил хийх сонирхолтой 51 залууг бүртгэж, сайн дурын ажилд 30 залуучуудыг холбон зуучилж ажилласан. 2022 онд байгууллага аж ахуй нэгж, багийн залуучуудын салбар зөвлөлийг уриалж, 60 гаруй байгууллага, 22 багийн залуучуудын салбар зөвлөл нэгтгэн, 80 гаруй сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулснаас бүтэн өнчин 19 настай нэг залууг амьдрах гэртэй болгож, хашааны газрыг нь шийдэж, ажил орлоготой болгосон. Үйл ажиллагаандаа идэвхтэй оролцдог 15 гишүүнийг үнэмлэхжүүлсэн. "Чадах зүйлээрээ туслая" аяныг эхлүүлж өөрсдөө лаа, саван хийж борлуулалтын орлогыг Дундговь аймгийн "Ид шидийн уут" аянд хандивласан. Сайн дурын клубүүдтэй хамтран нийт 6 арга хэмжээг зохион байгуулсан. Тайлант онд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, сайн дурын ажил хийх идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Гүйе Түүе-Эко гэр бүл” бүх нийтийн гүйлт цэвэрлэгээ зохион байгуулж 100 гэр бүл, тамхины иш түүх, мэдлэгээ хуваалцах, тус дэм больё зэрэг 6 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж 1000 гаруй залуучууд, хүүхдийн тоглоомын талбайг засаж сайжруулах, тохижилтын ажил, сайн үйлсийн аян зэргийг	100%

											зохион байгуулж 100 гаруй залуучууд, Жаргалант суманд малчин айлын малын тэжээлийн хашааг цэвэрлэх ажилд 50 гаруй залуучууд, "Сайн дурын ажил болон түүний ач холбогдол"-ын талаар залуучуудад ойлголт хэлэлцүүлэг зохион байгуулж, "Орхон-МСҮТ", "ХАА-н МСҮТ"-ийн 100 суралцагчийг тус тус хамруулсан. "Бүх хайраа гэр бүлдээ", "Талархлын 7 хоног", "Урам түгээх 7 хоног" сэдвүүдийн хүрээнд 12 постер мэдээллийг цахимд байршуулж 9263 хандалт авсан. Сайн дурын клубүүдтэй хамтран англи хэл, номын өдөрлөг, гадаадад суралцахаар зорьж буй хүүхэд, залууст ielts, toefl шалгалтад хэрхэн бэлдэх, шинэ цагийн илгээлтийн эзэд малчин, тариаланчдад туслах сайн дурын ажил, цаасны дахин боловсруулалт зэрэг сайн дурын ажлуудыг өрнүүлж 400 хүнийг хамруулсан байна. Сайн дурын клубүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлснээр сонирхлын бүлэг, клубийн тоо нэмэгдэж, шинээр олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж хамрагдалт 2300, цахим хандалт 9263 болсон.		
48		"Өндөр ёс зүйтэй-өөдрөг иргэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	ГБХЗ ХГ	Орон нутгийн төсөв	30.0	Хөтөлбөр ийн хэрэгжилт 65%	Хөтөлбөр хэрэгжиж дуусна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 30.0	"Өндөр ёс зүйтэй өөдрөг Эрдэнэт" хөтөлбөрийг 2019 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 40 дугаар тогтоолоор батлагдсан. "Өндөр ёс зүйтэй өөдрөг Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Олон улсын мэргэжлийн хөгжлийн институттэй хамтран "Чадварлаг Монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд "Оюуны элч" манлайлагчдыг бэлтгэх эхлэлийг тавих суурь хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлсэн. "Оюуны элч" манлайлагчид нь салбар бүртээ зөв хандлага, ур чадвараараа бусдыгаа уриалж, Эрдэнэт хотын хөгжил, дэвшилд хувь нэмрээ оруулах зорилготой. "Оюуны элч" манлайлагч бэлтгэх урт хугацааны хөтөлбөрт боловсролын салбарын багш, ажилтнууд, иргэдийн төлөөлөл, анхдагчдын холбоо болон ахмадын холбооны ахмадууд, Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, багуудын хэсгийн ахлагч нар, Баян-Өндөр сумын багийн Засаг дарга нар, багуудын Залуучуудын салбар зөвлөлийн төлөөлөл зэрэг нийт 500 хүнд хувь хүний хөгжил, ёс зүй, манлайлал, бүтээмж, бүтээлч байдлын чиглэлээр "Идэвхжүүлэх" сургалтыг Олон Улсын NCS стандартын сургалтын агуулгын хөтөлбөр, хувь	100%

											хүний ур чадварын сургалтын 3 сэдвийг Олон улсын мэргэжлийн хөгжлийн институтийн "Олон улсад мөрдөгддөг суурь ур чадварын стандарт" суурилан боловсруулсан агуулгын дагуу зохион явуулсан. Мөн нийт оролцогчдод "Хувь хүний хөгжил", "Аз жаргалтай гэр бүл", "Хувь хүний хөгжлөөс-Улсын хөгжил", "Эрүүл мэнд-Эрүүл дадал", "Хог хаягдал, тогтвортой хөгжил", "Зохист хэрэглээ", "Боловсрол" сэдвээр орон нутгийн удирдах албан тушаалтнууд, холбогдох албаны хүмүүс, харилцааны урлагийн чиглүүлэх багш нар илтгэл танилцуулж, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, нийгмийн бусад салбарт тулгамдаж буй асуудлыг танилцуулж, түүнийг шийдвэрлэх аргачлалын талаар шаталсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд зохион байгуулсан нийт арга хэмжээнд 2019- 2022 онд 20000 гаруй иргэд, өсвөр үе залуучуудыг хамруулсан байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 92% - ийн хэрэгжилттэйгээр дүгнэгдэн хэрэгжиж дууссан.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

49	2.1.4.Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, төсөл хэрэгжүүлнэ.	“Ач санах” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	Аймгийн ахмадын хороо	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хэрэгжилтийн хувь 80%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 105.0	Ахмад настны Ач санах хөтөлбөр нь 3 зорилтын хүрээнд 20 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2023 онд хөтөлбөрийн хүрээнд: Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Зэвсэгт хүчний 102 жил, Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан Хүндэтгэлийн арга хэмжээ, "Эх үрийн элбэрэл" тоглолт, "Ахмадууд дуулж байна" урлагийн наадам, аймгийн аварга шалгаруулах волейбол, шатар, софт воллейбол, ширээний теннисний тэмцээн, сар бүрийн 15-нд ахмадын "Дуулах өдөр" дуун цэнгүүн, ахмад настанд чиглэсэн 4 удаагийн сургалтын үйл ажиллагаа зэрэг арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 13600 гаруй ахмад хамрагдсан байна. Орхон аймгийн ХХҮГ, Улаан загалмайн хороо хамтран Жаргалант сумын 78 ахмад, Баян-Өндөр сумын 224 ахмад настныг өдрийн үйлчилгээнд хамруулсан. Мөн олон улсын ахмадын өдрийг угтан хэвтрийн өвчтэй 250 ахмадад хүндэтгэл үзүүллээ. Тайлант оны 9 дүгээр сараас эхлэн ахмад настанд зориулсан алжаал тайлах өрөө, номын сан, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимыг тохижуулан ажиллуулж өдөрт 30-45 хүн тогтмол үйлчилгээ авч байна. Мөн номын сангийн номын фондыг ахмадууд нэмэгдүүлэн одоогоор 1500 орчим номтой болоод байна. Ахмадын ордонд сэтгэл зүйчийн танхимыг нээн ажиллуулснаар 1 сарын хугацаанд бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөг 100 гаруй ахмадад, ганцаарчилсан зөвлөгөөг 19 ахмадад тус тус өгсөн. Тайлант онд хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо өмнөх оныхтой харьцуулбал 3000 ахмадаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Дээрх үйл ажиллагаануудад орон нутгийн төсвөөс 105.0 сая төгрөг зарцуулаад байна. Хөтөлбөрийн хүрээнд дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр хөтөлбөр 80 хувийн хэрэгжилттэй байна.	90%
50		“Анхдагч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	НБХ	ТББ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хэрэгжилтийн хувь 80%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 40.0	Анхдагч дэд хөтөлбөр нь 3 зорилт 10 үндсэн үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд МАНЗ-Баатар холбоо, төрийн байгууллагуудын Соёмбо холбоо, Эрдэнэтийн овооны анхдагч илгээлтийн эздийн	90%

							хүрээнд					холбоо, Барилгачин дайчдын холбоо, Залуу насаа эргэн дурсахуй холбооны гишүүдийн дунд зохион байгуулах олон талт үйл ажиллагааны зардалд 28.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Тус дэмжлэгийн хүрээнд хүнд нөхцөлд амьдарч буй 87 анхдагчид тусламж, хэвтрийн өвчтэй 127 анхдагчид гэр эргэлт, ахмадын сувилалд 197, өдөр өнжүүлэх үйл ажиллагаанд 85 анхдагч тус тус хамрагдсан. Мөн тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг 3, сургалтын үйл ажиллагаа 2, туршлага судлах уулзалт аялал 5, спортын урлагийн 5 төрөлт тэмцээн зэргийг зохион байгуулж 1400 гаруй анхдагч, ахмадууд хамрагдсан байна. Тайлант онд нийт анхдагчдын 70 хувь нь хөтөлбөрт хамрагдаж, орон нутгийн төсвөөс нийт 40.0 сая төгрөгийг зарцуулан ажилласнаар тус хөтөлбөр 80 хувийн хэрэгжилттэйгээр хэрэгжиж байна.	
51	2.1.5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх	2021-2023	ГБХЗ ХГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Хөтөлбөрийн хэрэгжилт 20%	Хөтөлбөрийн хэрэгжилт 98%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 50.0	Хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 8 төрлийн 12 арга хэмжээг зохион байгуулж 4200 иргэн хамруулсан. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос 49.5 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг өмнөх оноос 76.9 хувиар тус тус буурсан. 2022 онд "Жендэрт суурилсан хүний эрхийг хүндэтгэе" 3 сарын аяныг зохион байгуулж нийт 10 гаруй төрлийн үйл ажиллагаанд 12000 иргэн хамрагдсан. Тайлант онд жендэрийн тухай ойлголт мэдээллийг олон нийтэд сурталчлах зорилгоор "Хөгжилд хамтдаа" жендэрийн мэдлэг олгох сургалт, өдөрлөг "Жендэрт суурилсан хүний эрхийг хүндэтгэе" нөлөөллийн арга хэмжээ, "Бүх бүлгийн оролцоо тэгш байх тухай ойлголтыг өгөх сургалт", Хуулийн хэрэгжилт цуврал сургалт зэрэг нийт 6 удаагийн сургалт, 2 арга хэмжээ зохион байгуулсан. "Бүх хайраа гэр бүлдээ" уриан дор "Бүх хайраа гэр бүлдээ" өдөрлөг, "Миний үнэ цэнэ миний гэр бүл өглөөний сургалт уулзалт, "Харилцаагаа усалж-Хайраар гэрэлтүүлэе" өдөрлөг, "Хүмүүжлийн зэрэг арга" сургалт, "Бүх хайраа гэр бүлдээ" сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өдөрлөг, "Жендэрийн сургалт", "Сэтгэл нэмье" гэр бүлийн өдөрлөг зэргийг зохион байгуулж 800 гаруй хүн хамрагдсан. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран "Бүх хайраа гэр бүлдээ" сэдэв дор манлай үлгэр жишээ гэр бүлийг оролцуулсан 4 удаагийн нэвтрүүлэг "Далд хүчирхийллийг ил болгоё" аяны хүрээнд ерөнхий	91.8%

												боловсролын 10 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 22 байгууллагад зөвлөн туслах, арга зүйгээр хангах зэрэг арга хэмжээг нэг сарын хугацаанд явуулсан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэд олон нийтэд хүргэх, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, гэр бүлийн боловсрол олгох мэдлэг мэдээллийг сурталчилж ажилласан. Тайлант хугацаанд 5 төрлийн 16 арга хэмжээнд давхардсан тоогоор 8800 гаруй иргэн хамрагдаж, 12 шторк, 6 нэвтрүүлэг, 220 постер мэдээ, мэдээлэл бэлтгэн мэдээлсэн ба хандалт 283107 байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувьтайгаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.	
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ													
	2.2.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.												
52	2.2.1.Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулна.	Нийгмийн халамжийн үйлчилгээг ehalamj системд шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	10%	80%	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 08 дугаар сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь ehalamj.mn цахим системд үе шаттайгаар шилжиж эхэлсэн. 2020 онд 6, 2021 онд 26 төрлийн үйлчилгээ дээрх системд шилжсэн. 2022 онд 40 үйлчилгээг цахимд шилжүүлснээр 2023 оноос нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээ 100% цахимжсаны үр дүнд иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд цахимаар хамрагдаж, өргөдөл хүсэлтээ гаргах боломж бүрдсэн.	100%
53	2.2.2.Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	Нийгмийн халамжийн багц хуулийн хүрээнд нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээг үзүүлэх	2020-2024	ХХҮГ	-	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	40000 /давхардсан тоогоор/	41500 /давхардсан тоогоор/	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 137.9	Нийгмийн халамжийн багц хуулийн хүрээнд 2020-2022 онуудад давхардсан тоогоор 121500 иргэнд нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээг хүргэсэн бол хүүхдийн мөнгөн тэтгэмжид 111314 хүүхэд, хүнс тэжээлийн дэмжлэгт 5449 өрхийн 28133 иргэнийг хамруулж 4.9 тэрбум төгрөг зарцуулсан. Тайлант онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид давхардсан тоогоор нийт 80441 иргэн хамрагдсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 39142 хүүхэд хамрагдаж 46.4 тэрбум төгрөг зарцуулсан.	100%
54	2.2.3.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн	Орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж,	2020-2024	ХХҮГ	НБХ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	430 иргэн	490 иргэн	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 137.9	2020-2022 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 404.1 сая төгрөг батлагдсан. Онцгой тохиолдлын тэтгэмжид 113 иргэнд 131.2 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд 7 төрийн бус байгууллагатай хамтран 908 иргэнийг хамруулсан	100%

	оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.	/5 төрөл/ олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг (8 төрөл) хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх									зорилтот арга хэмжээнд 233.5 сая төгрөгийг зарцуулсан. Тайлант онд онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид 48 иргэнд 57.6 сая, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 331 иргэнд 73.0 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас тус тус зарцуулсан.		
2.2.4.Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, тусалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.													
55	2.2.5.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	78 иргэн	92 иргэн	47.9	Улсын төсөв 47.9	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс жил бүр баталж хэрэгжүүлдэг "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр"-ийн хүрээнд 2020-2022 онуудад мэргэжил олгох сургалтыг аймгийн Орхон, ХАА-н МСҮТ-үүдтэй хамтран хийж, цахилгаанчин, тогооч, барилгын засал чимэглэлч, гагнуурчин, үсчин, оёдолчин 7 мэргэжлээр нийт 169 иргэнийг хамруулан ур чадварын гэрчилгээ олгож, сургалтын зардалд 46.1 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд мөн дээрх сургалтын байгууллагуудтай хамтран 7 мэргэжлээр ажил хайгч 95 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэн нийт 105 иргэнийг сургаж, 47.9 сая төгрөг зарцуулсан. Сургалтын дараа 10 иргэн байнгын ажлын байртай болж нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаж байна. Ажилд орсон иргэдийг салбараар нь авч үзвэл боловсруулах үйлдвэрт 3, уул уурхайд 2, худалдаа үйлчилгээнд 4, төрийн байгууллагад 1 иргэн тус тус ажилд орсон. Иргэд мэргэжлийн сургалтад хамрагдаж суурь мэргэжил эзэмшснээр залуучууд хөдөлмөрийн харилцаанд орж, орлого олохоос гадна эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломж бүрдсэн.	100%
56	2.2.6.Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, ажил олоход хүндрэлтэй иргэдэд мэргэжил сонгох, ажилд ороход шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөх	2020-2024	ХХҮГ	БШУГ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	1520 иргэн	1670 иргэн	14.1	Улсын төсөв 7.4	2020-2022 онуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, ганцаарчилсан болон бүлгийн сургалт зэрэгт 4823 иргэн хамрагдаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 42.1 сая төгрөгийг зарцуулсан. Бүлгийн сургалтыг ХХҮЕГ-аас эрх авсан сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ЕБС-ийн 2403 сурагч хамруулж мэргэжил сонголтоо зөв хийхэд хэрэгтэй мэдээ мэдээллээр хангаж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Тайлант онд ХХҮЕГ-аас эрх авсан "Алтан алхам" сургалтын төв, Насан туршийн боловсролын төв	86.8%

											зэрэг байгууллагуудтай хамтарч ерөнхий боловсролын түшиц 7 сургуулийн 8 дугаар ангийн 329 сурагч, хорих ангид хүмүүжиж байгаа 40 иргэн, ажил хайгч 31 иргэн нийт 400 иргэнд бүлгийн зөвлөгөө, 250 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, нийт 650 иргэнд зөвлөгөө мэдээллийг өгч 5.0 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. 2023 оноос хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээ, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээг шинээр нэвтрүүлж 800 иргэнийг хамруулснаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг нийт 1450 иргэнд үзүүлсэн байна.		
57	2.2.7.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх, оюутны цагаар ажиллах арга хэмжээний хүрээнд сул чөлөөтэй ажлын байрны мэдээллийг их, дээд сургууль, коллежийн оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүдэд хүргүүлж холбогдох мэдээллээр хангах	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	81 төсөл	100 төсөл	460.0	Улсын төсөв 846.6	2020-2022 онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болох хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, ажлын байр дэмжих, малжуулах, ахмадын хөдөлмөр эрхлэлт, залуучуудын хөдөлмөр эрхлэлт зэрэг 5 хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт нийт 197 иргэний төсөлд 1.2 тэрбум төгрөгийг 24-48 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгож 286 байнгын ажлын байр бий болсон. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийг төсөл хэрхэн бичих, бизнесээ хөгжүүл зэрэг аж ахуй эрхлэлтийн 3 өдрийн сургалтад хамруулсан.Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын дагуу 1 байгууллагад 12 оюутан цагийн ажилд зуучлуулж 12 түр ажлын байр бий болсон. Тайлант онд нийт 101 иргэний төсөлд 830.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгосон. Үүний үр дүнд 101 ажлын байр хадгалагдаж 59 шинэ ажлын байр бий болсон байна. Залуучуудын Старт-ап арга хэмжээг "Шинэ эхлэл цэг" ТББ-ын сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, 65 залуусыг оролцуулснаас эцсийн шалгаруулалтаар 1 баг шалгарч 10.0 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж шинээр 2 ажлын байр нэмэгдсэн. "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд мэргэжлийн чадамжийн гэрчилгээ, цахим ур чадварын сертификат олгох 21 хоногийн цахим сургалтыг зохион байгуулж 40 эмэгтэйг хамруулан 6.6 сая төгрөг зарцуулж, 5 ажлын байр бий болсон. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа	100%

												иргэн, аж ахуй нэгжээс цагийн болон өдрөөр ажиллах ажлын байрны захиалга ирүүлсний дагуу Орхон, ХАА-н МСҮТ-ийн давхардсан тоогоор нийт 300 орчим суралцагчид өдрийн 50.0-70.0 мянган төгрөгөөр цалинжин ажиллаж байна.	
58	2.2.8.Аймгийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучилж, ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин ажиллана.	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, мэдээллийн сан баяжуулж, ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	1000 иргэн	1000 иргэн	7.0	Улсын төсөв 1400.0	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем LMIS программд 2020-2022 онд ажил хайгч 4509 иргэнийг бүртгэсэн. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системд 1769 ажил олгогчоос 3188 ажлын байрны захиалга ирж сул чөлөөтэй ажлын байранд 3131 иргэн ажилд зуучлагдсан. Үүний 2441 нь байнгын ажлын байранд, 521 нь түр болон улирлын ажлын байранд зуучлагдаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 24.1 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд 706 ажил олгогч байгууллагаас 1481 ажлын байранд ажилтан авах захиалга хүлээн авч мэдээллийн сайтуудад байршуулан иргэдэд түгээж байна. Ажил хайгчаар 475 иргэн бүртгэгдэж, 1183 иргэн ажилд зуучлагдсан байна. Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа 550 иргэнийг нийтийн эзэмшлийн хог цэвэрлэх, шарилж устгах түр ажлын байранд ажиллуулж 110.0 сая төгрөгийн урамшуулал олгогдсон. Орон нутагт хийгдэх бүтээн байгуулалттай холбоотой тендерийн ажилд оролцох хүсэлтэй 33 ажил олгогч байгууллагаас 408 иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллуулсан.	100%
59		Тогтвортой ажлын байрыг бий болгож, шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал олгох	2020-2024	ХХҮГ	НБХ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	11 аж ахуйн нэгж, байгууллага	15 аж ахуйн нэгж, байгууллага	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Ажил олоход хүндрэлтэй 29 иргэнийг ажлын байраар ханган нийгмийн даатгалын шимтгэл, цалин хөлсийг тасралтгүй 12 сараас дээш хугацаагаар олгож, байнгын ажлын байраар ханган ажилласан 23 аж ахуйн нэгж, байгууллагад нийт 136.1 сая төгрөгийн урамшууллыг 2020-2022 онуудад олгосон. 2022-2023 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ажил олгогчийн урамшуулалд 12 сараас дээш хугацаагаар 6 иргэнийг ажлын байраар хангасан 6 аж ахуйн нэгжид 28.3 сая төгрөгийн урамшуулал олгосон. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 5 ажил олгогч, аж ахуй нэгж байгууллага 6 ажлын байранд гэрээ байгуулан ажиллаж байна.	73.3%

60	2.2.9.Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.	Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, бодлого арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон ТББ, ААНБ, иргэдийн үйл ажиллагааг уялдуулах	2020-2024	ХХҮГ	ХАБЭА-н аймгийн салбар зөвлөл	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	20.0	20	-	Орон нутгийн төсөв 20.0	Аймгийн ХАБЭА-н зөвлөлөөс 2020-2022 онд нийт 42 үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Үүнд: -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 16 төрлийн видео бичлэг, хүүхдийн аюулгүй байдлын талаарх 9 төрлийн видео зөвлөмж, хийлгэн орон нутгийн 4 телевиз болон цахим хуудсаар түгээсэн. Мөн 6 төрлийн шторк, 153 төрлийн постер, 11 төрлийн Баннер зэргийг хийж цахимаар болон байршуулан ажиллахад давхардсан тоогоор 30.000 аж ахуй нэгж байгууллагын ажилтан, иргэдэд хүргэж ажилласан. -2020 онд 8 аж ахуйн нэгж, байгууллага, 2021 онд Эрчим хүчний салбарын 5 аж ахуйн нэгж байгууллагын 1300 гаруй ажилтан, 2022 онд Эрүүл мэнд, боловсролын салбарын 37 аж ахуйн нэгж байгууллагын 1909 ажилтаныг хамруулан хуулийн хэрэгжилт, үзлэг шалгалт зохион байгуулсан. -Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч шилдэг байгууллагуудыг 3 жилийн хугацаанд зохион байгуулж нийт 15 аж ахуй нэгж байгууллагыг шалгаруулж, тухайн байгууллагуудын сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх үүднээс видео бичлэг болон постер, баннер зэргийг хийсэн. Тайлант онд "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу сургалт, уулзалт, зөвлөгөөн, хурал, холбогдох байгууллагуудаас санал авах дээд шатны байгууллагуудад хүргүүлэх, видео бичлэг хийх зэрэг 18 ажлыг 100% хийж гүйцэтгэсэн. -Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сарын аян, сургалт, улсын үзлэг зохион байгуулах, уулзалт хэлэлцүүлэг хийх, туршлага түгээн дэлгэрүүлэх зэрэг 9 ажлыг 100% гүйцэтгэлтэй хийсэн. Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу 4 дүгээр сард "Эрүүл аюулгүй ажил-бидний суурь эрх" уриатай сарын аяныг Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо ТББ, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулж 3.0	100%
----	--	---	-----------	------	-------------------------------	--------------------	----------------------------	------	----	---	-------------------------	--	------

											сая төгрөг зарцуулсан. Аж ахуй нэг байгууллагуудад "Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эрх" уриан дор "Ажил олгогчийн эрх, үүрэг, Үйлдвэрлэлийн осол гарах шалтгаан нөхцөл, стандартууд болон оффест суудаг ажилтнууд, дэлгэцийн донтолтоос үүдэж эрүүл мэндэд ямар хор уршиг үзүүлж байгаа талаар 3 төрлийн зөөврийн самбарыг 21 байгууллагын 3491 ажилчид болон иргэд уншиж, танилцаж, мэдлэг мэдээлэл өгсөн. ХАБЭМТөвийн баг бүрэлдэхүүн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн чиглэлээр мэдээлэл өгөх, сургалт хэлэлцүүлэгт нийт 50 хүн оролцлоо. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлын хүрээнд 14 ААНБ-ын 380 албан журмаар даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн. ХАБЭА-н талаарх суурь мэдлэг, хууль эрх зүйн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. 2023 оны 04 дүгээр сарын 28-нд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Үйлдвэрлэлийн осолд амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийн арга хэмжээг зохион байгуулсан. "Нэн тэргүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал" сэдэвт үндэсний зөвлөгөөнд нийгмийн түншлэлийн талуудаас төлөөлөл оролцож, "Орон нутаг дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд" сэдвээр илтгэл тавьсан. Аймгийн ХАБЭА-н зөвлөл нь ажлаараа сүүлийн 2 жилд дараалан улсад тэргүүлсэн амжилтыг гаргасан.		
ГУРАВ.БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖИЛ													
	БОЛОВСРОЛ												
61	3.1.Бүх шатны боловсролын байгууллагын багш суралцагчдын сурч хөгжих орчныг сайжруулж, иргэдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэйгээр зохион байгуулан, сургалтын	Ерөнхий боловсролын 1, 2-р сургуулийн өргөтгөл, 16-р сургуулийн спорт заалны барилга, Рашаант багийн 250 хүүхдийн сургууль, Согоот багийн 4-р цэцэрлэгийн өргөтгөл, Яргуйт багийн 150 хүүхдийн цэцэрлэг, ХАА-н Мэргэжил,	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС ААН	Улсын болон орон нутгийн төсөв	7.350.0	-	1 барилга байгууламж эхлүүлэх	Батлагдсан төсвөөр	Улсын төсөв 7720.0 Орон нутгийн төсөв 2300.0	2021 онд Согоот багийн 4-р цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилга, Яргуйт багийн 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгууд тус тус ашиглалтад орсон. 2022 онд улсын төсвийн 5.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 дүгээр сургуулийн өргөтгөл, 2023 онд "Ирээдүйн одод" сургуулийн спорт заалны өргөтгөл, Чандмань багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулсан. 3-р сургуулийн барилгыг буулгаж шинээр барих ажилд 2023 онд 2.7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд барилгын ажил 30 хувь, 8-р сургуулийн 320 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилгад 2023 онд 2.7 тэрбум батлагдсан ба одоогоор барилгын ажил 50 хувийн	90%

	чанарыг нэмэгдүүлнэ.	сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрыг ашиглалтад оруулах									гүйцэтгэлтэй байна. ХАА-н МСҮТ-ийн барилгын 1, 2-р давхрын карказ бүрэн цутгагдсан. Тус ажилд 2023 онд 1420.4 сая төгрөг батлагдаж барилгын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. ● Говил багийн 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Рашаант багийн 250 хүүхдийн суудалтай барилга барилгын материалын үнийн огцом өсөлт, санхүүжилт хүрэлцэхгүй шалтгаанаар зогссон. Тус барилгын үлдэгдэл санхүүжилт тус бүр 1.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгахад шаардлагатай нэмэлт баримт, материалуудыг жагсаалтын дагуу гаргаж Үндэсний Аудитын газар, Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн. ● 16-р сургуулийн спорт заалны гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээг цуцалсан. Барилгыг дуусгахад шаардлагатай 879.0 сая төгрөгийн нэмэлт төсвөөс 2024 оны улсын төсвийн төсөлд 277.0 сая төгрөг тусгагдсан.		
62		Сургууль, цэцэрлэгийн барилгад засвар хийх ажлыг үе шаттайгаар хийж, боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС ААН	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	4 барилга байгууламж	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 2676.0	2021 онд 4 сургууль, 5 цэцэрлэгийн засварын ажилд орон нутгийн төсвөөс 1.1 тэрбум, 2022 онд 6 сургууль, 5 цэцэрлэгийн авто зогсоол, барилга сантехникийн засвар, үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 1.24 тэрбум төгрөгийг зарцуулж засвар, үйлчилгээг хийсэн. 2023 онд орон нутгийн төсвөөс дараах 10 сургалтын байгууллагад 2676.0 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийгдсэн. Үүнд: ● Уран эгшиг урлагийн төрөлжсөн сургуульд их засвар хийх 586.7 сая төгрөг ● 1-р цэцэрлэгийн цонх засварлах 73.2 сая төгрөг ● 15-р цэцэрлэгийн цонх засварлах 174.3 сая төгрөг ● Эрх бүжинхэн цэцэрлэгийн радиатор солих 79.9 сая төгрөг ● Ирээдүйн одод сургуулийн спорт заалны өргөтгөл, үндсэн заалыг модон шалтай болгох 950.0 сая төгрөг ● 5-р цэцэрлэгийн фасад засварлах 157.2 сая төгрөг, ● 21-р цэцэрлэгийн фасад засварлах 173.8 сая төгрөг, ● Бялзуухай цэцэрлэгийн фасад засварлах 98.0 сая төгрөг	100%

												• "Унага" цэцэрлэгийн гадна ханын дулаалга хийх 176.8 сая төгрөг • 5-р сургуулийн гадна биеийн тамирын тохижилт хийхэд 206.1 сая төгрөгийг тус тус зарцуулан засвар, тохижилтын ажил хийгдсэн байна.	
63		СӨББ, ЕБС-ийн ачаалал, ээлжийн коэффициентыг бууруулж, анги дүүргэлтийг 35-аас хэтрүүлэхгүй байх	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС	-	-	Ээлжийн коэффициент-1.8 Хамран сургалт-91.1%	Ээлжийн коэффициент-1.6 Хамран сургалт-93%	-	-	2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 20, хувийн хэвшлийн 4, нийт 24 сургуулийн 781 бүлэгт 24751 хүүхэд суралцаж, ээлжийн коэффициент 1.5, анги дүүргэлт 29.2 байгаагаас бага анги 34.1, дунд анги 30.4, ахлах анги 27.7 болж, өмнөх оноос 1.0 хувиар буурсан үзүүлэлттэй байсан. 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн 19, хувийн хэвшлийн 6 сургуулийн 799 бүлэгт 25698 сурагч суралцаж байна. ЕБС-ийн бүлэг дүүргэлтийн дундаж 32.1 байна. Энэ хичээлийн жилд шинээр 1-р ангийн 74 бүлэгт 2405 сурагч суралцаж, бүлэг дүүргэлт 32.5 байгаа бөгөөд төрийн өмчийн сургуулийн хамгийн их суралцагчтай анги 46 хүүхэдтэй байна. 4-р сургуулийн ээлжийн коэффициентыг бууруулахын тулд 1-р сургуульд бага ангийн 4 бүлгийг шилжүүлэн суулгасан. Ингэснээр аймгийн хэмжээнд ээлжийн коэффициент 1.5, анги дүүргэлт 32.1 байгаагаас бага ангийн бүлэг дүүргэлт 1.7 функтээр буурсан үзүүлэлттэй байна. ЕБС-ийн хамран сургалт 93.6 хувьтай байна. СӨББ-ын хамран сургалт 2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 31, төрийн бус өмчийн 8, нийт 39 цэцэрлэгт 8768 хүүхэд үндсэн сургалтад хамрагдсан. 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн 31, төрийн бус өмчийн 6 нийт 37 цэцэрлэгт 9211 хүүхэд сургалтад хамрагдаж, хамран сургалт 98.1 хувь байгаа нь өмнөх оноос 5.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100%
64		"Сургуулийн автобус"-ын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	2022-2024	БШУГ	СӨББ ЕБС	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	8	Чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуульд 1, Баян-Өндөр сумын сургуулиудад 6 автобус 7 чиглэлд 15 сургуулийн 1600 орчим хүүхдэд үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр автобусны 3 нь Даваат, Шанд, Уртын гол, Яргуйт, Наран, Рашаант, Цагаанчулуут багийн хүүхдүүд болон хотын төвийн сургуульд суралцдаг хүүхдүүдийг сургуульд нь хүргэж үйлчилж байна. Тайлант хугацаанд автобусны буудлын тоог 2-оор нэмэгдүүлж, сурагчид гэрийн ойроос үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн. 3-р сургуулийн хичээлийн байрыг "Хийморь" худалдааны төвд	100%

											шилжүүлсэнтэй холбогдуулан Наран, Шанд багаас 3-р сургуулийн дунд, ахлах ангид сурдаг 68 хүүхдийг тус хичээлийн байранд хүргэж байхаар автобусны маршрутыг шинээр гарган батлуулж, алслагдсан багийн хүүхдүүд сургуульдаа автобусаар зорчих боломжийг бүрдүүлсэн.		
65		Өмчийн бүх хэлбэрийн ЕБС, СӨББ-ын сургалтын чанарыг сайжруулж, ЭЕШ-ын чанарыг ахиулах	2020-2024	БШУГ	ЕБС СӨББ	-	-	Сургалтын чанар-80.5% ЭЕШ-507	Сургалтын чанар-84.0%, ЭЕШ-517	-	Орон нутгийн төсөв 23.6	2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтад 1097 төгсөгч бүртгүүлсэн. ЭЕШ-ын чанарыг сайжруулах, сурагчдын ЭЕШ-д амжилттай оролцох бэлтгэлийг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран ЭЕШ-ын 2 удаагийн урьдчилсан сорилыг явуулж давхардсан тоогоор 2163 сурагч хамрагдаж өөрийн сонгосон 3 хичээлээр шалгалт өгсөн. Энэ ажлын үр дүнд ЭЕШ-ын 10 судлагдахууны 9 судлагдахуун дээр аймгийн дундаж өмнөх оноос өссөн. 2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтын 10 судлагдахууны хэмжээст онооны дундаж 553.00 байгаа бөгөөд энэ нь улсын дунджаас 36.00 оноогоор өндөр байна. Хэмжээст онооны дунджийг өмнөх онтой харьцуулахад 2.67 оноогоор өсч, 6 судлагдахууны төрлөөр 12 сурагч 800 оноо, дүйцүүлсэн оноогоор 25 сурагч 800 оноо авсан байна. Төгсөх ангийн сурагчдын Монгол хэл, бичгийн шалгалт 04 дүгээр сард явагдаж, 1135 сурагч хамрагдсанаас 2 сурагч 800 оноо авсан байна. Монгол хэл, бичгийн хичээлийн хэмжээст онооны дундаж 519 байгаа нь улсын хэмжээнд гуравдугаарт эрэмбэлэгдэж байна. Сургалтын чанарыг Боловсролын үнэлгээний төвөөс авсан шалгалтын үнэлгээгээр тооцдог ба 2023 онд аймгийн нийт 5, 9, 12-р ангиудаас авсан шалгалтын дундаж гүйцэтгэлийн хувь 85 хувьтай үнэлэгдсэн.	100%
66		СӨББ-д бүтээмж дээшлүүлэх хөтөлбөр, ЕБС-иудад чанарын удирдлагын системийг нэвтрүүлэх	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	-	-	5 цэцэрлэг, 4 сургууль	5 цэцэрлэг, 4 сургууль	-	-	Тайлант хугацаанд төрийн өмчийн 15 цэцэрлэг буюу нийт цэцэрлэгийн 51.7 хувь нь бүтээмж дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж, харилцан суралцах, туршлага солилцох ажлыг зохион байгуулсан. ЕБС-ийн 4,5,14,15 дугаар сургуулиуд "Тогтвортой хөгжлийн боловсрол- II" төсөлд хамрагдаж, тайлангаа эцэг эх, багш, сурагчдадаа тавьсан. Эдгээр сургуулиуд ажиллах арга хандлагад суралцаж, хамт олны үйл ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэн ажиллаж байна. 5-р сургуулийн хамт олон байгууллагын төлөвлөлт менежментэд олон улсын PDCA /ТХҮС-Төлөвлө-Хий-Үнэл-Сайжруул/	100%

											загварыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба энэ арга зүйгээ аймгийн ЕБС-ийн захирлуудад танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулсан. Сургуулийн өмнөх боловсролын 15 байгууллага 5с буюу бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласнаар шинээр ажилд орсон багш, ажилчдад сургалт зохион байгуулах, үйл ажиллагааны зохион байгуулалтыг танилцуулах, идэвх санаачилгыг дэмжих, ажлын байранд өөрийгөө хөгжүүлэх зэргээр ажлын байран дээрх идэвх санаачилгыг өрнүүлж байна. "Бүтээмжийн хөтөлбөр"-ийг доорх чиглэлээр хэрэгжүүлж байна. Үүнд: 1. Ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах "5S"-ийн арга 2. Ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх чанарын дугуйлан, багийн үйл ажиллагаа 3. Кайзен хандлага, саналын тогтолцоог хэрэгжүүлэх Дээрх цэцэрлэгүүд 7 хоног бүрийн баасан гаригийг "5S" хэрэгжүүлэх "Эмх цэгцийн өдөр" болгон ажиллаж хэвшсэн. Ерөнхий боловсролын 17 сургууль олон улсын PDCA менежментийн загварыг хэрэгжүүлэн ажиллаж, өөрийн байгууллагын үйл ажиллагааг ЕБС-ийн захирлуудад танилцуулах сурталчлах ажлыг зохион байгуулсан. Аймгийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр БШУГ, Эрдэнэт цогцолбор дээд сургууль хамтран боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг бүх шатны боловсролын байгууллагуудад зориулагдсан "Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо MNS ISO 21001:2021 стандарт"-ыг түгээн дэлгэрүүлэх, орон нутгийн боловсролын байгууллагад нэвтрүүлэх зорилго бүхий сургалтын эхний хэсэг "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль дээр 2023 оны 01 сард зохион байгуулж, ерөнхий боловсролын 25 сургууль, 40 цэцэрлэг, нийт 65 байгууллагын 325 удирдах ажилтан хамрагдсан. Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жилийн хүрээнд ерөнхий боловсролын 7,13-р сургууль улсын хэмжээнд PDCA аргачлалыг нэвтрүүлэх 40 сургуульд сонгогдсон. Мөн "Шинэ Монгол" судалгаа, хөгжлийн төвийн "Сургуулийн менежмент" төсөлд	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

											ерөнхий боловсролын 1, 20-р сургуулиуд тус тус хамрагдаж байна.		
67		Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, МСҮТ-үүдэд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах	2022-2024	БШУГ	Их, дээд сургууль МСҮТ	Орон нутгийн төсөв	60.0	-	Дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.	20.0	Орон нутгийн төсөв 15.0	2022 онд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй МУИС-ийн "Эрдэнэт" сургуультай хамтран ажиллах гэрээг байгуулж, ЕБС-ийн гадаад хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх арга зүйн сургалт, семинар, ЕБС-ийн багш нарт эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичих, судалгааны ажил хийх арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, төрийн болон орон нутгийн өмчит төсвийн байгууллагын нягтлан бодогчдод мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтыг зохион байгуулах, аймагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ, хөтөлбөрүүдийн үр ашгийн судалгааг хийж гүйцэтгэх, тайлан, дүгнэлт бичих зэрэг үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Мөн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Эрдэнэт" цогцолбор дээд сургуультай хамтран ЕБС, СӨББ-уудад "Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо-MNS ISO 21001-2021" стандарт нэвтрүүлэх, танилцуулах 3 модуль зохион байгуулж 325 багш, ажилтныг хамруулсан байна. Үүний үр дүнд аймгийн боловсролын байгууллагуудад дээрх стандартыг нэвтрүүлэх, дараагийн шатны үнэлгээнд хамрагдаж баталгаажуулалтын гэрчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2023 онд БШУГ, "Эрдэнэт" цогцолбор дээд сургуультай хамтран Эрдэнэт хотын тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, орон нутгийн нөөц бололцоонд түшиглэсэн гарц шийдлийг эрэлхийлэх, шинэ санал санаачилга дэвшүүлэх, харилцан туршлага солилцох, бүс нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнг сурталчлах зорилгоор "Эрдэнэт хотын тулгамдсан асуудал, гарц шийдэл" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. Мөн БШУГ, "Эрдэнэт" цогцолбор дээд сургуулийн багш, ажилтнуудыг ӨМӨЗО-ны Бугат хотын Төмөрлөгийн үйлдвэр, тус үйлдвэрийн харьяа ШУТИС-тай танилцуулж, туршлага судлуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	100%
68		Багшийн мэргэжил дээшлүүлэх Институтын "Хамтдаа хөгжье"	2021-2024	БШУГ БМДИ	СӨББ ЕБС	Орон нутгийн болон байгуул	9.0	-	Үйл ажиллагааг түгээх	2.0	-	"Хамтдаа хөгжье" хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн 2-4, 6-9 дэх жилдээ ажиллаж байгаа багш нарт зориулсан "Эрдэнэтийн чадварлаг багш" орон нутгийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж	100%

		хөтөлбөрт 3 цэцэрлэг, ерөнхий боловсролын 3 сургуулийг хамруулах				лагын төсөв, төсөл хөтөлбө р					өмчийн бүх хэлбэрийн сургууль, цэцэрлэгийг хамруулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 8 төрлийн сургалтыг зохион байгуулж, 1-4, 6-9 дэх жилдээ ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн 24 сургууль, 40 цэцэрлэгийн 486 багшийг хамруулж, мэргэжил арга зүйг дээшлүүлсэн 2023 онд Боловсролын Ерөнхий газартай хамтран зохион байгуулсан 1, 5, 10 дахь жилийн үндсэн сургалтад 13 судлагдахуунаар 24 сургуулийн 193 багш хамрагдаж ирц 77.5%, СӨББ-ын 40 цэцэрлэгээс 86 багш, СӨББ-ын арга зүйч, эрхлэгч, ЕБС-ийн нийгмийн ажилтан, сургалтын менежер, захирал 59 удирдах ажилтан, нийт 350 багш, удирдах ажилтан тус тус хамрагдаж мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн байна.		
69	3.1.1.Суралцагчдыг бие даан бүтээлчээр суралцах боломж олгох, дээд болон мэргэжлийн боловсрол эзэмшихэд бэлтгэх зорилготой уян хатан сургалтын хөтөлбөрийг сурагчдад сонголт хийх боломжтойгоор хэрэгжүүлнэ.	ЕБС-иудын ахлах ангийн суралцагчдад инженерийн боловсрол, ажил мэргэжлийн баримжаа олгох сургалтыг орон нутгийн их, дээд сургуулиудыг түшиглэн зохион байгуулах	2021-2024	БШУГ	Их, дээд сургуулиуд	Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	6.0	-	Сургалт үйл ажиллагааг зохион байгуулна.	2.0	-	Аймгийн хэмжээнд 6-9-р ангийн сурагчдад өөрийгөө таньж мэдэх, ирээдүйн мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, 10-12-р ангийн сурагчдад ирээдүйн мэргэжлийн дагуу сургалтын хөтөлбөрийг судлах, мэргэжилд өөрийгөө бэлтгэх, их дээд сургуульд элсэх бэлтгэлийг хангах зорилгоор ЕБС-ийн сурагчдад зориулсан "Мэргэжил сонгох хөтөлбөр"-ийг боловсруулж 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид, оюутан залуучуудад "Тэтгэлэг залуус бидний амьдралд" цахим аян-2021" цахим үйл ажиллагааг зохион байгуулж 10-12-р ангийн сурагчдад болон их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудад мэргэжлээ хэрхэн сонгох талаар, гадаадын 7 улсын Засгийн газрын тэтгэлэг, түүнд хэрхэн хамрагдах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хүрээнд БШУГ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулиас хамтран "Мэргэжил сурталчлах аялал"-ыг 2 дахь жилдээ зохион байгуулж байна. Уг үйл ажиллагааны хүрээнд инженерийн болон нийгмийн ухааны чиглэлээр мэргэжил сонгосон нийт 876 суралцагч хамрагдахаас 769 суралцагч хамрагдаж 87.8 хувийн ирцтэй оролцсон. Сурагчид "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ил уурхай, "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийн хичээлийн анги танхим, лаборатори, номын сантай танилцаж мэргэжлийн ур чадвар, ажил мэргэжлийн чиг баримжааны талаар танилцуулга зөвлөгөө авч, сонирхсон асуултдаа хариулт авсан.	100%

											2023 оны 05 дугаар сард төгсөх ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтын чиглэл олгох, ЭЕШ-д бэлтгэх чиглэлээр зөвлөгөө өгөх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийг Амарын талбайд зохион байгуулж, Улаанбаатар хотын 6 их, дээд сургууль, 8 сургалтын төв, орон нутгийн их дээд сургууль, сургалтын төвүүд үйл ажиллагаагаа сурталчилсан бөгөөд тус өдөрлөгт давхардсан тоогоор 3567 иргэд, төгсөгчид хамрагдаж, мэдээллээр хангагдсан. Мөн 2023-2024 оны хичээлийн жилийн эхэнд ерөнхий боловсролын сургуулийн 10-12-р ангийн 3972 сурагчдаас мэргэжил сонголтын судалгааг авч нэгтгэн судалгааны үр дүнд тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг төлөвлөгөөг боловсрууллаа. Тайлант хугацаанд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх 23 цагийн сургалтыг БШУГ-аас зохион байгуулж 978 багш, 111 удирдах ажилтан хамрагдсан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн нийт 421 анги удирдсан багш, сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох талаарх сургалтыг аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран зохион байгууллаа.		
70		ЕБС-иудын ахлах ангиудад байгалийн ухаан, математик, гадаад хэл, техник технологи, спорт, эрүүл мэнд, ёс зүй, урлагийн боловсрол олгох сургалтыг төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	6.0	-	Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2.0	Орон нутгийн төсөв 591.0	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын захирамжаар "Уран элшиг" урлагийн төрөлжсөн сургалттай сургууль байгуулж, орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хичээлийн байрны асуудлыг шийдвэрлэж, шаардлагатай техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангасан. Тус сургуульд ятга, шанз, ёочин, хуучир, морин хуур, лимбэ, төгөлдөр хуур, уран нугаралт, уран зураг, дизайн, драм гэсэн урлагийн 13 хөтөлбөрөөр 1-12 дугаар ангийн 350 сурагч хичээллэж байна. Мөн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр "Эрүүл хүүхэд", спорт, техник технологи, урлагийн боловсрол олгох чиглэлээр "Хүүхдийн хөгжил", хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр "Тэгш боломж" төслүүдийг 2022 оноос хэрэгжүүлж, төслүүдийн хүрээнд багш хичээл заах, дугуйлан секц, клуб хичээллүүлэх багш нарыг Улаанбаатар хотод туршлага судлах үйл ажиллагаа, сургалтуудад үе шаттайгаар хамруулсан. Мөн "Тэгш боломж" төслийн хүрээнд 1, 7, 20 дугаар сургуулиудад "Хөгжлийн	100%

											бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв", 4 дүгээр сургуульд "Эрүүл мэндийг дэмжих төв" байгуулагдаж, ерөнхий боловсролын 7 сургуульд "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд хөгжим, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнүүд нийлүүлэгдсэн байна. Дээрх 3 төслийг 2023 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. "Тэгш боломж" төслийн хүрээнд 2, 4, 13 дугаар сургуульд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төв", "Эрүүл хүүхэд" төслийн хүрээнд 15 дугаар сургуульд "Эрүүл мэндийн жишиг кабинет" байгуулагдаж, "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудад хөгжим, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнүүд нийлүүлсэн байна. Төслийн хүрээнд багш, сурагчдад чиглэсэн сургалт үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.		
71		Залуучуудын ордныг түшиглэн "Залуу зохион бүтээгчдийн төв" байгуулах	2022-2024	ГБХЗ ХГ БШУГ	"Эрдэ нэт үйлдвэр" ТӨҮГ "Эрдэ нэт цогцолбор" сургууль "ШУТ П"	Орон нутгийн болон байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Үйл ажиллагааг тогтворжуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Залуучуудын ордны дэргэдэх unitel hub төвд робот угсралт, програмчлалын robo kid сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, 40 сурагчийг хамруулан тэдний STEAM боловсролыг дэмжихийн зэрэгцээ, смарт юмс хэрхэн бүтээгддэгийг ойлгох, төхөөрөмжийг угсрах явцад техник сэтгэлгээ, зохион бүтээх чадвар, авьяасыг хөгжүүлснээр одоогийн байдлаар 13 сурагчид Robo kid Робот угсралт инженерчлэл, кодчиллын анхан шатны сертификатыг олгоод байна. 14 дүгээр сургуульд хэрэгжиж байсан залуу зохион бүтээгчдийн "Хос нислэг" клубтэй хамтран техник, загварын спортоор дамжуулан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын техник сэтгэлгээ, инженер сэтгэлгээ, зохион бүтээх чадварыг хөгжүүлэх "Би инженер" төслийг Залуучуудын ордны дэргэд хичээллүүлэхээр өрөө, танхимыг тохижуулж, хичээллэх бэлтгэл ажлыг хангаж байна. "Би инженер" төсөлд хамрагдан хичээллэж байсан 1 сурагч Техник технологийн улсын олимпиадад оролцож 2 дугаар байранд орсон амжилтыг үзүүлээ.	50%
72	3.1.2.Бүх шатны боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж.	ЕБС, СӨББ-ыг "Тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага" болоход дэмжлэг үзүүлж "Ногоон	2020-2024	БШУГ	БШУЯ БОАЖ Я	Орон нутгийн төсөв, олон улсын төсөл	48.0	-	4 сургууль, 4 цэцэрлэг	16.0	-	БОАЖЯ, БШУЯ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Байгаль орчин сургалт мэдээллийн төвтэй хамтран хэрэгжүүлсэн "Тогтвортой хөгжлийн боловсрол- II" төсөл аймгийн хэмжээнд 4 сургуульд амжилттай хэрэгжсэн. Үүнд: - 4-р сургууль "Ардын ёс заншил" төсөл - 5-р сургууль "Дотоод агаарын чанар" төсөл	90%

	суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлнэ.	хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх				хөтөлбөр					- 14-р сургууль "Цахилгааны хэмнэлт" төсөл - 15-р сургууль "Байгалийн ухаан" төсөл Дээрх 4 сургуулиас олон улсын "Эко сургууль"-ийн алтан гэрэгэ, ногоон тугийн болзлыг 14, 15-р сургуулиуд, хүрэл гэрэгэний болзлыг 4, 5-р сургуулиуд тус тус хангасан. Эдгээр төслийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, сургуулиуд төслийн үр дүнгээ улсын хэмжээнд тайлагнасан. Мөн тайлант хугацаанд олон улсын "Эко сургууль, цэцэрлэг"-хөтөлбөрт 4, 15, 26-р цэцэрлэг, Орхон МСҮТ хамрагдаж, болзлоо ханган батламж авсан. "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төсөлд хамрагдсан сургуулиуд байгаль, нийгэмд ээлтэй сургуулийн орчныг бүрдүүлж, суралцагчдад экологийн боловсрол олгох жишиг сургалтын хөтөлбөртэй болж хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байна.		
73		Ерөнхий боловсролын сургуулиудад “Цахим сургууль” программыг нэвтрүүлж, сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулах	2020-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	-	-	3 сургууль	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Тайлант хугацаанд 1, 7, 8-р сургуулиуд "Moodle систем", 5, 13-р сургуулиуд "Их нүүдэл" системийг нэвтрүүлэн цахим сургалтын технологийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд багш нар цахим хичээл бэлтгэн байршуулж, сурагчийн хичээлийн оролцоо нэмэгдэж, хичээл сургалтын үйл ажиллагаан дахь эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоо сайжирсан. Боловсролын үйлчилгээг цахимжуулах, оновчтой төлөвлөлт, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Боловсролын мэдээллийн технологийн төв"-ийн esis.edu.mn үндсэн системд төрийн болон төрийн бус өмчийн 25 сургууль, 39 цэцэрлэгийг статистик мэдээллийн баазад нэгтгэж, сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох цахим системийг боловсронгуй болгож, сургалт, хүмүүжил, төлөвшлийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо, хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж байна. 2023 онд "Мэдлээ" цахим сургуульд 17 сургуулийн 10 дугаар ангийн 432 сурагч, 14 судлагдахуунаар суралцаж байна. Урьдчилсан хичээл сонголтыг ерөнхий боловсролын 24 сургуулийн 9 дүгээр ангийн 68 бүлгийн 2048, 10 дугаар ангийн 1613 сурагч student.medle.mn хичээл сонголт хийсэн. Хичээл сонголтод дүн шинжилгээ хийж үзэхэд Англи хэл, Математик, Монгол хэл судлагдахууныг сурагчид анги нийтээр сонгох, Физик. Хими. Нийгмийн ухаан судлагдахууныг	100%

												ангийн 50-60% нь сонголт хийсэн байна. 2023-2024 оны хичээлийн жилд сонголтын бүлэг үүсч буй сургуулиуд танхимаар, сонголтын бүлэг үүсээгүй сургуулиуд судлагдахуунаар "Мэдлээ" цахим сургуульд сурагчдыг хамруулан суралцуулж байна. Төрийн өмчийн ерөнхий боловсролын 16 сургуулийн 3-4-р ангийн 4541 сурагч, 117 багш математикийн “Эдүтэн” улсын хэмжээний туршилтад сонгогдсон. Ерөнхий боловсролын 14-р сургуулийн 5-10-р ангийн сурагчид болон төрийн өмчийн 17 сургуулийн 5-6-р ангийн 4407 сурагч, 75 багш англи хэлний судлагдахуунаар “Персон” хөтөлбөрийн цахим платформыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
74		ЕБС, СӨББ-ыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлоор хангаж сургалтын орчныг сайжруулах	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	4 сургууль, 4 цэцэрлэг	Батлагдсан төсвийн хүрээнд	улсын төсөв 1000.0 орон нутгийн төсөв 3023.3	2023 онд ЕБС, СӨББ-ыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлоор хангаж сургалтын орчныг сайжруулах ажлын хүрээнд доорх ажлууд хийгдсэн. Улсын төсвөөс: ● Сургуулийн өмнөх боловсролын 31 байгууллага, ерөнхий боловсролын 17 сургуулийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног, төхөөрөмжөөр хангах 1.0 тэрбум, Орон нутгийн төсвөөс: ● "Хүүхдийн хөгжил" төслийн хүрээнд ЕБС-иудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах 241.0 сая төгрөг, ● "Эрүүл хүүхэд" төслийн хүрээнд ЕБС-ийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах 50.0 сая төгрөг, ● "Тэгш боломж" төслийн хүрээнд ЕБС-иудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах 150.0 сая төгрөг, ● Боловсрол хөтөлбөрийн хүрээнд ЕБС-д сандал ширээ худалдан авах 2.175.0 сая төгрөг, ● "Уран эгшиг" урлагийн сургуульд шаардлагатай тоног, төхөөрөмж, эд хогшил худалдаж авах 345.0 сая төгрөг, ● 26-р цэцэрлэгт гал тогооны шаардлагатай тоног төхөөрөмж авах 22.3 сая төгрөг ● 11-р цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдаж авах 40.0 сая төгрөг тус тус зарцуулсан.	100%
75	3.1.3.Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, хүмүүжил	Хүүхдийн “Хөдөлмөр зуслан” байгуулах ажлыг санаачлан	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл	Батлагдсан төсвийн	-	Санаачилгыг дэмжинэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 36.0	Эрдэнэ багт байрлах “Ёс заншлын өргөө”-ний дэргэдэх хөдөлмөр зуслан зуны турш 8 ээлжээр 400 гаруй хүүхэд хүлээн авч “Би монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ногоо тарих арчлах, мал	70%

	төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах агуулга бүхий орон нутгийн онцлогт тохирсон төслийг төсөл, хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	хэрэгжүүлж буй төрийн болон ТББ, ААН, иргэнийг дэмжиж хамтарч ажиллах				хөтөлбөр	хүрээнд				маллах арга ухаанд сургах, үндэсний ёс заншил зан үйлд сурах, эх оронч үзэл төлөвшүүлэх, малын түүхий эд боловсруулах зэрэг 5 чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсан. Булган аймгийн Бугат сумын нутагт баригдаж буй "Эрдмийн Сан" сургуулийн дэргэдэх хөдөлмөр зуслангийн бүтээн байгуулалтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Тус зуслан ашиглалтад орсноор 1 ээлжинд 120-160 хүүхэд амарч амьдрах арга ухаан, хөдөлмөр, ёс заншил, өв уламжлалаасаа суралцах боломж бүрдэнэ. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Энэрэл" зусланд тус төвийн 60 хүүхэд 2 сарын хугацаанд амарч хүнсний ногоо тариалах, цагаан идээ боловсруулах зэрэг амьдрах ухааны сургалтуудад хамрагдсан.		
76		"Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2020-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	20.0	-	Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	5.0	Орон нутгийн төсөв 23.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор "Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж 4 зорилтын хүрээнд 13 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж 84.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. "Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 31 үйл ажиллагаатайгаар батлуулж, "Монгол хэлний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагын үүрэг оролцоо" уулзалт, зөвлөгөөн, төрийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад зориулсан "Албан хэргийг хос бичгээр үйлдэх стандарт, монгол бичгээр эх бэлтгэх арга зүй" сургалт, "Үндэсний бичиг үсгийн өдөр"-ийн арга хэмжээ, аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтарсан захиалгат сургалтууд, 6-12 дугаар ангийн сурагчдын анги нийтийн чанарын уралдаан зэрэг нийт 31 ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж 82.3 хувьтай үнэлэгдсэн. "Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар 4 зорилтын хүрээнд 28 үйл ажиллагаатайгаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласнаар 85.4 хувийн хэрэгжилттэй байна. Хөтөлбөрийн хүрээнд "Үндэсний бичиг үсгийн баяр -2023" арга хэмжээ, 9 дүгээр ангийн Монгол хэлний хичээлийн анги нийтийн уралдаан, "Амьд бичиг" уран бичлэгийн уралдаан, ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчдын дунд "Үндэсний бичгийн үсэглэлийн аварга шалгаруулах уралдаан".	85.4%

											Монгол бичгийн захиалгат сургалтууд зэрэг арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Хөтөлбөрийн хүрээнд явагдсан захиалгат сургалт, багш нартай хамтран зохион байгуулсан сургалтуудад 10 байгууллагын 250 гаруй албан хаагч хамрагдаж үндэсний бичгийн боловсролоо дээшлүүлсэн байна.		
77		Олон улс, улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцох багш, сурагчдад дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Дэмжлэг үзүүлж, урамшуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 6.3	Тайлант хугацаанд "Ковид-19" цар тахлын улмаас улс, олон улсын олимпиадын сорилгууд цахим хэлбэрээр явагдаж, математикийн хичээлээр 2, физикийн хичээлээр 1, химийн хичээлээр 1 сурагч тус тус шалгарч олон улсын олимпиадын нэгдсэн бэлтгэлд хамрагдсан. Улсын математикийн олимпиадаас 2 сурагч мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн. 2022 онд улсын төрөлжсөн олимпиадын II даваанд сурагчийн төрөлд 9 судлагдахууны 20 төрлөөр 509 сурагч, багшийн төрөлд 9 судлагдахууны 9 төрлөөр 278 багш оролцлоо. Багийн дүнгээр Эрдмийн сан, 14, 4 дүгээр сургууль эхний байруудыг эзэлсэн. Олимпиадын II даваанд эхний 3 байрт шалгарсан 61 сурагч, 27 багшийг орон нутгийн төсвөөс 4.2 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Олимпиадын III даваанд 9 судлагдахуунаар 24 сурагч, 10 багш оролцсоноос 1 алт, 7 хүрэл, нийт 8 медаль хүртсэн. 2022 онд улсын олимпиадад оролцож медаль хүртсэн 9 сурагч, 5 багш, сурагчдыг бэлтгэсэн багш нарт 4.0 сая төгрөгийн, 2023 онд улсын олимпиадад оролцож медаль хүртсэн 7 сурагч, 2 багш, сурагчдаа бэлтгэсэн багш нарт 2.3 сая төгрөгийн урамшуулал тус тус олгосон байна.	100%
78		Үндэсний ёс заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах агуулга бүхий цахим контентыг хийх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Цахим контент хийнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Тайлант хугацаанд олон улсын эко сургууль, цэцэрлэг төсөлд хамрагдаж буй 4, 5, 14, 15 дугаар сургуулиуд өөрийн онцлогтой ардын зан заншил, байгаль экологийн боловсрол олгох, амьдрах арга ухаанд сургах хөтөлбөртэй болж, аймаг, улсын хэмжээнд туршлагаа түгээн дэлгэрүүлэн ажиллаж байна. Дээрх 4 сургуульд хэрэгжүүлж буй "Ардын ёс заншил", "Дотоод агаарын чанар", "Цахилгааны хэмнэлт", "Байгалийн ухаан" төслийн хүрээнд БОАЖЯ, БШУЯ, Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв, Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран цахим контент хийж олон нийтийн хүртээл болгон, БОАЖЯ-ны төлөөллийг	100%

											оролцуулан аймгийн хэмжээнд үзүүлэх ажил зохион байгуулсан. 2023 онд Баян-Өндөр сумын ИТХ, БШУГ хамтран "Суралцагч хот хөтөлбөр"-ийн хүрээнд СӨББ-ын хэмжээнд бага насны хүүхдийг үндэсний ёс заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаан, зөв дадал хэвшилд сургах зорилготой цахим контентыг хийж олон нийтэд хүргэсэн. Мөн "Найз байя" аяныг өрнүүлж, зам тээврийн осол, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх агуулга бүхий 5 цахим контент бэлтгэж түгээсэн байна. 27-р цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар 8 цуврал подкаст бэлтгэж эцэг, эх, асран хамгаалагчид хүргэснээр 350 хандалт авч, 113 хүн хуваалцсан байна.		
79		Боловсролын чиглэлээр улс, бүсийн чанартай 1-ээс доошгүй арга хэмжээг жил бүр орон нутагтаа зохион байгуулах (Олимпиад, уралдаан, тэмцээн, хурал, зөвлөгөөн)	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	1 арга хэмжээ зохион байгуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 39.9	2022 онд улсын Нийгмийн ухааны 24-р олимпиадыг зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн 30 багш, 30 сурагч оролцсоноос Орхон аймгийн 14-р сургуулийн багш О.Эрдэнэболд III байранд шалгарсан. Олимпиадыг БШУЯ, аймгийн ЗДТГ, БШУГ, МУБИС, 14-р сургууль хамтран зохион байгуулсан ба олимпиадын зардалд орон нутгийн төсвөөс 39.5 сая төгрөг зарцуулсан. 2023 онд улсын биологийн 33 дугаар олимпиадыг зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн, нийт 60 сурагч, 31 багш оролцож орон нутгийн төсвөөс 39.9 сая төгрөг зарцуулсан байна. Олимпиадын хүрээнд аймаг, орон нутгаа улсын хэмжээнд сурталчилж, орон нутгийн аж ахуй нэгж байгууллагуудыг дэмжиж хамтарч ажилласан. Мөн биологийн шинжлэх ухааныг орон нутгийн хэмжээнд сурталчилж, энэ чиглэлийн мэргэжлийн багш нарыг чадавхжуулах үйл ажиллагааг МУИС-тай хамтран зохион байгуулсан.	100%
80		ЕБС-иудад Хүүхдийн хөгжил, төлөвшлийн ажилтнуудыг үргэлжлүүлэн ажиллуулж, сэтгэл зүйч мэргэжилтэй боловсон хүчнээр хангах	2020-2024	БШУГ	ЕБС	-	-	17	Сэтгэл зүйч ажиллуулах 2 сургуульд	-	-	Тайлант хугацаанд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 17 тэгш боломж, хүүхдийн хөгжил хариуцсан ажилтан, 19 сэтгэл зүйч ажиллаж байна. БШУЯ-ны мэргэшүүлэх сургалтад 11 сэтгэл зүйч хамрагдаж "Боловсролын сэтгэл зүйч" мэргэжил эзэмшсэн байна. ЕБС-ийн сэтгэл зүйчид сэтгэл зүйн гарааны үнэлгээг 2601 сурагч, 170 эцэг эх, асран хамгаалагч, 306 багш, 21 удирдах ажилтанд, сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг 1421 сурагч, сэтгэл зүйн бүлгийн сургалтыг 17000 гаруй сурагч, 1334	100%

											багш, 68 удирдах ажилтанд явуулж сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн 848 сурагчид хувийн хэрэг нээж ажилласан. Мөн ЕБС-ийн сэтгэл зүйчид "Сонсьё, Хайрлая, Мэдэрьё" сэтгэл зүйн өдөрлөгийг цувралаар зохион байгуулж, иргэд олон нийтэд сэтгэл зүйн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан. Тайлант хугацаанд ерөнхий боловсролын сургуулиудад захирал, нийгмийн ажилтан, хүүхэд төлөвшлийн ажилтан, сэтгэл зүйч нарын хамтарсан "Нийгэм сэтгэл зүйн алба"-ыг байгуулан ажилласнаар хүүхэд хамгааллын бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн. Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй сэтгэл зүйчдийн 84.2 хувь нь "Боловсролын сэтгэл зүйч" байна.		
81		Хүүхдийг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим хэрэглээний зохист байдлыг бий болгох сургалтуудыг ЕБС-ийн хэмжээнд тогтмол зохион байгуулах	2021-2024	БШУГ	ЕБС	Орон нутгийн төсөв, байгууллагын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	ЕБС-уидаа жилд 2 удаа	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Тайлант хугацаанд БШУГ, ГБХЗХГ хамтран "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийг эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч, олон нийтэд сурталчилж, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, постер, шторк бэлтгэн цахимаар олон нийтэд хүргэсэн. Мөн ЕБС-ийн сэтгэл зүйчид хамтран хүүхдийг цахим гэмт хэргийн золиос болох, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг хийж, хөл хорионы үеийн нийгэм, сэтгэл зүйн айдсыг даван туулах дэмжлэг бүхий 15 хичээлийг цахим орчинд байршуулж 1669 хүнд хүргэсэн байна. 2022 онд уг ажлын хүрээнд 2 сургалт, 2 нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Үүнд: - "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээний хүрээнд ГБХЗХГ, Цагдаагийн газартай хамтран "Цахим орчны зохистой хэрэглээ-донтолт болох нь" уулзалтыг зохион байгуулж, дунд болон ахлах ангийн 130 сурагч хамрагдсан. - Анги удирдсан багш, эцэг эх, асран хамгаалагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр танхимын сургалтыг хийж, 15674 багш, эцэг эх хамрагдсан. - Цахим орчны зөв хэрэглээ, дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ЕБС-иудын хүүхэд хамгааллын баг нийт 57 зурагт хуудсыг цахим орчинд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна. Боловсрол, шинжлэх ухааны газраас 2022 оны 9,10 дугаар саруудыг "Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг бууруулах сар" болгон зарлаж	100%

												сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. 2023 онд аймгийн Цагдаагийн газартай хамтран 6-12 дугаар ангийн "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийн цагаар цахим халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Энэхүү сургалтад өмчийн бүх хэлбэрийн 25 сургуулийн 283 бүлгийн 9905 хүүхэд хамрагдсан. Сургууль тус бүр ГБХЗХГ болон Цагдаагийн газартай хамтран "Цахим орчны зохистой хэрэглээ-донтолт болох нь" уулзалтуудыг зохион байгуулж, ахлах ангийн сурагчид эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулсан. Мөн энэ чиглэлээр сургуулиудын "Хүүхэд хамгааллын баг" нийт 57 зурагт хуудсыг цахим орчинд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна.	
82	3.1.4.Бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх, урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.	"Багш" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж бүх шатны боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих	2021-2024	БШУГ	СӨББ,ЕБС, Их, дэд сургууль, МСҮТ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 75%-д хүргэнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 180.0	"Багш" хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны А/306 дугаар захирамжаар 3 зорилтын хүрээнд 21 үйл ажиллагаа төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. Хөтөлбөрийн хүрээнд ЭЕШ-ын чанарыг сайжруулах чиглэлээр төгсөх ангийн сурагчдын ЭЕШ-ын урьдчилсан 2 удаагийн сорил, аймгийн мэргэжлийн зэрэгтэй багш нарыг түшиглэн залуу багш нарын арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг хангах "Ментор багш" төсөл, 2,3,4 болон 6,7,8,9 дэх жилдээ ажиллаж байгаа багш нарт зориулсан модуль сургалт, аймгийн "Зөвлөх баг"-тай хамтарсан багшийн арга зүйг оношлох, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа, "Боловсролын шинэ сэргэлт-Сургуулийн менежмент " сэдэвт багш удирдах ажилтны сургалт, хэлэлцүүлэг, багш нарын "Мэргэжлийн хөгжлийн бүлэг"-ийг дэмжсэн үйл ажиллагаа, "Ур чадварын уралдаан", "Чадварлаг багш" үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Мөн аймгийн Насан туршийн боловсролын төвийн багш, ажилтнуудыг Улаанбаатар хотод мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамруулах болон 4, 14 дүгээр сургуулийн 4 багш, ажилтныг Япон, Герман, Солонгос улсад богино хугацааны сургалт, туршлага судлах үйл ажиллагаанд хамруулахад тус тус дэмжлэг үзүүлсэн байна.	90%

												Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр тус хөтөлбөр 90 хувийн хэрэгжилттэй байна.	
83		Орон нутгийн онцлогт тохируулан сургууль, цэцэрлэг, багшийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх аргачлал боловсруулан хэрэгжүүлж, сургалтын чанар ажлын үр дүнгээр шалгарсан багш нарыг урамшуулах	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв	40.0	20 багш	20 багш ажилтан	10.0	Орон нутгийн төсөв 14.8	Тайлант хугацаанд багшийн ажлын үр дүнг үнэлж, дүгнэх аргачлал боловсруулж Боловсролын газрын даргын тушаалаар баталсан. Уг аргачлалын дагуу сургалтын чанарыг дээшлүүлсэн 35 багш, эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд тэргүүлсэн 12 удирдах ажилтан, амжилт гаргаж ажилласан 56 багш, 9 байгууллагыг шагнаж урамшуулсан. Мөн 2021 оны ЭЕШ-д сурагчид нь 800 оноо авсан 9 багшийг тус бүр 500.0 төгрөгөөр шагнаж, "Батламж" гардуулсан. 2022 онд ажлын үр дүнгээр шалгарсан болон ЭЕШ, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлсэн 30 багш, удирдах ажилтан, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжин ажилласан төрийн болон төрийн бус 6 байгууллагыг шагнаж урамшуулахад орон нутгийн төсвөөс 12.6 сая төгрөг зарцуулсан байна. 2023 онд ажлын үр дүнгээр шалгарсан болон анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлсэн багш нарыг урамшуулах үйл ажиллагааг "Монголын багш нарын 57 дахь өдөр" -өөр зохион байгуулж 445 багш, ажилтныг шагнаж урамшуулахад 10.8 сая төгрөг зарцуулсан байна. Мөн 2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтад сурагчдаа амжилттай бэлтгэсэн 8 багшийг 4.0 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.	100%
84	3.1.5.Бүх шатны боловсролын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	"Багш" хөтөлбөрийн хүрээнд бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв	-	60 багш, ажилтан	Жилд 60 багш, ажилтан	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвөөр	Орон нутгийн төсөв 19.0	"Багш" хөтөлбөрийн хүрээнд нийгмийн дэмжлэг олгох журмын дагуу 2021 онд 39 багш, ажилтанд 16.7 сая төгрөг, 2022 онд 18 багш, ажилтанд 11.0 сая төгрөг, 2023 онд шинэчилсэн журмын дагуу 36 багш, ажилтанд 19.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон байна.	60%
85	нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Шаардлагатай цэцэрлэгүүдэд багш нарыг 2 ээлжээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	2021-2024	БШУГ	СӨББ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Цэцэрлэгүүдэд багш нарыг 2 ээлжээр ажиллуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсөв 763.6	2022 оны 03-р сарын 01-нээс ачаалал ихтэй 10 цэцэрлэгийн 84 бүлэгт ээлжийн 42 багш ажиллаж эхэлсэн. Ээлжийн багш ажиллаж буй 10 цэцэрлэг өглөө 07:00 цагаас орой 19:00 цаг хүртэл 12 цагаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эцэг, эхчүүд ажил, хөдөлмөрөө тайван эрхлэх боломжийг бүрдүүлсэн. Ээлжийн багшаар ажиллаж буй багш нарыг ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангах ажлын	100%

												хүрээнд сайжруулсан хөтөлбөрийн хэрэгжилт, зөвлөмж, үр дүнгийн талаар сорил, тест боловсруулан шалгалт авч 4 удаагийн чадваржуулах сургалтад хамруулсан. 2023 онд цалин хөлсөнд 763.6 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон.	
86	3.1.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн жирийн ангид шилжин суралцах боломжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн үзүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна.	Багш, ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулах	2021-2024	БШУГ	СӨББ ЕБС	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	4.0	-	2 багш	1.0	-	2021 онд багш нарын мэргэжил дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг чадавхжуулах 14 удаагийн 379 багш, 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт тэгш хамруулах, шаардлагатай хүүхдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр нийт 640 гаруй багшийг тус тус сургалтад хамруулсан. 2023 онд сургууль, цэцэрлэгийн "Дэмжлэгийн баг"-уудын үйл ажиллагаа тогтмолжиж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах ажлын хүртээмж нэмэгдсэн. Орон нутагт энэ чиглэлээр ажиллах боловсон хүчнийг нэмэгдүүлж үндэсний сургагч багш 1, орон нутгийн сургагч багш 60 бэлтгэгдсэн байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 12, ерөнхий боловсролын сургуулиудад 60 гаруй багш "Ганцаарчилсан сургалт"-ын төлөвлөгөөг хэрэгжүүлж, хуульд заасны дагуу үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдлийг олгож байна.	100%
87		Жаргалант сумын сургууль, 7-р сургууль, 27-р цэцэрлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөөх дунд оврын автобустай болгох	2022-2024	БШУГ	СӨББ ЕБС	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	1 автобус	1 автобус	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 130.0	Тайлант хугацаанд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын сургуулийн хүүхдийн автобусыг шинэчилж, COUNTY маркийн дунд оврын автобус, "Тэгш боломж" төслийн хүрээнд 130.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг багийн 27 дугаар цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөөх тусгай зориулалтын "Starrex" маркийн авто машиныг тус тус хүлээлгэн өгч, хүүхдүүдийг цэцэрлэг, сургуульд нь зөөж байна. Ерөнхий боловсролын 7 дугаар сургуульд COUNTY маркийн дунд оврын автобусыг ашиглаж байна. Уг автобусаар тус сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй 49 хүүхдийг зөөвөрлөж байна.	100%
88	3.1.7.Бүх нийтийн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар менежментийг дээшлүүлж, орон	Иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бизнес амьдрах ухаан, ёс суртахуун төлөвшил, гоо зүй,	2021-2024	БШУГ	НТБТ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	15.0	-	Хөтөлбөр хэрэгжүүлнэ.	5.0	-	2022 онд аймгийн Насан туршийн боловсрол төв 5 агуулгын хүрээнд 82 хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, 70 гаруй аж ахуй нэгж, байгууллагын 4249 хүнд сургалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлж, 11757 орчим иргэнийг нөлөөллийн ажилд хамруулсан.	100%

	нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэн "Насан туршийн боловсрол төв"-ийг хүн амын насан туршийн боловсролыг дэмжигч, мэдээлэл түгээгч байх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	гэр бүлийн, байгаль орчны, иргэний боловсрол олгох гэсэн чиглэлээр сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж , ардын уламжлалт гар урлал, амьдрах ухааны чиглэлээр шавь сургалтыг иргэдийн дунд зохион байгуулах									2023 онд иргэдийн хэрэгцээнд суурилсан сургалтыг 2 чиглэлээр зохион байгуулж байна. Үүнд: 1. Иргэдийн боловсролын түвшин дээшлүүлэх захиалгат сургалтад гэр бүл, амьдрах ухаан, иргэний, ёс суртахуун, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд 60 гаруй байгууллага, Баян-Өндөр сумын 10 гаруй багийн 5220 иргэнийг хамрууллаа. 2. Үндэсний бичиг, англи хэл, компьютер, шатар, хөгжим, гар урлал, оёдол эсгүүрийн сургалтуудыг иргэдийн хүсэлтээр зохион байгуулж байна. Сургалтыг 15-120 цагаар төлөвлөж нийт 877 иргэн хамрагдсан байна. Тухайлбал: Үндэсний бичгийн сургалтад 12 байгууллагын 290 ажилтан, англи хэлний хэрэглээний 10 удаагийн сургалтад 185 иргэн, компьютерын хэрэглээний анхан ба дунд шатны 16 удаагийн сургалтад 172 иргэн, оёдол эсгүүр 79 иргэн, шатар 120 иргэн, гитар хөгжим 15 иргэн, төгөлдөр хуур хөгжмийн сургалтад 16 иргэн тус тус хамрагдсан байна. Сургалтын 10-30 хувь нь онол, 70-90 хувь нь дадлага, бие даалт хэлбэрээр суралцагч төвтэйгөөр зохион байгуулж амжилттай төгссөн иргэдэд гэрчилгээ гардуулсан.		
89		Насан туршийн боловсролын төвд бүх насны иргэд ашиглах боломжтой цахим сургалтын кабинетыг бий болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2021-2024	БШУГ	НТБТ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	18.0	-	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	6.0	-	Тайлант хугацаанд БШУЯ, Насан туршийн боловсролын үндэсний төв, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" төслийн хүрээнд 18.5 сая төсөвт өртөгтэй цахим сургалтын кабинетын хэрэглэгдэхүүнийг аймгийн Насан туршийн боловсролын төвд нийлүүлсэн.	100%
СОЁЛ УРЛАГ													
90	3.2.Эрдэнэтийн өв соёлыг хадгалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, соёл урлагийн байгууллагын материаллаг бааз, хөрөнгө	Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	6.0	-	Жилд 2-3 уран бүтээлч	1.5	Орон нутгийн төсөв 14.8	Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд 2022 онд 20.0 сая төгрөг зарцуулсан. Энэ ажлын хүрээнд аймгийн Музейн ажилтнуудын Улаанбаатар хотод мэргэжил дээшлүүлэх, Номын төв, сургуулийн номын санчдад зориулсан "Орчин цагийн номын сангийн хөгжлийн чиг хандлага", бүжгийн багш бэлтгэх сургалтуудыг тус тус зохион байгууллаа. Мөн "Соёлыг түгээе" аяны хүрээнд СУИС-тай	100%

	оруулалтыг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг дэмжиж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана.										хамтран аймгийн соёл, урлагийн байгууллагын ажилтнууд, уран бүтээлчид, соёлын төв, ЕБС, СӨББ-ын байгууллагын багш нарыг чадавхжуулах 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 100 гаруй ажилтан, албан хаагчийг хамруулсан. 2023 онд соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах тухай", "Гамшгийн бэлэн байдал", "Хэрэглээний англи хэл", "Авлигын эсрэг хууль", Жендэрийн тэгш байдал, "Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого", "Гэр бүлийн үнэ цэнэ", аймгийн Цагдаагийн газартай хамтарсан "Анзаар", "Соёлын өвийг хамгаалах нь" сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 346 ажилтан, албан хаагч хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд соёл, урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх чиглэлээр Хүүхэд, залуучуудын театрын 14 уран бүтээлчийг мэргэжлийн нүүр хувиргалтын 2 өдрийн сургалтад хамруулсан. Аймгийн Музейгээс Үндэсний музейтэй хамтран төвийн бүсийн музейн ажилтнуудын дунд зохион байгуулсан "Музейн үзмэр дэглэлт, хадгалалт, хамгаалалт", "Музейн үзмэр тайлбарлах арга зүй", "Музейн боловсролын хөтөлбөр" сэдэвт сургалтуудад аймгийн Музейн 9, Соёлын төвүүдийн орон нутаг судлах танхимын 5 ажилтан тус тус хамрагдсан. Мөн "Соёлыг түгээе" аяны хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолбороос аймгийн соёлын төвүүдийн бүжгийн багш, дууны багш, хөгжмийн багш, техникийн ажилчид, номын санчдад соёлын ажлын арга зүй, онол практик хосолсон 5 өдрийн сургалтыг зохион байгуулж 30 ажилтан хамрагдсан байна.		
91		Аймгийн номын төвийн өргөтгөл, Номын өргөө бүхий цогцолбор барилга, Даваат, Наран багуудын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулах, соёл, урлагийн	2020-2024	БШУГ	СУБ	Улсын болон орон нутгийн төсөв	-	-	1 барилга	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 4300.0	Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Даваат багийн соёлын төвийн барилгыг 2021 оны 01 сард ашиглалтад оруулсан. Орон нутгийн төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Номын өргөө бүхий цогцолбор"-ын барилгын ажил дуусч, тохижилтын ажил хийгдээд байна. Мөн улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Наран багийн соёлын төвийн барилгын ажил нэмэлт санхүүжилт	90%

		байгууллагын барилгыг өргөтгөх, шинээр барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулах									шаардлагатайгаар 82 хувийн гүйцэтгэлтэй ажил зогссон байна. Тус ажлын нэмэлт санхүүжилтийг ажлын тоо хэмжээгээр гаргасан 1.1 тэрбум төгрөгийн төсөвт дүнд Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэж байна.	
92		Соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хувцас хэрэглэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2020-2024	БШУГ	СУБ	Улсын болон орон нутгийн төсөв	165.0	-	Тоног төхөөрөмжөөр хангана.	50.0	Орон нутгийн төсөв 509.4	100%
93		Хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	2020-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	80.0	-	Дэмжлэг үзүүлнэ.	20.0	Орон нутгийн төсөв 67.5	100%

											Аймгийн телевизүүдийн холбоотой хамтран сар шинийн баярын нэвтрүүлэг,"Colorfilm" студитэй хамтран эх үрсийн баярын нэвтрүүлэг, цахим тоглолт, шилдэг 15 өвлөн уламжлагчийн "Эрдэнэтийн өв соёл" видео контентыг хийж иргэдийн хүртээл болгосон байна. 2022 онд “Эрдэнэт” дуу бүжгийн чуулгын 3 уран бүтээлч, 14 дүгээр сургуулийн 1 сурагчийн бие даасан тоглолтод 15.8 сая, “Таван эгшиг” төгөлдөр хуурын улсын уралдаанд оролцох замын зардалд 1.5 сая сургалтын төв, “Тод анир” зохиолчдын салбар зөвлөлөөс зохион байгуулсан 2 арга хэмжээнд 3.5 сая, нийт 20.8 сая, 2023 онд 7 уран бүтээлчийн бие даасан тоглолт болон шинэ уран бүтээл, үзэсгэлэнгийн зардалд 21.6 сая, соёл урлагийн чиглэлээр явагдсан 5 уралдаан тэмцээнд 12.9 сая, аймгийн “Зураач, урчуудын холбоо”, “Номын шидэт хайрцаг” төрийн бус байгууллагаас зохион байгуулсан үзэсгэлэн, сургалтад 12.0 сая, 2 хамтлагийн бие даасан тоглолтод 9.0 сая, “Эрдэнэт” дуу, бүжгийн чуулгын уран бүтээлчдийг “Цэнгэлийн эгшиг” уралдаанд оролцоход 5.0 сая, “Өсөх ирээдүй” бүжгийн хамтлагт 1.0 сая, 1 сурагч, 2 уран бүтээлчийг АНУ, Франц, ОХУ-д зохиогдсон уралдаанд оролцоход 6.0 сая, нийт 67.5 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна.		
94	3.2.1.Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, гадаад харилцааг өргөжүүлж, соёл, урлагийн үйлчилгээг аялал жуулчлалтай холбон сурталчлах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Соёл, урлагийн байгууллагын ажилтнуудыг гадаад улс орнуудад туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах	2022-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	75.0	-	10 уран бүтээлч Жил бүр	25.0	Орон нутгийн төсөв 6.0	2022 онд Япон, Болгар улсад зохион байгуулагдсан хөгжмийн болон дуурийн дуулаачдын уралдаанд оролцсон уран бүтээлч, багш сурагчдад нийт 4.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2023 онд ОХУ-д зохиогдсон дуурийн дуулаачдын уралдаанд оролцсон чөлөөт уран бүтээлч Б.Заяатад 1.5 сая, АНУ-д төгөлдөр хуурын уралдаанд оролцсон Ц.Энх-Ундаргад 1.5 сая, Жаргалант сумын соёлын төвийн 1 ажилтан Франц улсад “Чингис хаан дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнд оролцоход 3.0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн байна. Мөн Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборын уран бүтээлч Н.Цэрэнпил БНСУ-д зохиогдсон “MAMF-2023” олон улсын соёлын фестивальд “Соёлын биет бус өв өвлөн уламжлагч” төрлөөр, тус цогцолборын уран бүтээлч Д.Дагвадорж, М.Маналжав нар ОХУ-ын хөгжмийн зохиолч Исаак Дунаевскийн нэрэмжит Олон улсын дуулаачдын	90%

												XII дахь удаагийн уралдаанд тус тус оролцсон байна. Аймгийн Хүүхэд, залуучуудын театрын 6 уран бүтээлч БНХАУ-ын ӨМӨЗО-ны кино багтай хамтран "Шөнийн манаа" түүхэн олон ангит кинонд тоглож байна. Эдгээр уран бүтээлчдэд аймгийн Хүүхэд, залуучуудын театраас 2 сарын цалинтай чөлөө олгож, мэргэжил ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангасан.	
95		Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага болон бусад уран бүтээлчдийг шинэ уран бүтээл гаргахад нь дэмжлэг үзүүлэх	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	110.0	-	Дэмжлэг үзүүлнэ.	30.0	Орон нутгийн төсөв 22.3	2021 онд зөөврийн музей байгуулах төсөл, "Жороо баахан улаан" дууг дүрсжүүлэх, "Бачата" бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох Орхон аймгийн "Өсөх ирээдүй" бүжгийн спортын клубын бүжигчдийн замын зардалд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. 2022 онд дуучин Д.Нямсүрэн, Х.Мөнхбаяр, Б.Нямдэлгэр нарын бие даасан тоглолтод нийт 14.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, аймгийн Хүүхэд, залуучуудын театрын 2 уран бүтээлийн зардалд 40.0 сая төгрөгийг улсын төсвөөс олгож тус тус дэмжлэг үзүүлсэн. 2023 онд аймгийн Хүүхэд залуучуудын театрын найруулагч Е.Баярмагнайн тайз, дэлгэц хосолсон театрчилсан тоглолтод 5.7 сая, аймгийн "Зураач, урчуудын холбоо"-ноос зохион байгуулсан "Эрдэнэтийн хавар" үзэсгэлэнд 2.0, "Мэлмий" гэрэл зургийн бүлгэмийн зурагчин Т.Шинэсүлдийн Эрдэнэт хотын шилдэг гэрэл зургуудаас бүрдсэн шинэ уран бүтээлд 4.9 сая, аймгийн Хүүхэд, залуучуудын театрын "Асаж буй толгод" жүжгийг Өмнөговь, Дундговь аймагт аялан тоглоход 3.2 сая, тус театраас зохион байгуулсан "Хүүхэлдэйн урлагийн их наадам"-д 2.5 сая, Дундговь аймгийн "Уяхан замбуу тивийн наран" эвент арга хэмжээнд оролцоход 4.0 сая төгрөг, нийт 22.3 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ.	100%
96		Орон нутагт гадаад дотоодын аялал жуулчлалыг татах зорилгоор улс, бүсийн чанартай соёл, урлагийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	2021-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	80.0	-	2 арга хэмжээ зохион байгуулна.	25.0	Орон нутгийн төсөв 48.9	2022 онд Аймгийн Соёл, урлагийн газар, Орхон аймгийн Бүжгийн холбоод хамтран "Бүжин наадъя" бүжгийн фестивалийг зохион байгуулсан. Фестивальд 13 аймгийн 1300 гаруй бүжигчид оролцсон бөгөөд орон нутгийн төсвөөс 6.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Орхон, Булган аймгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд "Хангинахын шугуйн шагайн тойром" соёл, спортын үйл ажиллагааг Булган аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан.	100%

											2023 онд "Бүргэдийн баяр-2023" арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулж Казах түмний соёл, ёс заншлыг сурталчилсан. Уг үйл ажиллагаанд Баян-Өлгий аймгаас 13 бүргэдчин оролцож, гадаад, дотоодын 8000 гаруй иргэд үзэж сонирхсон бөгөөд худалдаа, үйлчилгээ, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагууд нийт 9.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Мөн аймгийн аялал жуулчлал, уул уурхайн салбарын онцлогийг илэрхийлсэн эвентийг хөгжүүлэх, сурталчлах зорилгоор "Зэс фестиваль"-ийг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд хоол үйлдвэрлэл, зэс бүтээгдэхүүний худалдаагаар орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид 23.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.		
97		Улсын хэмжээний шилдэг уран бүтээлийг орон нутгийн иргэдийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх	2022-2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-	Орон нутгийн төсөв 20.0	2022 онд УДЭТ-ын уран бүтээл "Анна Каренина" жүжгийг, 2023 онд "Соёлыг түгээе" аяны хүрээнд Монгол улсын филармоний Морин хуурын чуулгын шилдэг уран бүтээлийн тоглолтыг 3 удаа орон нутгийн иргэдийн хүртээл болгоход орон нутгийн төсвөөс тус тус 20.0 сая төгрөгийг зарцууллаа.	100%
98	3.2.2.Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах хамгаалах, сурталчлах ажлын чанарыг нэмэгдүүлэн, иргэд олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж иргэд олон нийтийн хяналт оролцоог сайжруулах	2021-2024	БШУГ	Аймгийн Музей	Орон нутгийн төсөв	12.0	11 өрх	20 өрхөд урамшуулал олгоно.	4.0	Орон нутгийн төсөв 4.0	Орхон аймгийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хамгаалж буй 12 айл өрхтэй гэрээг шинэчлэн байгуулж, гэрээгээр хамгаалах бүсчлэлийг шинэчилсэн. 2022 оноос гэрээгээр хамгаалах өрхүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын А/227 дугаар захирамжаар Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 20 өрхтэй гэрээ байгуулж нийт 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулсан. 2023 онд дээрх өрхүүдтэй гэрээг сунгаж харьяалах нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх 28 дурсгалт газрын 343 булш, оршуулгын дурсгалын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын А/691 дүгээр захирамжаар нийт 4.0 сая төгрөгийн урамшууллыг 20 өрхөд олголоо.	100%
99		Айргийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэн хийж аймгийн Музейн үзмэрийн сан	2023-2024	БШУГ	Аймгийн Музей	Орон нутгийн төсөв	60.0	-	Малтлага судалгааны ажлыг хийх	30.0	-	Соёлын яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу Монгол улсын Үндэсний Музей, БНХАУ-ын Ардын Их сургуультай хамтран Жаргалант сумын Айргийн гозгорын дурсгалт газарт 2023 оны 06 дугаар сарын 18-наас 07 дугаар сарын 11-нийг дуустал 3 дурсгалд малтлага судалгааны ажлыг	90%

		хөмрөгийг баяжуулах										хийж гүйцэтгэсэн. Уг малтлагаас гарсан 2 ширхэг вааранд судалгаа хийж, бүртгэлжүүлсэн байна.	
100		Соёлын биет бус өв тээгчдийг сурталчлах ажлыг техник, технологийн шийдлийг ашиглан шинэлэг хэлбэрээр зохион байгуулах	2021- 2024	БШУГ	СУБ	Орон нутгийн төсөв	40.0	-	Сурталчлах ажлыг зохион байгуулна.	-	Орон нутгийн төсөв 2.5	2021 онд соёлын биет бус өв тээгчдийг сурталчлах, алдаршуулах ажлын хүрээнд өв тээгчдийн судалгааг шинэчилж, 120 өвлөн уламжлагчийг цахим орчинд сурталчилсан. Мөн "Номин" телевизтэй хамтран шилдэг 15 өвлөн уламжлагчаар "Эрдэнэтийн өв соёл" видео контентыг хийж иргэдийн хүртээл болгоход 4.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Энэ нь иргэд, хүүхэд багачуудад уламжлал, өв соёлыг таниулах, түгээн дэлгэрүүлэх чухал нөлөө үзүүлсэн томоохон ажил болсон. 2022 онд соёлын биет бус өв өвлөн уламжлагчдын улсын үзлэг тооллогыг зохион байгуулж, бүртгэлийн www.ich.mongoluv.mn сайтад 198 хүний бүртгэлийг хийж, нийт өв тээгчдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хадгалж байна. Соёлын яамнаас зохион байгуулсан "Нүүдэлчин Монгол" фестивальд аймгийн биет бус өв тээгч, өвлөн уламжлагчид оролцоход орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2023 онд соёлын биет бус өв өвлөн уламжлагчдыг сурталчлах зорилгоор МҮОНТ-ийн "Монгол өв соёл" 4 цуврал нэвтрүүлэгт угийн бичгийг арьсан дээр тусгай аргаар 8 үеэ судалж хөтөлсөн 2 иргэн, монгол марк цуглуулга, эсгий урлал, ширмэл ширдэг, модон эдлэл, модны үндсээр гар аргаар сийлбэр хийх, Урианхай ардын уртын дуу болон өрөөл магтаал, зодог шуудаг хийх, Монгол ардын оньсон тоглоом, гангаар гэр ахуйн эдлэл хийх, алт мөнгөний дархан, Монгол бичиг, Монгол зураг, зоосон ширээ, уран хатгамал, бурхан урлалын төрлөөр соёлын өвийг өвлөн уламжлагч 56 иргэнийг оролцуулж орон даяар сурталчилсан.	100%
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ													
3.3.Шинэ технологи нэвтрүүлэх, инновацыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.													
101	3.3.1.Аймгийн онцлог, давуу талд тулгуурлан катодын зэс боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэх	2021- 2022	“Эрдэ нэт үйлдв эр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	“Эрдэнэ т үйлдвэр ” ТӨҮГ	167.3	-	Төслийг ажлын явцыг 100%-д хүргэнэ. Төсөл бүрэн хэрэгжиж дуусна. /2022 онд/	83.7	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлыг "Майнинг Шорт Лонг Терм" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэгч компани ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. 2023 оны 06 дугаар сард зураг төсөл, төсөв гүйцэтгэгч "Майнинг шорт лонг терм" ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дууссан боловч	30%

											зураг төслийн гүйцэтгэл дутуу ажлуудыг яаралтай дуусгах талаар 2 тал хэлэлцэж гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сард гүйцэтгэгч компанид 33.8 хувийн санхүүжилтийг олгосон.		
102		“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлэх	2021-2024	“Эрдэ нэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	1628.4	-	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 100%-д хүргэнэ.	488.5	-	Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай хамтран боловсруулж УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлж дэмжигдсэн. ТЭЗҮ-ээр зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр нь жилд 560 мянган тонн зэсийн баяжмал (хуурай) боловсруулж А зэрэглэлийн катодын зэс 124.1 мянган тонн, алт (99.9%) 72 кг, мөнгө (99.9%) 38.2 кг, элементийн хүхэр 182 мянган тонн, шингэрүүлсэн хүхрийн хүчил 118.2 мянган тонныг үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс ялгарах металлургийн хийг боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилтын ажлыг БНХАУ-ын ENFI компани гүйцэтгэж байна. Элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжиан Уйгарын өөртөө засах орны Xinjiang Xinxin Mining Industry компанийн харьяа Karatongke Copper Nickel Mine хайлуулах үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100 хувь дууссан ба "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэн БНХАУ-руу тээвэрлэх ажлыг зохион байгуулан үйлдвэрт хүргүүлж, туршилтын ажлыг эхлүүлсэн.	70%
103		Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах	2021-2024	“Эрдэ нэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г УТП “ШУТ П”	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	1495.1	-	Төслийн ажлын явц 70%. Төслийн ажлыг үргэлжлүүлнэ.	488.5	-	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд дараах 4 төсөл хэрэгжиж байна. -Өөрөө нунтаглах хэсгийн шинэ 4 дүгээр шугамын хүчин чадлыг 2.0 сая тн/жилээр нэмэгдүүлэх, -Нунтаглан баяжуулах хэсэгт хам баяжуулалтын 2, 3 дугаар секцийг шинэчлэх, -Хүдэр бэлтгэлийн I шугамыг шинэчлэх, -Хаягдал өтгөрүүлэх технологийг нэвтрүүлэх төслүүд байна. Үндсэн тоног төхөөрөмж болон цахилгаан хөдөлгүүр, давтамжийн хувиргагчийн үйлдвэрлэл	70%

		төслүүдийг хэрэгжүүлэх										25 хувьтай хэрэгжиж, өргөтгөлийн ажлын бүтээн байгуулалтыг 2024 оны 8 дугаар сард дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Нунтаглан баяжуулах хэсэгт жилд 12.0 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 2, 3 дугаар секцийг өндөр бүтээмжтэй, ашиглалтын зардал багатай флотмашинаар шинэчлэх ажлын гүйцэтгэгч FLSmidth Mongolia компанитай 2023 оны 5 дугаар сард гэрээ байгуулсан. Эмультсийн тэсрэх бодисын үйлдвэрийн барилга угсралтын ажил 83 хувь, технологийн тоног төхөөрөмжийн угсралт 90 хувийн гүйцэтгэлтэйгээр явагдаж байна. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 45 хувь, Эмультсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90 хувь, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжийн ажил 100 хувийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөгөөний дагуу явагдаж байна.	
104	3.3.2. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийг түшиглэн боловсрол эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгон, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ.	Их, дээд сургууль, МСҮТ, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан гарааны бизнесийг дэмжин хөгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ "ШУТ П" Хувийн хэвшил	ХХАА Г ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	35.0	Гарааны 5 төслийг дэмжсэн.	Гарааны 5 бизнес санааг дэмжин хөгжүүлнэ.	10.0	ШУТП-ийн өөрийн орлогоос 10.0	2021-2022 онд "Боломжоос өөрчлөлт рүү" шинэ санаа, шилдэг технологийн уралдаан зохион байгуулж, 20 гаруй гарааны бизнесийн санаа бүртгэснээс 5 төслийг шалгаруулан тус бүр 400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож дэмжсэн. Бизнес инкубаторт 10 гарааны бизнесийг 2 жилийн хугацаанд ажлын байраар хангаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлснээр металлург, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, технологийн судалгааны үйлчилгээ зэрэг бизнес бий болсон. 2023 онд "Судлаач-Энтрепренер" хөтөлбөр хэрэгжүүлж инновацийн төсөл, гарааны компани хөгжүүлэх 18 залуу судлаач, оюутны төсөл хүлээн авч, оролцогчдыг 2 сарын турш сургалтад хамруулан шилдэг оролцогч 2 оюутныг төслөө хэрэгжүүлэхэд ажлын байраар хангаж, 1 төсөлд нь 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийн 120 оюутны дунд гарааны бизнесийн уулзалт зохион байгуулж, гарааны бизнесийн хөтөлбөрт оролцох сонирхолтой 20 оюутны баг бүрдүүлэн зөвлөн ажиллаж байна. "Гарааны бизнес-2023" төслийг хэрэгжүүлэн хүнсний шинэ төрлийн бүтээгдэхүүн, ногоон сууц үйлдвэрлэлийн ангилалд Эко чихэр, Мөөгний чипс, Блок хаус үйлдвэрлэх 3 төсөлд 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, өрхийн болон бичил үйлдвэрлэлийн ангилалд бетон хийцийн 1, арьсан эдлэлийн 6, хүнсний 11, оёдлын 8, металл	85%

												хийцийн 2, мэдээллийн технологийн 1, биомасс дахин боловсруулах 2, бусад 2, нийт 33 төсөлд нийт 270.0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон. Хүүхэд залуучуудад программ, код хөгжүүлэх сургалт явуулж буй "Код лаб" сургалтын төвд орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн өртөг бүхий 12 ширхэг зөөврийн компьютер олгосон. Тус сургалтын төвөөс 62 сурагчийг программ, код хөгжүүлэх сургалтад хамруулж чадавхжуулсан. Одоогийн байдлаар Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркаас 17 гарааны бизнесийг дэмжин хөгжүүлээд байна.	
105		Бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээг үе шаттай хүргэх, чадавхжуулах	2021-2024	ХБТХ ОХ "ШУТ П" Хувийн хэвшил	ХХАА Г ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	35.0	10 бизнес эрхлэгч	10 бизнес эрхлэгчийг чадавхжуулна.	10.0	Олон улсын төсөл хөтөлбөр 100.0	2021-2023 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Прогресс төсөл, Эрдэнэт ШУТП-ийн хамтран ажиллах гэрээний хүрээнд 120 бизнес эрхлэгчид санхүүгийн менежмент, бизнесийн стратеги, брэнд хөгжүүлэлтийн зөвлөх үйлчилгээг үзүүлснээс 40 бизнес эрхлэгчид нийт 380.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийж дэмжлэг үзүүлсэн. Бизнес хөгжлийн төвд "Бизнес ширээ" ажиллуулж бизнес эрхлэх, татвар, тохирлын гэрчилгээ, хөнгөлөлттэй зээл болон хөрөнгө оруулалтын боломж, оюуны өмчийг хамгаалах зэрэг 10 төрлийн мэдээллийг 250 гаруй иргэнд өгч анхан шатны мэдлэг олгосон. Европын Холбооны "СВИЧ-Эйшиа" хөтөлбөрийн хүрээнд дөрвөн жилийн хугацаанд нийт 2.2 сая еврогийн санхүүжилттэйгээр "Эдийн засгийн ногоон шилжилт" төсөл хэрэгжиж эхэлсэн. Газар тариаланд суурилсан хүнс, ундааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдэд салбартаа тогтсон хэв загвараа илүү ногоон болгон өөрчлөхөд нь шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх, ногоон баталгаажуулалт, эко шошгожуулалтыг зах зээлд нэвтрүүлж, ногоон санхүүжилтэд хүрэхэд туслах зорилготой уг төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад "Чацарганы шүүс үйлдвэрлэл"-ийн чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхлэгч 1 иргэн, мэргэжилтнүүд хамрагдлаа. Төслийг Пипл ин Нийд, Каритес Чех Репаблик, Монголын тогтвортой хөгжлийн санхүүжилтийн холбоо, Хөгжлийн шийдэл ТББ хамтран хэрэгжүүлж байна.	100%

											“Хөгжлийн шийдэл” Төрийн бус байгууллагын BEST хөтөлбөр нь бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж төсөл бичих арга зүйд суралцуулан зээлийн ашиглалт, зарцуулалтын чиглэлээр сургалт өгснөөр хүнс, хувцас үйлдвэрлэл, газар тариалан болон бусад чиглэлээр 37 иргэн, аж ахуйн нэгж төсөл бичиж арилжааны банкуудаас 1.9 тэрбум төгрөгийн бизнесийн зээл авч, 76 ажлын байр хадгалагдан, 6 ажлын байр шинээр нэмэгдсэн. Өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 2 иргэнд оёдлын машины тоног төхөөрөмж, 1 иргэнд дугуй засварын тоног төхөөрөмж тус тус олгогдлоо. Ингэснээр 5 ажлын байр шинээр нэмэгдэж, өрхийн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж байна.		
106	3.3.3.Инновацийн төсөл хэрэгжүүлэх хүрээнд технологийн парк, технологи дамжуулах төв, гарааны бизнесийг хөгжүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гадаад, дотоодын зах зээлд гаргах, тэлэх, нээлттэй болоход нь дэмжлэг үзүүлнэ.	"Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк" ОНӨААТҮГ-ын дэргэд технологи дамжуулах төв байгуулах	2021	"ШУТ П" ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ ХХАА Г	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	2.0	-	-	-	Улсын төсөв 50.0	2022 онд "Эрдэнэт ШУТП"-ийн дэргэд технологи дамжуулах төв байгуулж, "Эрдэнэт-2022 инноваци, технологийн өдрүүд" арга хэмжээг зохион байгуулан 15 бизнес эрхлэгчид инновацийн зөвлөгөө өгч шилдэг 3 төсөлд тус бүр 10.0 сая төгрөг олгосон. 2023 онд "БМОМ" ХХК, "Мөөг кластер" ХХК-иудад технологийн хөгжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран хальтиргаанаас сэргийлэх материал, сахар үйлдвэрлэл, дулааны станцын хаягдал үнс дахин боловсруулах чиглэлээр судалгааны ажил хийж байна.	100% 2021 онд бүрэн хэрэгжиж дууссан
107		Бизнес эрхлэгчдэд инновацийн төслийн ТЭЗҮ боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зах зээлд гаргах, хөгжүүлэхийг дэмжих	2021-2024	"ШУТ П" ХБТХ ОХ	ХХҮГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	34	1 бизнес эрхлэгчид технологи дамжуулсан.	3 бизнес эрхлэгчийг дэмжинэ.	10.0	Олон улсын байгууллага 32.0	2022 онд цаас, хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж түлш үйлдвэрлэх, яс дахин боловсруулах, арьс шир боловсруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлж буй 3 бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний технологийн хөгжүүлэлт, зах зээлд гаргахад бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж дэмжин ажилласан. 2023 онд хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн төслийг инновацийн төслөөр хөгжүүлэхээр зөвлөх үйлчилгээ үзүүлж, "Баяжуулагч-Одод" ХХК-ийн хатаасан аарц, "Идэрбаялаг" ХХК-ийн давсалсан махны хатаамал зэрэг инноваци шингэсэн	100%

												бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд тус бүр 6.0 сая, цаасны хог хаягдлаар эко түлш боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй 1 компанид үйлдвэрлэсэн түлшээ нөөцлөхөд зориулж 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 11 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нэгдэн хоршоо байгуулж мөөг ургуулах хөрс үйлдвэрлэж байна. Ингэснээр сард 500 кг мөөгийг ургуулах боломж бүрдүүлээд байна. Иргэн Зулчимэгийн амттаны үйлдвэрлэл, "Ган компасс" ХХК-ийн экспортын тоглоом үйлдвэрлэл, "Мөөг кластер" ХХК-ийн чипс үйлдвэрлэл, тариалалтын ухаалаг чингэлэг үйлдвэрлэл, эмийн мөөг тариалалт, "Бидэрт манхан" ХХК-ийн хуванцар эдлэл үйлдвэрлэл, "БМОМ" ХХК-ийн биомасс боловсруулах зэрэг 9 төслийг дэмжин хөгжүүлж байна.	
ДӨРӨВ.ЭРҮҮЛ ХҮНС, ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ													
	ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ												
	4.1.Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдол, аюулыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.												
108	4.1.1.Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, үүсэж болзошгүй аваар ослыг бууруулна.	Гэр хорооллын үерийн хамгаалалтын далан сувгийн бэлэн байдлыг ханган ахуйн хог цэвэрлэгээг улирал бүр зохин байгуулах	2021-2024	ХЗА	ХТГ ОБГ ХХҮГ	Орон нутгийн төсөв	60.0	Хотын хэмжээнд	100%	15.0	Орон нутгийн төсөв 11.5	2023 онд Хотын захирагчийн алба, Онцгой байдлын газар, Баян-Өндөр сум, Хот тохижуулах газар зэрэг байгууллагууд хамтран сар бүр 2 удаа төлөвлөгөөт үзлэг хийж ажиллаж байна. Энэ жил 7-9 дүгээр сард нийт 47 өдөр усархаг бороо орсонтой холбогдуулан 2.3 км шороон сувгийг сэргээж ухах, 4 удаагийн үерийн сувгийн их цэвэрлэгээг зохион байгуулан 144м³ хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн давхардсан тоогоор авто замын 14ш гарц хог хайргаар бөглөрснийг цэвэрлэж, намар 6.6 км шороон сувгийг сэргээх хийж гүйцэтгэлээ.	100%
109		Гэр хорооллын шороон үерийн хамгаалалтын суваг шинээр татах	2021-2024	ХЗА ОБГ	ХТГ	Орон нутгийн төсөв	100.0	Хотын хэмжээнд	90%	30.0	Орон нутгийн төсөв 163.9	2021-2022 онд 16.6 км шороон сувгийг шинээр болон сэргээн ухах ажил орон нутгийн төсвөөс 25.9 сая төгрөгийг зарцуулсан. 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 72.8 км шороон үерийн суваг байгаагаас инженерийн хийцлэлтэй 10.2 км, далд 11.0 км, 51.6 км нь байгалийн гуу жалга болон авто замын ус зайлуулах хаялага байна. 2023 онд аймгийн болзошгүй аваарын зардлаар Их залуу багийн Баруун задгай 18, 19 дүгээр гудамжинд 165м суваг, Даваат багийн Зураагийн 1, 2 дугаар гудамжинд 153м суваг шинээр хийхэд орон нутгийн төсвөөс 163.9 сая төгрөгийг зарцуулан ашиглалтад орууллаа.	70%

110		Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам талбай, тохижилтын нэгдсэн мэдээллийн сан байгуулж болзошгүй аваарыг түргэн шуурхай илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЗА	ХЗА ОНӨГ ОБГ СТСХ	Батлагдсан төсвийн хүрээнд	80.0	-	Аюул эрсдэлийг бууруулна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 1092.8	2023 онд Erdenet.mn сайтаар дамжуулан Эрдэнэт иргэн https://irgen.erdenet.mn/ хэсэгт иргэдийн өгсөн мэдээллийн дагуу холбогдох газруудтай хамтран газар дээр нь үзлэг шалгалт хийж болзошгүй гэмтэл эвдрэлийг илрүүлж, засварлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар уг сайтад нийт 19 хүсэлт ирснийг 100 хувь судалж шийдвэрлэлээ. Мөн аваарын байдалтай байсан ДГТ-3-р байрны подвалын инженерийн шугам сүлжээг шинэчлэх шинэчлэх ажилд 79.9 сая төгрөг, төрийн албан хаагчдын чийрэгжүүлэлтийн танхимын инженерийн шугам сүлжээ, узелыг засварлаж шинэчлэх ажилд 79.3 сая төгрөг, Говил баг, Арбулаг хэсэгт 6/0.4 кВ-ын 160 кВА дэд станц, 6/0.4 кВ-ын ЦДАШ барих ажилд 96.2 сая төгрөг, Уурхайчин багт хот дахин төлөвлөлтийн барилгажуулах төслийн цэвэр усны шугам шилжүүлэх ажилд 243.6 сая төгрөг, Уртын гол багт баригдсан 260 айлын орон сууцны ус, дулаан, дамжуулах төвд нэмэлт тоноглол суурилуулах ажилд 36.7 сая төгрөг, Чандмань багт Эко хорооллын гадна шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажилд 543.8 сая төгрөг, Дэнж багийн Баруун Дэнжийн 4 дүгээр гудамжинд байршилтай ус түгээх байранд цэвэр усны нөөцийн сав байрлуулах /гадна пандусны хамт/ ажилд 13.2 сая төгрөг нийт 1.1 тэрбум төгрөгийг болзошгүй аваарын зардлаар шийдвэрлэснээр нийт ажлын гүйцэтгэл 81 хувьтай хэрэгжиж байна.	90%
111	4.1.2.Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх, дэд бүтэц барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаах хэрэгсэл нэвтрүүлэх	2021-2024	ХЗА БОАЖ Г	Баян-Өндөр сумын ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	50 өрх	Төсөв болон Хувийн зардал	Орон нутгийн төсөв 150.0	Гэр хорооллын дахин төлөвлөлт, шинэ суурьшлын бүсийг бий болгох, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баян-Өндөр сумын 2 байршилд хийгдэх /Эрдэнэ багийн 6 га талбайд 60 айл, Уурхайчин багийн Сархиа уулын энгэрт 48га талбайд 300 айл/-ын амины орон сууцны төслийг бүх нийтэд танилцуулж, "Ногоон амины орон сууц"-ны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, барилга орон сууц, ногоон технологийн шийдлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй аж ахуйн нэгж оролцож, иргэдийг мэдээллээр хангаж ажиллалаа. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн тоог бууруулах зорилгоор 2022 онд НҮБ-ын Хүүхдийн сан, БОАЖЯ, Аймгийн Засаг даргын хамтран	72.6%

											ажиллах санамж бичгийг байгуулж энэ ажлын хүрээнд 49 өрхөд, 2023 онд орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын 60 өрхөд тус тус монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгож гэр хорооллын яндангийн тоог буурууллаа. Баян-Өндөр сумын хэмжээнд халаалтаа цахилгаанаар шийдвэрлэсэн өрхийн тоо 275 болж нэмэгдсэн.	
112		Бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй барилга, гэрэлтүүлэг шинээр барих (Нарны болон салхины эрчим хүч)	2021-2024	ХЗА ХБТХ ОХ	БОАЖ Г Баян-Өндөр сумын ЗДТГ	Төсөл хөтөлбөр Иргэдийн оролцоо	500.0	-	25 өрх	Төсөв болон Хувийн зардал	Орон нутгийн төсөв 656.9 НҮБХС-150.0	30%
113	4.1.3.Хотын доторх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг стандартын түвшинд хүргэж, шинэчилнэ.	"Ногоон-Эрдэнэт" төслийг боловсруулан хэрэгжүүлэх	2021-2024	ХЗА	БОАЖ Г ЦНБ	Орон нутгийн төсөв	1000	-	Төслийн хэрэгжилт 25%	Төлөвлөгөө биелэгдсэн байна.	Орон нутгийн төсөв 383.3	100%

												1888068 ширхэг мод тарьсан. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2023 онд таримал ойн хэмжээг 36.76 га талбайгаар нэмэгдүүлж, өссөн дүнгээр 92.76 га талбайд нийт 3340577 ширхэг мод тарьж, ойн төгөл, зурвас байгууллаа. 2023 оны байдлаар “Ногоон-Эрдэнэт” хөтөлбөр 37.9 хувийн хэрэгжилттэй байна.	
114		Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг иргэд аж ахуй нэгж, байгууллагуудын оролцоотойгоор нэмэгдүүлэх	2021-2024	ХЗА	Сумдын ЗДТГ	Байгууллагын зардал	ААНБ н зардал	20 ААНБ	25 ААНБ	Хувийн зардал	-	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж нэмэгдүүлэх чиглэлээр 2 төрлийн зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн. Үүнд хуйлдаг зүлэг 4100м2 талбайд тарьж шинэ технологи нэвтрүүлэхэд 234.0 сая, Согоовор болон өлөнгө сортын үрээр нийтийн эзэмшлийн 7200м2 талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг 97.8 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн. Бүх нийтийн мод тарилтаар Тарлан толгойн энгэр, Сархиа ууланд 106 төрийн байгууллагуудын оролцоотой 5640 ширхэг мод тарьсан. Аймгийн хэмжээнд нийт ногоон байгууламж 92.76 га талбай болсноор 1 хүнд ноогдох ногоон байгууламжийг 8.7 м ² -д хүргэлээ.	100%
115	4.1.4.Гэр хороололд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх, усны зөв хэрэглээний талаар бүх нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хөрсний	Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г ХЗА	Сумдын ЗДТГ	БОХАХ 3 болон улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр	800.0	500 ш	200 ш	200.0	орон нутгийн төсөв 200.0	Гэр хорооллын айл өрхөд стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийн суурийн байгууламжийг барьж, гүйцэтгэх 2023 оны БЗА-65/23 гэрээт ажлын гүйцэтгэгчээр Би Юу Эм Ди ХХК ажиллаж, орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр гэр хорооллын 12 багийн нийт 45 өрхөд соруулдаг технологитой эко ариун цэврийн байгууламжийн суурийн хэсгийг иж бүрэн хийж дууссан. БЗА-41/22 гэрээт ажлын гүйцэтгэл он дамжин хэрэгжиж 2023 оны 8 дугаар сард нийт 78 өрхийн суурийн байгууламжийг бүрэн хийж, хаяавч бетоныг цутгаж, улсын комисс ажиллаж хүлээж авлаа. Мөн өөрийн хөрөнгөөр гэр хороололд 4 өрх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж хийсэн. 2023 оны байдлаар нийт 1718 айл өрх стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжтай болоод байна.	100%
116	бохирдлыг бууруулна.	Усны хэрэглээний талаар зөв мэдлэг, хандлага, дадлыг бий болгох сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г МХГ СГСГ 3	Сумдын ЗДТГ “ЭУДТ С” ОНӨХ К	БОХАХ 3	4.0	16 удаа	4 удаа	1.0	Орон нутгийн төсөв 3.0	Монгол улсад Усны салбар үүсч хөгжсөний 85 жилийн ойн хүрээнд “Өөрчлөлтийг хурдасгая-Дэлхийн усны өдөр”-ийг хамтран зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр дараах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгууллаа. Үүнд:	100%

											Ус хэмнэх чиглэлээр "УС 85" дүрс бүхий сурагчдын зураг авалтыг Colorfilm студитэй хамтран хийж, ерөнхий боловсролын 4, 5, 14, 15 дугаар сургуулиудын ахлах ангийн усны элч 85 сурагч хамрагдлаа. Хотын ус хангамж, түгээлт, нийлүүлэлтийн талаар сурагчдын дунд аялал зохион байгуулж, Бүрэнбүстийн унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрт ажилласан. Ерөнхий боловсролын сурагчдын дунд усны чиглэлээр АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд амжилттай оролцсон сурагчдыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. Хүүхэд, залуучуудын театрттай хамтран "Ус" драмын жүжгийг сурагчдад үзүүлж, усны үнэ цэнэ, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэлээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Дэлхийн усны өдрийг тохиолдуулан "Өөрчлөлт, сэргэлтийг хурдасгая" уриалгын хүрээнд зохион байгуулагдсан "Цэнхэр алт" усны салбарын үндэсний чуулганд Орхон аймгаас Сэлэнгэ голын сав газрын захиргаа, БОАЖГ, Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ус хангамжийн цех, Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-иас нийт 20 гаруй төлөөлөл оролцлоо. "Гүүд нэйборс" олон улсын ТББ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу "Ундны ус эрүүл ахуй" хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж аймгийн БОАЖГ, ЭМГ, Баян-Өндөр сумын сумын ЗДТГ, Яргуйт, Их залуу, Эрдэнэ, Дэнж багийн ажлын албаны албан хаагчид хамрагдлаа. Дээрх хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан, өрхийн түвшинд ундны усны аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн оновчтой хэрэглээний талаар өрхийн гишүүдийн ойлголтыг нэмэгдүүлж, эрүүл аж төрөх зөв дадал хэвшилтэй болохыг дэмжих зорилгоор гэр хорооллын 1166 иргэнд сургалт хийсэн.		
117	4.1.5.Агаарын бохирдлыг бууруулах боломжит судалгааг хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, байгальд ээлтэй	Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, бохирдлыг бууруулах	2021-2024	ХБТХ ОХ БОАЖГ ХЗА Сумдын ЗДТГ	ААНБ	БОХАХ 3 болон улсын төсөв	330.0	Pm10- ст-с 1.4 дахин давсан	MNS4585:200 ст-ын түвшин	100.0	-	Эрдэнэт хотын агаарын чанарын хэмжилт, судалгааг нийт 4 суурин харуулаар тогтмол хийж, дүн мэдээг http://www.tsag-agaar.gov.mn/ , www.Agaar.mn сайтуудаар бүх нийтэд ил тод мэдээлж байна. Агаарын чанарын 2023 оны хүйтний улирлын хяналт шинжилгээний дүнгээр хүхэрлэг хийн дундаж агууламж 21 мкг/м3 буюу агаарын	90%

	дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжинэ.											чанарын MNS4585:2016 стандартаас хэтрээгүй байна. Азотын давхар ислийн дундаж агууламж 126 мкг/м3, стандартаас хэтрээгүй боловч хотын төв орчим нийт хэмжилтийн 30 хувь нь хүлцэх агууламжаас давсан байна. PM2.5 тоосонцрын агууламжийн дундаж дүн 0.0682мг/м3 хүрч стандартаас 1.4 дахин, хотын төв орчим нийт хэмжилтийн 80 хувь, гэр хороолол орчим 63 хувь нь хүлцэх агууламжаас давсан байна. БОАЖЯ-аас хэрэгжүүлж буй хүлэмжийн хийг бууруулах төслийн хүрээнд 2-3 өрхөд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, дулаалга, цахилгаан халаалтыг багцаар нь шийдвэрлэж, карбон кредит тооцуулах туршилтын ажлыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж, гэр хорооллын нийт 480 иргэнийг сургалтад хамруулж, урьдчилсан судалгааны ажлыг эхлүүлээ. Эрдэнэт хотын агаарын чанарын бүсийг шинэчлэн батлуулсантай холбогдуулан агаарын чанарын бүсийн зураг, бүсэд мөрдөх журам, Агаарын тухай хуулийн холбогдох заалтуудыг тусгасан гарын авлагыг бэлтгэн хэвлүүлж, Баян-Өндөр сумын ЗДТГ, гэр хорооллын 19 багийн ажлын албаны хэрэгцээнд олгож, мэдээллээр хангаж ажиллалаа. "Агаарын чанарыг сайжруулах, мэдлэг үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл"-ийн удирдагч Орхон аймагт ажиллаж, төслийн хэрэгжилтийн явц, Эрдэнэт хотын агаарын чанарын тулгамдаж буй асуудлуудтай танилцаж, аймгийн удирдлага, мэргэжлийн байгууллагуудтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтаас гарсан шийдвэрийн дагуу Эрдэнэт хотын цэвэр агаарын төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тус тус боловсруулан Монгол хэлээр орчуулж ирүүлээд байна. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлээр 13614 айл өрх, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 28 уурын зуух, 24398 авто тээврийн хэрэгсэл тоологдсон. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 166 өрх өөрийн хөрөнгөөр цахилгаан халаалт нэвтрүүлснээс гадна олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран нэмэлтээр Монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг нийт 109 өрхөд олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог 275-аар буурууллаа. Цаашид гэр, байшингийнхаа халаалтыг утаагүй технологиор
--	---	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

											өөрчилсөн өрх бүрт урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэхээр журмын төслийг боловсруулж байна.		
118		Байгальд ээлтэй газын хэрэглээ болон бусад үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжих	2021-2024	ХБТХ ОХ БОАЖ Г	ХЗА Сумдын ЗДТГ	БОХАХ 3 болон улсын төсөв	300.0	Хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл-1363 ш Хийн халаалтын систем-0	Хийн халаалтын систем -10	100.0	-	Эрдэнэт хотын хэмжээнд ахуйн болон тээврийн хэрэгслийн зориулалтаар шингэрүүлсэн шатдаг хийн түлш түгээдэг 4 аж ахуйн нэгж байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. "Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл"-ээр аймгийн хэмжээнд хийн хөдөлгүүртэй 1877 ширхэг, цахилгаан хөдөлгүүртэй 7 ширхэг, хосолсон хөдөлгүүртэй 9705 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь суурь түвшинтэй харьцуулахад хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 514 ширхгээр, цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 7-р нэмэгдсэн байна. Цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Leaf center ХХК-тай хамтран иргэдэд цахилгаан автомашины ач холбогдлыг танилцуулах өдөрлөгийг Амарын талбайд 4 өдрийн турш зохион байгуулж, 6 төрлийн цахилгаан автомашиныг нийт 10-12 мянган хүнд сурталчилж, мэдээллээр хангаж ажиллалаа. Цахилгаан автомашины хэрэглээг дэмжих зорилгоор томоохон худалдааны төвийн гадна зогсоолд цахилгаан машин цэнэглэх станц байрлуулахаар Leaf center ХХК-тай хамтран ажиллаж байна. Шанд багийн 17-р сургуулийн уурын зуухыг шинэчлэх, бие даасан эрчим хүчний үүсвэртэй байлгах, агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бүрэн автоматжуулагдсан 1400 квт-ын хүчин чадалтай, тохируулга бүхий хяналт удирдлагын системтэй хийн түлшний усан халаалтын зуух суурилуулахаар техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг гаргаж, худалдан авах ажиллагааг зарласан.	100%
119	4.1.6.Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.	Эрдэнэт хотын хатуу хог хаягдлын боловсруулах, татан зайлуулах менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх	2021-2023	ХБТХ ОХ ХЗА	ХТГ	Гадаадын зээл	30150.0	-	Төслийн хэрэгжилт 90%	1507.5	-	Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийг Улаанбаатар хотноо 2017 онд байгуулсан. Бүгд Найрамдах Польш улсын Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэхээр Польш улсын ППЭйч Мелиорекс ХХК шалгарч, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын гэрээг Орхон	70%

												аймагтай 2019 онд байгуулсан. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох хог хаягдлыг татан зайлуулах 12 ширхэг машин механизмыг бүрэн хүлээн авч Хот тохижуулах газар хүлээлгэн өгсөн. Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулахаар барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Төслийн гүйцэтгэгч, Орхон аймагтай байгуулсан ажлын гэрээг сунгахаар 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр хийгдэж гэрээ 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хүртэл сунгагдсан.	
120		Олон нийтэд хог хаягдлын талаар боловсрол олгох, үүрэг хариуцлага оролцоог нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах	2021-2024	ХЗА	БОАЖ Г Баян-Өндөр сумын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлсэн байна.	Иргэдийн оролцоог 10%-иар нэмэгдүүлнэ.	5.0	-	Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 2023 онд "Иргэн иргэндээ-хөрш хөршдөө" нөлөөлье хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөн Баян-Өндөр сумын 1050 хөршийн холбооны ахлагч нарыг чадавхжуулах ээлжит сургалтыг 2023 оны 02-р сард зохион байгууллаа. Тус сургалт, үйл ажиллагаагаар Сургалтын ЛАБ-ын сургагч багш хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр хөршийн холбоодын ахлагч нарыг мэргэшүүлэх, чиглүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүнд: - Орон нутгийн хөгжлийн бодлогуудад иргэдийн саналыг тусгах үйл ажиллагааг хөршийн ахлагч нараар дамжуулж хүртээмжтэй болгох - Хог хаягдлын талаар иргэдийн дадал, хандлага өөрчлөх - Иргэдтэй ажиллахад шаардлагатай ур чадварт суралцуулах - Хөршийн ахлагч нар хамтран санаачилж ажил хэрэгжүүлэхэд нь дэмжих - Хөршийн ахлагч нарыг иргэд, олон нийтэд таниулах зэрэг ажлуудыг зохион байгуулаад байна. 2023 онд хотын 2 удаагийн их цэвэрлэгээг зохион байгуулан 680 аж ахуйн нэгж байгууллагын нийт 1704 иргэн, албан хаагч оролцож, 529632 м² талбайд цэвэрлэгээ хийн 425 м³ хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн. Хог хаягдлыг ангилан ялгах, хор нөлөө, тархалтыг бууруулах талаарх мэдээллийг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагуудын пейж хуудас, олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд тогтмол түгээж байна.	100%

121		Хот тохижуулах газарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг үе шаттай хийх	2021-2024	ХЗА ХТГ	ХБТХ ОХ	Орон нутгийн төсөв	Тухайн төсвийн хүрээнд	Парк шинэчлэлт 5%	Парк шинэчлэлт 45%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 2650.0	Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах" төслийн хүрээнд хог хаягдлыг татан зайлуулах 12 ширхэг машин механизмыг Хот тохижуулах газар хүлээлгэн өгсөн. 2023 онд орон нутгийн төсвийн нийт 2.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хот тохижуулах газрын парк шинэчлэлтийг хийж байна. Үүнд: Хог хаягдал ачиж тээвэрлэх 20 ширхэг хөдөлгөөнт чингэлэг худалдан авсан. Мөн машин механизм, хөдөлгөөнт чингэлэг нийлүүлэх гүйцэтгэгчээр шалгарсан Хьондай ХХК 45 ширхэг хөдөлгөөнт чингэлгийг нийлүүлж, хог хаягдлыг ачиж тээвэрлэх 7 ширхэг автомашиныг хүлээлгэн өгсөн. Парк шинэчлэлтийг хийснээр Хот тохижуулах газарт 49 машин механизм, 110 хөдөлгөөнт чингэлэгтэй болж, гэр хорооллын хог ачилтыг жилд 7-8 удаагийн хог татан авах нөхцөл бүрдүүлсэн нь өмнөх жилүүдээс хог татан авалтыг 2-3 удаагийн давтамжаар нэмэгдүүлээд байна.	90%
122	4.1.7.Гүний усны ашиглалтын хязгаарлан, гадаргын усны хуримтлал бий болгож, усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, аймгийн цэвэр усны хангамжийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.	Гадаргын усны чанарын хяналт, мониторингийг тогтмол, хуваарийн дагуу хийж мэдээллээр хангах	2021-2024	УЦУО ШТ	БОАЖ Г МХГ	Улсын төсөв	-	-	MNS 4586:1998 Стандартын түвшин	-	-	УЦУОШТ-ийн байгаль орчны шинжилгээний лаборатори нь Хангал, Эрдэнэт, Орхон голуудаас 2023 онд 76 сорьц авч 23 үзүүлэлтээр нийт 1748 удаагийн давталттай чанарын хяналт-шинжилгээг "MNS 4586:1998 усан орчны чанарын үзүүлэлт ерөнхий шаардлага"-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр: Хангал голын эрдэсжилт 422-995мг/л, аммоны азот Хангал-Эрдэнэт доод цэг дээр 2.0-16.9 дахин давсан байна. Хангал-Улаантолгой цэг дээр биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 5, 9-р саруудад хүлцэх агууламжаас 1.4-1.5 дахин давсан байна. Хангал-Эрдэнэт дээд, Хангал-Хангал өртөө цэгүүдэд усны чанар хэвийн горимд байна. Хангал гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой түвшинд байна. Орхон-Хангал дээд цэгийн эрдэсжилт 169.0-577.5мг/л хооронд хэлбэлзэж хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй байна. Орхон-Хангал доод цэгийн эрдэсжилт 392.1-1031.9мг/л хооронд хэлбэлзэж, умбуур бодисын агууламж Хангал голын нөлөөгөөр ихэссэн байна. Орхон гол 2-р зэрэг буюу цэвэр гэсэн ангилалд байна. Хяналт шинжилгээний дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн сан болон Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторид сарын бүрийн 5-ны өдрийн дотор дамжуулан аймгийн УЦУОШТ-ийн	100%

												http://orkhon.tsag-agaar.gov.mn/ сайтад сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна.	
123		Бохирдуулагч эх үүсвэрүүдийн технологийн хяналтыг сайжруулж, сөрөг нөлөөллийг бууруулах	2021-2024	МХГ БОАЖ Г	УЦУО ШТ	ААНБ- ын өөрийн зардлаа р	-	-	-	-		Цэвэрлэх байгууламжийн 24 дээж, хяналтын цооногийн 183 дээжид хяналт шинжилгээ хийсэн. Томоохон бохирдуулагч эх үүсвэрүүд болох 28 үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хянан баталгаажуулж, технологийн болон холбогдох хууль, журмын хүрээнд тогтмол хяналт тавин дүгнэж ажиллалаа. Бохирдуулагч эх үүсвэрүүдийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2023 онд төлөвлөгөөт хяналт шалгалтаар 28 аж ахуйн нэгж, байгууллага, төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 91 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад хийж, 51 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд улсын байцаагчийн албан шаардлага, 10 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зөвлөмж, 30 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд мэдэгдэл өгч, Байгаль орчны багц хууль зөрчсөн 19 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 12.1 сая төгрөгийн торгууль, 28.9 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, зөрчлийг арилгуулж ажиллалаа.	100%
124		Хөв цөөрөм байгуулах, булаг шандын эх ундаргыг хамгаалж, тохижуулах	2021-2024	ХЗА БОАЖ Г	Сумд ын ЗДТГ	БОХАХ 3	252.0	Хөв цөөрөм 1ш , булаг шанд 3	3	9.0	Орон нутгийн төсөв 284.0 Гадаадын хөрөнгө оруулалт 60.0	Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр Уртбулаг, Ар булгийн урсацыг нэмэгдүүлэх боломжийн судалгааны ажлыг Шинжлэх ухааны академийн газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн судалгааны баг хийж, булгуудын дэд сав газрын физик газар зүйн нөхцөл, хөрсний шинж чанар, гадаргын усны чанар, газрын доорх усны чанарыг тодорхойлох зорилгоор дээж авах ажлыг зохион байгууллаа. Дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах Баянцагаан, Далиу, Долоонбулаг, Хөөвөр, Хүрэнбулаг зэрэг 5 булгийн эх ундаргыг бүрэн хашиж, сэргээн засварлах ажлыг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулан ажиллаж байна. Бүрэнбүстийн овооны хөв цөөрмийн ажлыг 2023 онд иж бүрэн дуусгах ажлын гүйцэтгэгчээр Ээлт-Өлгий ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаад байна. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хөв цөөрмийн хамгаалалтын хашааны зардалд 60.0 сая	90%

											төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласнаар 740м урт хамгаалалтын хашааг бариулж ашиглалтад авлаа.	
125		Айл өрхүүдийн хашаанд гаргасан ундны усны худгуудаас дээж авч шинжилгээнд хамруулан дүгнэлт гаргаж мэдээллээр хангах	2021-2024	БОАЖ Г	МХГ	БОХАХ 3	20.0	Шинжилгээнд хамруулсан худгийн тоо 11	Шинжилгээнд хамрагдах худгийн тоо 60	5.0	Орон нутгийн төсөв 12.0	100%
126		Гадаргын болон газрын доорх усны чанарын хяналт, мониторингийн сүлжээг өргөтгөх, ус бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах	2021-2024	БОАЖ Г Татварын хэлтэс	МХГ СГСГ 3	БОАЖЯ, БОХАХ 3	70.0	Мониторингийн цооног тоноглох, 2 ш Ус бохирдуулагч эх үүсвэр, 10 %	1 багц	35.0	Орон нутгийн төсөв 45.0	100%

												бөгөөд газрын доорх усны ордын цаашдын ашиглалтын горим, бодлогыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм. 2023 онд улсын төсөвт ус бохирдуулсны төлбөрөөр 832.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.	
127	4.1.8.Хот орчмын орон нутгийн хамгаалалтай газарт таримал ойн төгөл, ногоон зурвас байгуулж, жилд ойжуулах талбайг хэмжээг нэмэгдүүлж, тарьц, суулгацын нөөц бүрдүүлнэ.	Эрдэнэт хотын ойролцоох суурьшлын бус газруудад үе шаттайгаар мод тарьж, ойн төгөл, зурвас байгуулах	2021-2024	БОАЖ Г ХЗА	“Эрдэ нэт үйлдвэр” ТӨҮГ	БОХАХ 3, дүйцүүлэн хамгаалах зардал	352.0	1 га	18 га	50.0	Орон нутгийн төсөв 436.0	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих Ногоон Эрдэнэт хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 онд Чимээгүй хотын хамгаалалтын ойн зурвас, Цагаанчулуутын ам, А1001 авто зам дагуух ойн зурвас, Эрдэнэт хаалга, зэрэг газруудад таримал ойн зурвас байгуулж 11500 ширхэг навчит болон шилмүүст мод, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ хаягдлын аж ахуйн орчимд Цагаан тоосны дэгдэлтийг сааруулах зорилгоор ойн зурвас байгуулах ажлыг 50 га талбайд 100000 ширхэг мод тарих зэрэг ажлуудыг олон нийтийн оролцоотой зохион байгуулж 56 га талбайгаар нэмэгдүүлэхэд Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаас 261.0 сая төгрөгийг зарцуулсан. 2023 онд Бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлын хүрээнд Дэнж багийн нутаг дэвсгэр, Тарлан толгойн энгэр суурьшлын бүсэд 17.5 га талбайг хашаажуулж, ойн төгөл байгуулахаар мод тарилтын ажлыг зохион байгуулсан. Хүрэнбулагийн аманд "Гэр бүлийн ойн төгөл", Жаргалант суманд 6.6 га талбайд газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал голын дагуу, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх зэрэг газруудад олон нийтийн оролцоотой 12.66 га талбайд мод тарих ажлыг шат дараатайгаар зохион байгуулж, таримал ойн хэмжээг 36.76 га талбайгаар нэмэгдүүлж, нийт өссөн дүнгээр 92.76 га талбайд мод тарьж, ойн төгөл, ойн зурвас байгууллаа.	100%
128		Жилд ойжуулах талбайн хэмжээг 25 га-д хүргэх, хэрэгцээтэй тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэх	2021-2024	БОАЖ Г	СДОА	БОХАХ 3	137.5	14 га	21	23.1	Орон нутгийн төсөв 129.6	2022 онд Жаргалант сумын Хөндлөнгийн амны ойн санд орон нутгийн төсвийн хөрөнгө 19.5 сая төгрөгөөр ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлыг ойн мэргэжлийн байгууллага "Хөвөнтөн ой" ХХК-аар гүйцэтгүүлж ойжуулсан талбайг 18 га талбайгаар нэмэгдүүлж 62 га талбайд хүргэсэн. 2023 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ойн мэргэжлийн байгууллагаар Жаргалант сумын	100%

												Хонгор морьтын амны ойн сангийн 48 га талбайг, Баян-Өндөр уулын Цагаанчулуутын аманд Япон улсын Оиска ТББ-ын дэмжлэгтэйгээр "Сайвар хээр" ХХК-аар 4 га талбайд тус тус ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлж нийт 52 га талбайг ойжууллаа. Нийт өссөн дүнгээр ойжуулсан талбайг 114 га талбайд хүргээд байна. Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудад тарьц, суулгацын нөөц 7 дахин нэмэгдэж үрийн нэгдсэн тооллогыг зохион байгуулж 4 төрлийн шилмүүст модны 0.4 сая ширхэг, 20 төрлийн навчит модны 2.0 сая ширхэг тарьц, суулгацын нөөц бүрдүүлээ.	
129	4.1.9.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны улмаас болон хууль бус үйл ажиллагаанаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүн, хариуцлагыг дээшлүүлнэ.	Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жилд 1 га доошгүй техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэх	2021-2024	БОАЖ Г МХГ ЦГ	Сумын ЗДТГ	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын өөрсдийн зардлаар	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын өөрсдийн зардлаар	1190.24 га	5 га	-	Орон нутгийн төсөв 16.0	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган батлуулсны дагуу ил уурхайн 3 дугаар овоолго дээр 3.9 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж 1000 ширхэг мод тарьж, арчлан хамгаалж, ургуулаад байна. Дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудтай "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ орон нутгийн тусгай хамгаалалттай Баян-Өндөр хайрхны зүүн талын энгэрт Хүрэнбулагийн аманд 2 га талбайд 630 метр хамгаалалтын хашаа хийж, 4 төрлийн 1500 ширхэг мод, Эрдмин ХХК нь Эрдэнэт шинэ хаалга болон Хангал голын голдирол дагуу 1 га талбайд 560 метр хамгаалалтын хашааг хийж, ногоон зурвас байгуулж 1000 ширхэг мод, Ачит-Ихт ХХК эрдэнэт шинэ хаалга болон Хангал голын голдирол дагуу 1 га талбайд 500 метр хамгаалалтын 2 хэсэг төмөр хашаа хийж 1144 ширхэг мод, Гал сэнтий ХХК нь Эрдэнэт голын голдирол дагуу 140 метр хамгаалалтын хашааг хийж 1000 ширхэг мод, Очир төв ХХК Хангал гол дагуу 500 ширхэг улиас моднуудыг 0.5га талбайд, Зэс эрдэнийн хувь ХХК үйлдвэрийнхээ авто замын ногоон зурваст 1000 ширхэг улиас, Дэлт хошуу ХХК үйлдвэрийнхээ авто замын ногоон зурваст 500 ширхэг агч моднуудыг тус тус тарьж нийт 8.4 га талбайд мод тарьж арчлан хамгаалж, ургуулан ажиллаж байна. Улсын хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон 8000 га талбайгаас Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 2021-2024 оны хугацаанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь	100%

												2000 га-д техникийн нөхөн сэргээлт хийхээс 2023 оны жилийн эцсийн байдлаар 1200 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийгээд байна.	
130		Аймгийн хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон газруудын нөхөн сэргээлтийг үе шаттайгаар гүйцэтгүүлж нийтийн эзэмшилд шилжүүлэх	2021-2024	БОАЖ Г МХГ ЦГ	Сумы н ЗДТГ	БОХАХ 3	47.5	10	2 га	9.5	Орон нутгийн төсөв 16.0	Аймгийн хэмжээнд эвдэрч эзэнгүй орхигдсон газруудад техникийн нөхөн сэргээлт хийх ажлын хүрээнд 2020-2023 онд нийт 11.5 га талбайд нөхөн сэргээлтийн эрхтэй мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж ажиллалаа. Үүнд: • 2020 онд Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт Хивсний үйлдвэр “Өнөр хороолол”-ийн ард талд эвдэрч, эзэнгүй орхигдсон карьерын 2 га-д, Жаргалант сумын Дулаан уул багийн нутаг дэвсгэрт “Бүтлийн ундарга” ХХК-ийн ар талд Бумбан толгойн хойд энгэрт болон төв зам дагуу эвдэрч, эзэнгүй орхигдсон 2 га-д, • 2021 онд Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт буюу 18 карьерын зүүн хойд талын уулын аманд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га-д, Говил багийн нутаг дэвсгэрт Чингэлбөөн цагааны карьерын баруун талд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га-д, • 2022онд Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт 18 карьерын зүүн хойд талд эвдэрч эзэнгүй орхигдсон 2 га-д, • 2023 онд Жаргалант сумын Улаантолгой багийн нутаг дэвсгэрт буюу Тасгийн толгойд эвдэрч, эзэнгүй орхигдсон 1.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын дагуу тус тус гүйцэтгүүлж ажиллалаа.	100%
131	4.1.10.Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, аж ахуйн нэгж, байгууллагуудаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, цагаан тоосны дэгдэлтийг	Аж ахуйн нэгж, байгууллагуудаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, сөрөг нөлөөллийг бууруулах	2021-2024	МХГ БОАЖ Г	МХГ БОАЖ Г	ААНБ-ын өөрийн зардлаар	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдсан ААНБ-ын тоо 32	ААНБ-ын тоо 5	ААНБ-ын өөрийн зардлаар	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг И-Монголиа цахим системд шилжүүлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар шинээр хэрэгжих болон хэрэгжиж буй нийт 56 төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, тус төслүүдийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэж, БОАЖЯ-ны цахим мэдээллийн санд оруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажиллаж байна.	100%

132	бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.	Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах богино хугацааны хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2021-2024	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	ХБТХ ОХ БОАЖ Г	ААНБ-ын өөрийн зардлаар	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зардлаар	10%	70%	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зардлаар	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын зардлаар	"Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр" 2022 онд хугацаа дууссан тул аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал болон аймгийн ИТХ-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 85 хувьтай дүгнүүлсэн. Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ИТХ-ын Хөгжлийн хороо, ажлын албаны төлөөлөл, аймгийн ЗДТГ, мэргэжлийн агентлагууд хамтран Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хаягдлын аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж, Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажилтай газар дээр нь танилцаж, тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийн талаар нээлттэй уулзалт зохион байгуулсан ба цаашид хөтөлбөр төлөвлөгөөг үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн тул шинэчлэн, боловсруулж, нөлөөллийн бүсийн багуудын ИНХ-аар хэлэлцүүлжээ. Цагаан тоосны сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 67 дугаар тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Хаягдлын аж ахуйг нүүлгэн шилжүүлэх чиглэл өгсний дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас хаягдал өтгөрүүлэх технологийн ТЭЗҮ-г боловсруулан батлуулж, 2027 онд ашиглалтад оруулахаар технологийн ажил хийгдэж байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, зорилгоор тоос дарагч 3 төрлийн бодисыг устай хольж тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж ашиглан хуурайшилттай талбайд цацах, хаягдал булингад хольж өгөх, үйлдвэрийн технологийн аргуудыг хослуулан Хаягдлын аж ахуйн тоос идэвхтэй дэгддэг 1100 га хуурай талбайн 85%-ийг тогтмол дарж ажиллалаа.	70%
ЭРҮҮЛ ХҮНС													
133	4.2.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.	“Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж хүн амын хүнсний хэрэгцээт мах, төмс, гурилыг бүрэн, хүнсний ногооны 50-аас доошгүй хувийг орон нутгийн	2021-2023	ХХАА Г ХБТХ ОХ	МХГ ЭМГ Сумын ЗДТГ СХЗХ	Орон нутгийн төсөв	75.0	Хэрэгжилтийн хувь 30%	Хэрэгжилтийн хувь 100%	25.0	-	2022 оны хүн амын физиологийн хэрэгцээг тооцоход малын махны 92.7 хувь, гурилан бүтээгдэхүүний 34.5 хувь, жимс, жимсгэний 0.3, төмсний 86.5 хувь, хүнсний ногооны 72 хувь, өндөгний 2.3 хувийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангасан бол шингэн сүүний 2.7 хувь, цагаан идээний 5.4 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүнээр хангасан. "Эрүүл Хүнс-Эрүүл Монгол Хүн" хөтөлбөр нь 2020-2021 онд 85.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон.	100%

		үйлдвэрлэлээс хангах										"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Орхон аймагт 2022-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 12/02 дугаар тогтоолоор батлуулж, шаардагдах 52.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлснээр 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн, 1 арга хэмжээ хэрэгжилтийн шатанд, 3 арга хэмжээ төлөвлөгдсөн хугацаа хүлээгдэж байна. Аймгийн хэмжээнд мал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхээр нийт 58 аж ахуйн нэгж, иргэн бүртгэгдсэнээс мах, махан бүтээгдэхүүний 10, гурил, малын тэжээлийн 5, сүү, сүүн бүтээгдэхүүний 4, гурилан бүтээгдэхүүний 24, ургамлын цайны 1, нөөшилсөн ногооны 4, нийт 49 цех болон үйлдвэрүүд байна. Эдгээрээс тохирлын гэрчилгээтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа гурил, тэжээл үйлдвэрлэгч 3, мах, махан бүтээгдэхүүний 5, сүү, сүүн бүтээгдэхүүний 2, гурилан бүтээгдэхүүний 14, ургамлын цайны 1, нийт 26 цех болон үйлдвэрүүд байгаа бөгөөд нийт үйлдвэрлэл эрхлэгчдийн 53 хувь нь тохирлын баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. 2023 оны байдлаар аймгийн хүн амын хэрэгцээт малын махны 60.2, сүүний 4.0, цагаан идээний 4.6, гурилан бүтээгдэхүүний 42.6, улаан буудай 100.0, төмсний 43.3, хүнсний ногоо 100.0 хувь тус тус орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.	
134		Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумы н ЗДТГ	Орон нутгийн төсөв	184.0	Хэрэгжилтийн дундаж хувь 85%	Хэрэгжилтийн хувь 100%	46.0	-	УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого", аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 63 дугаар тогтоолоор "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр" батлагдаж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тус хөтөлбөрийн хүрээнд хаврын тариалалт, намрын ургац хураалт, малын үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ, хүн амын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зэрэг ажлыг зохион байгуулан ажилласнаар тус хөтөлбөр 94.9 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж дууссан ба УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болсон.	94.9%
135		Хаврын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор махны нөөц бүрдүүлэх	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Хувийн хэвшил	Орон нутгийн төсөв	2.200.0	Хаврын хэрэгцээт махны 25%-ийг хангасан.	50-аас доошгүй хувийг хангана.	600.0	-	Аймгийн хүн амын 2021, 2022 оны хаврын хэрэгцээнд нийт 450 тонн үхэр, хонь, ямааны махны нөөц бэлтгэн зах зээлд нийлүүлсэн. 2023 оны хаврын махны нөөц бэлтгэхэд 500.0 сая төгрөг батлагдсан. Авлигатай тэмцэх газраас	70%

											ирүүлсэн зөвлөмжийн дагуу нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер зарласан боловч хүчингүй болж, дахин тендер зарлах нь нөөцийн мах бэлтгэгдэн худалдаанд гарах цаг хугацааны хувьд боломжгүй, мах борлуулах хугацаа хоцорч үр дүнгүй ажил болох болсон тул орон нутгийн төсвөөс хөрөнгө зарцуулан нөөцийн мах бэлтгэж худалдаанд гаргаагүй. Орон нутгийн төсвөөс нөөцийн мах бэлтгэн худалдаанд гаргаагүй ч “Өвлийн идэш” арга хэмжээгээр иргэд 63.5 тонн малын мах худалдан авснаар өвлийн идшээ хямд нөөцлөх боломж бүрдсэн. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 махны үйлдвэр өөрсдийн нэрийн дэлгүүрээр 150 тн мах зах зээлд нийлүүлснээр 2023 онд хаврын улиралд аймгийн хэмжээнд махны хомсдол үүсээгүй.		
136	4.3.Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.	Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийн хэрэгжилтийг ханган ажиллах	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	ЭМГ МХГ	Орон нутгийн төсөв	15.0	Бүтээгдэхүүний давсны агууламж 47.9 хувиар буурсан.	Бүтээгдэхүүний давсны агууламж 53.0 хувиар буурна.	5.0	-	Хүнсний боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 үйлдвэр, цехэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний давсны орц, найрлагыг бууруулах зөвлөмж мэдээлэл хүргэж ажилласан. Энэ онд түүврийн аргаар орон нутагт үйлдвэрлэгддэг 8 хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн 9 дээж авч, давсны агууламжийг тодорхойлоход бүгд зохист хэмжээнд хэрэглэж хэвшсэнээс гадна бүтээгдэхүүний давсны агууламжийг 53.8 хувиар бууруулсан байна. "Давсны мэдээлэл сурталчилгааны 7 хоног"-ийг "Давсаа хасъя" уриан дор тэмдэглэн өнгөрүүлж давсны зохистой хэрэглээ, хэтрүүлэн хэрэглэхийн хор уршгийг олон нийтэд сурталчилж ажилласан. Тус аяны үеэр төр, хувийн хэвшлийн байгууллагуудад хандсан "Давсаа хэтрүүлэн хэрэглэх дадлаа зогсооё" уриалгыг хүргүүлсэн. "Давсны зохистой хэрэглээ" сургалтад цэцэрлэг, сургуулийн 47 эмч, 7 хоол зүйч, 46 тогоочийг хамрууллаа. Мөн цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийн нийт 1879 эцэг, эхчүүдэд эмч нараар дамжуулан хүнсний бүтээгдэхүүний шошго унших, давсны агуулга харах талаар сургалт зохион байгуулж 1100 ширхэг сурталчилгааны материал эмнэлэг, сувилал, сургууль, цэцэрлэг, албан байгууллагуудад хүргүүлэн "Давсны хэрэглээ ба эрүүл мэнд" сэдэвт цахим хичээл, зөвлөмжийг олон нийтэд түгээсэн. Хүүхдэд олгож буй хоолны	100%

												давсыг хэмжих зорилгоор ерөнхий боловсролын 3 сургуулийг давс хэмжигчтэй болгосон.	
137		Хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартын талаар үйлдвэрлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх	2022-2024	СХЗХ ХБТХ ОХ	ХХАА Г	Орон нутгийн төсөв	6.0	20 үйлдвэрлэл эрхлэгч	20 үйлдвэрлэл эрхлэгч	2.0	Орон нутгийн төсөв 2.0	“Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” сэдэвт сургалтад 3 аж ахуйн нэгж, байгууллагын 7 ажилтан хамруулснаар махны 1 үйлдвэрийн лаборатори итгэмжлэгдэж, төрийн 1 лаборатори итгэмжлэлийн магадлан үнэлгээнд хамрагдсан. Бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх “Чанарын удирдлагын тогтолцоо–Шаардлага MNS ISO 9001” стандартын сургалтад 3 байгууллагын 11 хүнийг хамруулан гэрчилгээ олгосон. Менежментийн тогтолцооны аудитын заавар MNS ISO 19011:2020 стандартын сургалтыг 5 ахуйн нэгж, байгууллагын 12 хүнийг хамруулан сургаж гэрчилгээ олгосон. Хоол, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 20 байгууллагын ажилтнуудад салбарын болон бусад хууль, эрх зүйн уялдаа холбооны талаар мэдлэг олголоо. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрхзүйн мэдлэг, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах 1 сарын хөтөлбөрт сургалтыг Best хөтөлбөр, Обзерв Консалтинг хүнсний аюулгүй байдлын зөвлөх байгууллагатай хамтран зохион байгуулж, хүнсний боловсруулах 35 үйлдвэр, цехийн ажилтнуудыг 5 удаагийн сургалтад хамруулан сертификат олгосон.	100%
138		Тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх	2022-2024	СХЗХ	ХБТХ ОХ ХХАА Г	Орон нутгийн төсөв	9.0	Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь 0%	Аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүний эзлэх хувь	3.0	Орон нутгийн төсөв 3.0	2021-2023 онд тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн бий болгох зорилгоор 8 удаагийн сурталт зохион байгуулж иргэд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг мэдээллээр хангасан. 2023 оны байдлаар "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдгийг талх, нарийн боовны 3 үйлдвэрийн 4 нэр төрлийн 52 нэрийн бүтээгдэхүүнд олгосноор нийт 7 хүнсний үйлдвэрийн 6 нэр төрлийн 56 нэрийн бүтээгдэхүүн эзэмшиж байна. Техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг бүхий махны 3, сүүний 3, бялуун бүтээгдэхүүний 11, нийт 17 иргэн, аж ахуйн нэгжийн цех, үйлдвэр байгаагаас тохирлын үнэлгээнд хамрагдсан "Жүр үр" ХХК аюулгүйн тэмдгийг 12 нэрийн бялуун бүтээгдэхүүнд	90%

											хэрэглэх эрх авч, нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн 5.8 хувь нь аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна. Махны 1 үйлдвэр аюулгүйн тэмдэг авахаар үнэлгээнд хамрагдах бэлтгэл хангаж байна. Аюулгүйн тэмдгийн талаар мэдлэг ойлголтыг 191 хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд өгч, мэдээллийн самбарт нь зурагт хуудсаар байршуулах, орон нутгийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр түгээх зэргээр нийтэд сурталчилсан.		
139		Хүнсний аюулгүй байдлыг хангах (НАССР) болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2022-2024	СХЗХ ХБТХ ОХ	Хамтарсан багууд	Орон нутгийн төсөв	7.5	Хамрагдсан үйлдвэрийн тоо 5	Хамрагдсан үйлдвэрийн тоо 15	2.5	Орон нутгийн төсөв 2.1	2023 онд "Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019" болон MNS CAC/ RCP 1:2003 /НАССР/ стандартыг хэрэгжүүлэхийн тулд суурь стандарт болох Чанарын удирдлагын тогтолцооны 9001 стандартыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 3 аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлснээс Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хоол үйлдвэрлэлийн 5 нэгж, талх нарийн боовны 1 үйлдвэр гэрчилгээ авсан. 2 талхны үйлдвэрийг тухайн стандартын сургалт, арга зүйгээр ханган, хэрэгжүүлэлтийг дэмжин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 5 аж ахуйн нэгж, байгууллагын 8 үйлдвэрлэл, үйлчилгээнд стандартыг хэрэгжүүлэх ажил хийгдэж байгаагаас "Хаан хүнс картеринг" ХХК, "Эрдмийт" ХХК Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019 /НАССР/ стандартаар, "Жаргалант мах маркет" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК, "Эрдмийт" ХХК MNS CAC /RCP 1:2003 (НАССР) стандартаар тус тус гэрчилгээ авсан. "Жаргалант мах маркет" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК-д нь ISO:22000 стандартын 2 дахь шатны аудитад орж, "Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим "(олон улсын зөвлөмж) MNS CAC/ RCP 1:2003 стандартыг усны 1 үйлдвэр, нийтийн хоолны 2, талхны 2 үйлдвэр хэрэгжүүлж эхлээд байна. Нийт 16 үйлдвэр, үйлчилгээнд стандарт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.	70%
140	4.4.Мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг	Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Улсын болон орон нутгийн төсөв	210.0	Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	125.0 мянган толгой мал хамруулна.	55.0	Орон нутгийн төсөв 100.3	2022 онд аймгийн хэмжээнд нийт 112.2 мянган толгой мал, амьтныг халдварт, архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 11 төрлийн вакцин тарилгад хамруулахаас 105.0 мянган толгой мал, амьтныг хамруулж гүйцэтгэл 93.3 хувьтай хэрэгжсэн. 2023 онд мал, амьтны халдварт өвчнөөс	99.5%

	хангах мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж нийтийн эрүүл мэндийг хамгаална.							арга хэмжээнд 126.9 мянган толгой мал хамрагдс ан.				урьдчилан сэргийлэх зорилгоор 109.1 мянган толгой малыг 10 төрлийн вакцинд хамруулахаар төлөвлөж 111.9 мянган толгой мал, амьтныг хамруулсан. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Мал эмнэлгийн ерөнхий газрын "Бог малын өвчинтэй тэмцэх стратеги"-төлөвлөгөөний дагуу 317 өрхийн 65.8 мянган толгой ямаа, 14.8 мянган толгой ишиг, 21.8 мянган толгой хурга, нийт 102.4 мянган толгой бог мал хамруулж 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хавар, намрын дархлаажуулалтад нийт 51.3 мянган толгой мал, амьтан хамруулж 100 хувьтай хэрэгжсэн. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 192.0 мянган толгой мал хамруулахаас боловсруулалтад 56.5 мянга, туулгалтад 62.6 мянга, угаалгад 78.5 мянга, нийт 197.6 мянган толгой мал сүргийг хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн.	
141		Малын бруцеллөз, лейкоз, адууны халдварт цус багадалт, ям өвчнүүд болон архаг халдварт өвчнүүдтэй тэмцэх	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Улсын болон орон нутгийн төсөв	95.0	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тандалт судалгаанд 3.4 мянган толгой мал хамрагдсан.	9.0 мянган толгой мал хамруулна.	25.0	Улсын төсөв 11.6	2022 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын 142 өрхийн 978 хээлтүүлэгч малд бруцеллөзын тандалт шинжилгээ хийхэд нийт 978 хээлтүүлэгч малын 0.5 хувь нь халдвартай байсан. 2023 онд бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 24.0 мянган толгой бог мал хамруулахаар төлөвлөж 23.9 мянган толгой бог малын төл хамруулж гүйцэтгэл 99.7 хувь хэрэгжсэн. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор мал, амьтны зоонозын өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд "Бруцеллөзын хээлтүүлэгчийн тандалт-2023" шинжилгээ хийж гүйцэтгэх тандалт шинжилгээнд 176 өрхийн нийт 1194 хээлтүүлэгч мал хамруулахад 3.0 хувь нь эерэг урвал үзүүлсэн тул 7 хээлтүүлэгчийг хэрэгцээлүүлж, бусад хээлтүүлэгч малыг эрүүлжүүлэх арга хэмжээ авсан. Адууны нийлүүлгийн өвчний үүсгэгчийг илрүүлэх шинжилгээг 215 адууны цусны сорьцод хийж гүйцэтгэхэд 2.8 хувь нь халдварлалттай байна. ХХААХҮ-ийн сайдын 2012 оны А/54 дүгээр тушаалаар үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлжүүлэх чиглэлээр аймгийн 6 фермерийн 200 үхрээс дээж цуглуулж Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргүүлээд байна.	100%

												Адууны ям болон үхрийн сүрьеэ өвчний эрүүл бүс статус авахаар нийт 4400 малд харшил сорилын шинжилгээ хийж эрүүл бүсийг баталгаажуулсан.	
142		Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд антибиотек, пестицидийн үлдэгдлийг тодорхойлох, малын эмийн зохистой хэрэглээг хангах	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Орон нутгийн төсөв	160.0	124 дээжид антибиотек, пестицидийн үлдэгдлийг тодорхойлсон.	450 дээжийг шинжилгээнд хамруулна.	40.0	Улсын төсөв 4.2	2022 онд 755 дээжид мал эмнэлгийн магадлан шинжилгээ, эмийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийхэд нийт 7 дээж эерэг урвал үзүүлсэн тул устгасан. 2023 онд малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний 155 сорьцод 7 нэр төрлийн эмийн үлдэгдлийн шинжилгээ хийж гүйцэтгэхэд эмийн үлдэгдэл илрээгүй. 2021-2023 онд давхардсан тоогоор 19900 дээжид эмийн үлдэгдлийн болон мал эмнэлгийн лабораторийн магадлан шинжилгээ хийсэн байна.	90%
143		Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2021-2024	МЭГ	ХБТХ ОХ	Орон нутгийн төсөв	24.0	221.0 мянган м/кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийсэн.	200.0 мянган м.кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийнэ.	6.0	Орон нутгийн төсөв 14.3	2021-2022 онд нийт 587 толгой мал, амьтны сэг зэмийг цуглуулан зөөвөрлөж, хогийн төвлөрсөн цэгт зориулалтын нүхэнд булж устган, 576.8 мянган мкв талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийсэн. 2023 онд нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 2458 мал, амьтны сэг зэмийг устган 565.0 мянган м.кв талбайд ариутгал, халдваргүйтгэл хийсэн. Тус ажилд орон нутгийн төсвөөс 14.3 сая төгрөг зарцуулсан.	100%
ТАВ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ													
ГАЗРЫН ХАРИЛЦАА, ХОТ БАЙГУУЛАЛТ													
5.1.Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.													
144	5.1.1.Орхон аймгийн газар зохион байгуулалтын 2021-2037 он хүртэлх 16 жилийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын дагуу мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авах	2021-2024	Аймгийн ЗДТГ ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	85.0	-	Төлөвлөгөөний 15%-ийг хэрэгжүүлсэн байна.	-	-	Аймгийн газар зохион байгуулалтын 2022-2037 оны ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллага "Ланд овнер" ХХК-аар гүйцэтгүүлэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12/03 дугаар тогтоолоор батлуулж, 28 арга хэмжээний хүрээнд Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд төсөл үүсгэн арга хэмжээг мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Баян-Өндөр, Жаргалант сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумдын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажилласнаар ерөнхий төлөвлөгөө 15 хувийн хэрэгжилттэй байна.	100%
145		Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг	2021-2024	ГХБХ БГ	БОАЖ Г ХХАА Г	-	-	84517 га	Төлөвлөгөөний 15%-ийг	-	-	Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Баян-Өндөр сумын	100%

		аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан үе шаттай зохион байгуулах		Сумдын ЗДТГ					хэрэгжүүлсэн байна.			ИТХ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг, 2023 оны 13/06 дугаар тогтоолоор нэмэлт тодотгол хийж нийт 12 арга хэмжээний хүрээнд төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласнаар хэрэгжилт 90.0 хувьтай байна. Жаргалант сумын ИТХ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулж нийт 11 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус төлөвлөгөөгөөр иргэд аж, ахуйн нэгж байгууллагад 442.74 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөгдсөнөөс 371.9 га газрыг эзэмшүүлж, Жаргалант сумын Дулаан-Уул багт байрлах Цагаан хустанд зуслангийн зориулалтаар иргэдэд эзэмшүүлэхээр төлөвлөсөн 7.51 га газар нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ашиглалтын лицензийн талбайтай давхацсан тул 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Жаргалант сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 83.9 хувьтай байна.	
146	5.1.2.Эрдэнэт хотод гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг батлагдсан стандартын дагуу хэрэгжүүлнэ.	Эрдэнэт хотын гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж, батлуулах	2021-2024	ХБТХ ОХ ГХБХ БГ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	-	-	Гэр хорооллын багуудад хаягжуулсан байна. 50%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 51.0	Хаягжуулалтын тухай хуулийн дагуу Орхон аймгийн хаягжуулалтын зураг боловсруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгээд байна. Үүнд: - Баян-Өндөр сумын ИТХ-ын 2020 оны 06, 40 дүгээр тогтоолуудаар батлагдсан гэр хорооллын 14 багийн 930 гудамжны нэр, Жаргалант сумын ИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан 3 багийн 73 гудамжны нэр, 23038 нэгж талбарыг мэдээллийн санд бүртгэж оруулсан. Үүнээс 2023 онд 2630 нэгж талбарт хаягийн мэдээлэл олгогдсон. Зайлшгүй нэр өгөх шаардлагатай 57 гудамж /хотын доторх 35 гудамж, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын эзэмшил газар доторх 22 гудамж/-нд нэр өгөх ажлыг 2023 оны 10-р сард Аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл, Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах комиссоор хэлэлцүүлэн сумын ИТХ-ын ээлжит 15 дугаар хурлаар Аврагчдын гудамж, Эрдэнэт үйлдвэр орчмын хэсгийн гудамж талбайн нэршлийг баталсан. Хаягжилтыг батлагдсан стандартын дагуу Шанд багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг	70%

												24ш, хашааны дугаарын тэмдэг 610ш, Дэнж багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 56ш, хашааны дугаарын тэмдэг 1200, Рашаант багт гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг 43, хашааны дугаарын тэмдэг 1000 ширхэгийг хийхэд орон нутгийн төсөвт 51.0 сая төгрөг тусган, ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Межин хишиг” ХХК-тай гэрээ байгуулах ажил хийгдэж байна.	
147		Эрдэнэт хотын гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын ажлыг иргэд, олон нийтэд сурталчилж, зохион байгуулах	2021-2024	ХБТХ ОХ ХББЗ А ГХБХ БГ	ХЗА Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	-	-	8 багт сурталчилна.	Батлагдсан төсвийн хүрээнд	-	2023 онд Жаргалант, Баян-Өндөр суманд зохион байгуулсан "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгүүдийн үеэр e-gazag цахим системийн танилцуулга 560 ширхэгийг хэвлэж олон нийтэд тарааж нийт 729 иргэнд хүрч үйлчилсэн байна. Мөн Эрдэнэт хотын гудамж, талбайн хаягжуулалтын зургийг erdenet.gazag.gov.mn цахим хуудсанд байршуулан давхацсан тоогоор 1250 иргэд мэдээлэл авсан байна.	100%
148	5.1.3.Газар ашиглалт, газрын төлөв байдал чанарын хянан баталгаа, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжинэ.	Суурьшлын бүсэд газрын төлөв байдал чанарын хянан баталгааны дүгнэлт гаргах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авах	2021-2024	Аймгийн ЗДТГ ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	50.0	-	Жил бүр 5-10 га	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Жаргалант сумын 12956.50 га газарт хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг мэргэжлийн байгууллага "Гео батаник" ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авсан. 2023 онд аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий 15 аж ахуйн нэгжээс газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч 700 иргэн, аж ахуйн нэгжийн 74 га газрын захиалгат чанарын хянан баталгааны тайланг баталгаажуулсан байна.	100%
149		Газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын цэгийг сайжруулах, нэмэгдүүлэх	2021-2024	ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	-	-	7 цэг	Хяналтын цэгийг сайжруулсан байна.	-	-	2021 онд Жаргалант суманд 3 цэгийг шинээр байгуулсан. 2023 онд шинээр Жаргалант сумын Дулаан-Уул багт 2 мониторингийн байнгын ажиглалтын сүлжээний цэгийг нэмж байгуулан аймгийн хэмжээнд 10 мониторингийн цэг бүхий 38614.70 га бэлчээрийн газрыг хамруулан судалгааны ажлыг зохион байгуулж бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлсэн ажлын тайлан, хот тосгон бусад суурин газрын байнгын ажиглалтын мониторингийн 10 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэн дүгнэлт тайлан мэдээг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн хүргүүлэн ажиллалаа.	100%
150		Газар хамгаалах, нөхөн сэргээсэн ажлын гүйцэтгэлийг	2021-2024	ГХБХ БГ БОАЖ Г	Сумдын ЗДТГ МХГ	-	-	-	Жил бүр 5 га	-	Орон нутгийн төсөв 16.0	2021-2022 онд Баян-Өндөр сумын Говил багийн нутаг дэвсгэрт "Чингэл бөөн цагаан" ХХК-ийн хойд талд 2 га газарт Байгаль хамгаалах сангийн зардлаар, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт	100%

		цахим мэдээллийн санд бүртгэх									“Вондер вон” ХХК -ийн зардлаар 2 га газарт тус тус нөхөн сэргээлтийн ажлыг хийж нийт 19.0 сая төгрөг зарцуулсан. Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрт элэгдэж эвдэрч эзэнгүй орхигдсон 2.0 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж, талбайн солбицлыг байгаль орчны нэгдсэн мэдээллийн санд бүртгэсэн. Жаргалант суманд 11865.5 га өвөл хаврын бэлчээрийг чөлөөлж, 482 га бэлчээрийг хашиж хамгаалж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Жаргалантын энгэрт 468 га бэлчээр, Хөндлөн намгийн хойно 630 га бэлчээрийн газрыг усжуулах 2 худаг байгуулсан. Тайлант онд Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар Жаргалант сумын Улаантолгой багийн нутаг дэвсгэр Тасгийн толгойд эвдэрч, эзэнгүй орхигдсон 1.5 га газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын эрхтэй Өү би би таун ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж актаар хүлээн авлаа. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр дэх Мо-гийн айлуудын урд талд ухагдаж эвдэрсэн 0.5 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг "Очир төв" ХХК-аар, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ ил уурхайн 3 дугаар овоолго дээр 3.9 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж, 500 ширхэг хайлс, 500 ширхэг шинэс мод тарьж, нийт 5.9 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулан БОАЖЯамны цахим мэдээллийн сан, Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн цахим системд оруулж бүртгүүлэн ажиллалаа.		
151	5.1.4.Геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байр зүйн зургийг үе шаттай бий болгоно.	Геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийж, гэмтсэн болон устсан цэгүүдийн судалгааг гаргаж, нөхөн сэргээх, шинээр байгуулсан цэг тэмдэгтийг хүлээн авах	2021-2024	ГХБХ БГ	Сумдын ЗДТГ	-	-	116 цэг	Жил бүр 2 цэг нэмэгдүүлнэ.	-	-	Геодезийн цэг, тэмдэгтийн үзлэг тооллогыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна. 2021 онд аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдэгтийн тооллогоор Тулгуур сүлжээн 1, Үндсэн 4, Дэд 11, Гравиметр 1, Триангуляци 6, Хадны марк 2, хөрсний репер 3, GPS 81, өндрийн 7 гэсэн 116 цэг тэмдэгтийн судалгааг гаргасан. 2022 онд Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Үйлдвэр технологийн паркийн" байр зүйн зураглалын ажлын хүрээнд "Тэгш хэм" ХХК-аар 33 геодезийн цэгийг шинээр суулгаж улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. 2023 оны геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллогын ажлыг	100%

												зохион байгуулж Зэст багийн нутаг дэвсгэрт ПП7209 дугаартай 1, Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт-РП001дугаартай 1 цэг бүтээн байгуулалтын улмаас устсан байх тул нөхөн сэргээх талаар тухайн цэг тэмдэгтийг устгасан аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэл хүргүүлсэн. Мөн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр "Дроникс" ХХК шинээр 16 геодезийн цэг нэмж байгуулах ажлыг хүлээн аваад байна. Аймгийн хэмжээнд улсын нэгдсэн систем болох геопортал цахим системд геодезийн 163 цэг, тэмдэгт бүртгэлтэй байна.	
152		Шинэ болон хуучин суурьшлын бүсэд бага, том масштабтай байр зүйн зурагт тодруулга хийх	2021-2024	ГХБХ БГ	Сумд ын ЗДТГ ХББЗ А	Орон нутгийн төсөв	-	-	5 га	Батлагдсан төсвийн хүрээнд	-	"Гэр хорооллын газрын дахин төлөвлөн барилгажуулах" ажлын хүрээнд Их залуу багийн нутаг дэвсгэрт 40.8га, Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт 11.9 га газар, Хүрэнбулаг багийн нутаг дэвсгэр Уурхайчин-1 хотхоны баруун талд баригдах амины болон цөөн давхар барилгын орон сууцны хотхон хорооллын 10 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд тус тус байр зүйн дэвсгэр зураг хийгдсэн.	90%
153	5.1.5.Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ.	Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, газрын үнэлгээ, төлбөр, татварын системийг цахим системд хамруулах	2021-2024	ГХБХ БГ Сумд ын ЗДТГ	Татварын хэлтэс	-	-	12800 Нэгж талбар	22800	-	-	Газрын кадастрын программ хангамжид бүртгэгдсэн Баян-Өндөр сумын 5623 нэгж талбарт 27315.0 сая төгрөгийн ногдуулалт хийж 6832 нэхэмжлэх, Жаргалант сумын 1095 нэгж талбарт 111.0 сая төгрөгийн ногдуулалт хийж 1156 нэхэмжлэхийг тус тус үүсгэн татварын нэгдсэн системд илгээгээд байна. Газрын үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулах ажлын хүрээнд 2023 онд 15437 нэгж талбарт газрын татварын бодолтыг хийж, Баян-Өндөр суманд 15166 иргэнд 29.57 сая төгрөг, Жаргалант суманд 271 иргэнд 82.0 мянган төгрөгийн ногдуулалт хийж нэхэмжлэх үүсгэлээ. Нийт газар өмчлөх, эзэмших ашиглах эрхтэй 22155 нэгж талбарт газрын төлбөр, татварын ногдуулалтыг хийж татварын системд илгээсэн.	97.1%
154		Газрын биржийн үнийн судалгааг жил бүр гаргаж цахим системд хамруулах	2021-2024	ГХБХ БГ	Сумд ын ЗДТГ	-	-	2300	4000	-	-	Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь Газрын биржийн www.mle.mn цахим системээс гэр бүлийн хэрэгцээ, худалдаа үйлчилгээ, ХАА-н үйлдвэрлэл, ХАА-аас бусад үйлдвэрлэлийн гэсэн газар ашиглалтын 4 зориулалтаар бүртгэгдсэн үнийн мэдээний тоо, дундаж үнэ, хамгийн бага үнэ, их үнэ, үнийн мэдээний эзлэх хувь, төрөл, эх сурвалж, эрхийн төрлийн тоон мэдээллүүдийг авах боломжтой. Мөн Улсын хэмжээнд газрын дуудлага худалдаа, төсөл сонгон	100%

												шалгаруулалтын талаар мэдээ мэдээлэл авч, дуудлага худалдаанд оролцох бүрэн боломжтой юм. 2023 онд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ шилжүүлсэн 721 нэгж талбар, нийт өссөн дүнгээр 4607 нэгж талбарын үнийн мэдээг газрын биржийн www.mle.mn цахим системд бүртгээд байна. Газрын биржийн цахим системийг олон нийтийн цахим сүлжээгээр болон гарын авлага бэлтгэн иргэдэд сурталчлан ажиллаж байна.	
155	5.1.6.Гэр хорооллын багуудад “Миний гудамж-Бидний гэр”, орон сууцны хорооллын багуудад “Миний орц-Бидний байшин” төслүүдийг хэрэгжүүлж зам талбай, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, камержуулалтыг үе шаттайгаар үргэлжлүүлэн шийдвэрлэнэ.	“Хашаандаа хаус” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын багуудад “Миний гудамж-Бидний гэр” төслийн хүрээнд төвлөрсөн шугам барих, ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ Х3А	ХББЗ А ГХБХ БГ	Орон нутгийн төсөв	8.600.0	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 431	Холбогдох нөхцөл бүрдсэн өрхийн тоо 120	3.00.0	Орон нутгийн төсөв 183.0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2.9 тэрбум төгрөгөөр гэр хорооллын дараах 7 багт инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Үүнд: Булаг багт дулаан хэрэглээний халуун хүйтэн усны 0.94 км, цэвэр усны 0.94 км, бохирын 0.5 км, Рашаант багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.63 км, цэвэр усны 1.63 км, Наран багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 1.14 км, цэвэр усны 1.1 км, бохирын 0.52 км, Цагаанчулуут багт бохир усны 0.76 км, Баянцагаан багт дулаан, хэрэглээний халуун, хүйтэн усны 0.98 км, Дэнж багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 0.88 км, цэвэр усны 0.88 км, бохир усны 0.26 км, Говил багт дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны 2.22 км, нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдлээ. Төслийн үр дүнд 1245 өрх төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдэж, 253 айл өрх бүрэн холбогдсон.	100%
156		Орон сууцны хорооллын багуудад “Миний орц-Бидний байшин” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ Х3А	ГХБХ БГ СӨХ	Орон нутгийн төсөв	147.9	-	Аюулгүй, тохилог орчин бүрдэнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 379.5	"Миний орц-Бидний байшин" төслийн хүрээнд 2022 онд "Зарим багуудын тохижилт" төсөл арга хэмжээний хүрээнд Оюут баг 2-3-р байранд 3 орц, 2023 онд 379.5 сая төгрөг батлуулан 14 орцны засварын хийж гүйцэтгэсэн. Үүнд: Дэнж багийн 3 байрны 6 орцны засварын ажлыг Алист констракшн ХХК, Баянцагаан багийн Вокзалын 3, 4 дүгээр байрны 8 орцны засварын ажлыг Өвөлжөөн булаг ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад өгсөн.	70%
157		Орон сууц болон гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ Х3А	“ЭУДТ С” ОНӨХ К	Орон нутгийн төсөв	1.550.0	9700 ш гэрэлтүүлэг	Жилд 200 ш гэрэлтүүлэг	200.0	Орон нутгийн төсөв 1700.0	2022 онд орон нутгийн 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 279 гэрэлтүүлэг шинээр хийгдэж, 1482 ширхэг гэрэлтүүлгийн толгойг шинэчлэх, 1480 ширхэг гэрэлтүүлгийн тэжээлийн блок солих, 0.4кв-ын 70874 метр СИП кабель шинээр татах ажлыг гүйцэтгэсэн. 2023 онд орон нутгийн төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө	100%

												оруулалтаар 14 байршилд 568 ш гэрэлтүүлэг шинээр хийж ашиглалтад оруулаад байна.	
158		Хотын камержуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ХТГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	2.000.0	30%	Нийт талбайн 45%	200.0	Орон нутгийн төсөв 1513.0	Аймгийн хэмжээнд бүх багийг бүрэн камержуулах, тоног төхөөрөмжөөр хангах засвар үйлчилгээг найдвартай хангах үүднээс жил бүр орон нутгийн төсөвт техник тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийг тусган камержуулах ажлыг хийж ирсэн. Камержуулалтын хөрөнгө оруулалтыг жил бүрээр нь авч үзвэл: 2021 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 397.0 сая төгрөгийн үнэ бүхий 104 ширхэг камер, 2022 онд 2 тэрбум 300.0 сая төгрөгийн үнэ бүхий 412 ширхэг камер, 87 сая төгрөгийн үнэ бүхий камерын засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай тусгай зориулалтын автовишка худалдан авч ашиглаж байна. 2023 онд орон нутгийн төсвийн 729.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 133 ширхэг камерыг шинээр суурилуулахаар гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажилласнаар Уурхайчин багт 17, Цагаанчулуут багт 12, Эрдэнэ багт 36, Булаг багт 35, Хүрэнбулаг багт 26, Зэст багт 7 ширхэг камерыг тус тус суурилуулан ашиглалтад бүрэн орууллаа. Одоогийн байдлаар 25 багт нийт 649 камер бүртгэлтэй байгаагаас 543 нь бүрэн ажиллагаатай, 106 нь засвартай байна. Нийт камеруудын 530 ширхэг нь нэг чиглэлийн, 107 ширхэг нь PTZ хөдөлгөөнт, 2 ширхэг нь хэт ягаан туяаны, нь 10 ширхэг ANPR дугаар таних зориулалттай тус тус ажиллаж байгаа нь хотын нийт газар нутгийн 48 хувь нь хамрагдаж байна. 2023 онд Камерын хяналтын нэгдсэн төвд 577 иргэн, 40 албан хаагчийн хүсэлтээр 617 удаагийн камерын бичлэг шүүж иргэд, аж ахуйн нэгжид учирсан 352.1 сая төгрөгийн хохирлоос 238.7 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон хохирлыг барагдуулж ажилласан байна.	90%
159	5.1.7.Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ.	Нарны эрчим хүчээр халдаг халаалтын систем нэвтрүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх	2021-2024	Төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоо	ХЗА Сумдын ЗДТГ	Төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	Батлагдсан төсвийн хүрээнд	Олон улсын байгууллага 65.0	2023 оны 3 дугаар сард Шанд багийн 17-р сургуулийн уурын зууханд гэмтэл гарсны дагуу "ЭДЦС" ТӨХК-ийн инженер, эрчим хүчний улсын байцаагчийн хамтаар газар дээр нь үзлэг шалгалтыг хийж дүгнэлт гаргасан. 2023 оны 7дугаар сард Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн хурлаар 656.9 сая төгрөг батлагдаж одоо байгаа уурын зуухыг буулгаж шинээр бүрэн автоматжуулагдсан тохируулга бүхий хяналт удирдлагын системтэй хийн түлшний усан	30%

												халаалтын зуух суурилуулахаар худалдан авах ажиллагаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй тул дахин зарлахаар бэлтгээд байна. Шинээр угсрах хийн түлшний усан халаалтын зуух нь 1400 квт-ын хүчин чадалтай халаалтын зууханд 17 дугаар сургуулийн 2 байр, Шанд, Даваат багийн байр, соёлын төвийн барилгуудыг дулаанаар хангана. Алслагдсан багуудын төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, айл өрхүүдийг бие даасан дулааны эх үүсвэрээр хангахаар НҮБ-ийн Хүүхдийн сан, ШУТИС-тай хамтран Яргуйт багт газрын гүний дулаан, нарны эрчим хүч /панел/ ашиглан багийн байр болон 28 дугаар цэцэрлэгийг халаах ТЭЗҮ-боловсруулсан. Үүний хүрээнд геологийн судалгааны ажил хийгдэж, ажлын нийт төсөв 1.8 тэрбум төгрөгийн тооцоо гарснаас НҮБ-ын Хүүхдийн сангаас төслийн 40 хувийг санхүүжүүлэх саналыг тавьсан.	
160	5.2.“Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2040”-г шинэчлэн боловсруулж батлуулна.	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, зургийн даалгаварт санал өгөх орон нутгийн ажлын хэсгийг байгуулах	2021-2024	ХБТХ ОХ	ГХБХ БГ ХББЗ А	Улсын төсөв	-	-	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруул агдан батлагдсан байна.	Улсын төсөв	-	"Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар"-ыг боловсруулах ажилд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас саналыг авч тусгуулан 2021 онд 2021/68 дугаартай ажлын даалгавар батлагдсан. 2023 онд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгийг улсын төсөвт тусгагдаагүй хасагдсан тул "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний ТЭЗҮ-ийг хийх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг ЗГХЭГ, ЭЗХЯ, БХБЯ-нд удаа дараа хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байсан. Иймд 2024 оны улсын төсөвт тусгуулахаар санал, хүсэлтийг дахин хүргүүлэн уулзалт хийж, БХБЯ-аас ЭЗХЯ-нд дэмжсэн албан бичгийг хүргүүлснээр ЭЗХ-ийн сайдад хүргүүлсэн.	0%
161		Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үе шаттай сурталчлах ажлыг зохион байгуулах	2021-2024	ГХБХ БГ ХББЗ А	ХБТХ ОХ ХЗА	Орон нутгийн төсөв	15.0	-	Иргэд хотын ерөнхий төлөвлөгөө ний талаар мэдээлэлтэ й болно.	5.0	-	Баян-Өндөр болон Жаргалант суманд зохион байгуулсан "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгөөр Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Жаргалант сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг зурагт самбар, альбом хэлбэрээр сурталчилж. 840 гаруй иргэнд мэдээлсэн. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг /https://erdenet.gazar.gov.mn/ цахим хуудаст байршуулж иргэдэд мэдээлснээр тайлангийн хугацаанд давхацсан тоогоор нийт 7520 иргэн мэдээлэл авсан байна.	100%

162	5.3.Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцны хорооллуудыг барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	ГХБХ БГ ХББЗ А	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	-	Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцанд амьдардаг өрхийн тоо 13180 айл	Шинээр 150 айл	-	Эрдэнэт үйлдвэр, Орон нутгийн төсөв 27400.0	Аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Уртын гол багт 5 блок бүхий 260 айлын орон сууцны барилгын ажил хийгдэж байна. 5 блок барилгын А блок 70 хувь, D блок 80 хувь, Е блок 12 хувийн гүйцэтгэлтэй, В, С блок ажил бүрэн дуусч ашиглалтад хүлээлгэн өгснөөр тус төсөл 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоогийн байдлаар ашиглалтанд орсон 2 блок барилгад нийт 70 айл орсон. Төслийн хүрээнд Ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөөний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 400 айлын "Уурхайчин-3" амины орон сууцны хорооллын барилга угсралтын ажил 55 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Мөн хувийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 1178 айлын 14 төсөл Оюут, Цагаанчулуут, Найрамдал, Зэст багуудад тус тус баригдаж байгаагаас одоогийн байдлаар 836 айлын орон сууц ашиглалтад орсон.	100%
163		Орон сууцны хорооллуудын ИШС-г үе шаттайгаар шинэчлэх	2021-2024	ХББЗ А ХЗА	“ЭУДТ С” ОНӨХ К	Улсын болон орон нутгийн төсөв	1.000.0	123.7км	30%	300.0	Улсын төсөв 910.0 Орон нутгийн төсөв 1326.9	2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хотын нийт орон сууцнууд болон ААНБ-ыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барихаар улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажлын гүйцэтгэл 65%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2023 онд Баянцагаан багт цагаан байрны айл өрхүүдийн шугам сүлжээг шинэчлэх ажилд 30.0 сая төгрөг, Говил баг Эрх бүжинхэн цэцэрлэгийн дотор халаах хэрэгслийг шинэчлэх ажилд 79.9 сая төгрөг, 186-р ангийн гадна ИШС-г шинэчлэх ажилд 253.0 сая төгрөг, нийт 442.9 сая төгрөг батлагдаад байна. Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Бүрэнбүст багийн цэвэр усны шугамын ажилд 691.1 сая төгрөг, Уурхайчин багийн цэвэр усны шугамын ажилд 833.5 сая төгрөг, Хүрэнбулаг багийн УДДТ №4-2-ын гадна 5 хос 1 км шугам шинэчлэх ажилд 1.0 тэрбум төгрөг тус тус батлагдсан ба одоогоор тендер сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна. Мөн аваарын байдалтай байсан ДГТ-3-р байрны подвалын ИШС-г шинэчлэх ажилд 79.9 сая төгрөг, Уурхайчин багт хот дахин төлөвлөлтийн барилгажуулах төслийн цэвэр усны шугам	70%

												шилжүүлэх ажилд 243.6 сая төгрөг, Уртын гол багт баригдсан 260 айлын орон сууцны УДДТ-д нэмэлт тоноглол суурилуулах ажилд 36.7 сая төгрөг, Эко хорооллын гадна шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажилд 543.8 сая төгрөг нийт 904.0 сая төгрөгийг болзошгүй аваарын зардлаас шийдвэрлэн хийж гүйцэтгэлээ.	
5.4.Гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна.													
164	5.4.1.Хотын бүх айл өрхийг цахилгааны 2 тарифт тоолуурт шилжүүлэн иргэдэд цахилгааны хөнгөлөлт үзүүлэх	Гэр хорооллын айл өрхүүдэд 2 тарифт тоолуур нэвтрүүлэх	2021-2023	ХЗА	БОАЖ Г Баян-Өндөр сумын ЗДТГ “ЭУДТ С” ОНӨХ К	Орон нутгийн төсөв	196.0	Гэр хорооллын айл өрх	500 өрх	65.0	Дэлхийн банкны санхүүжилт 5100.0	Дэлхийн банкны 1.5 сая долларын санхүүжилтээр 2021 оноос он дамжин хийгдэж байгаа Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэмжээнд айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх нийт ажил 71.5 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Энэ ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхөд 14484ш тоолуур суурилуулахаас 8002ш тоолуур суурилуулаад байна.	55.2%
165		Эрдэнэт хотын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хоёр тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх	2021-2022	“ЭБЦТ С” ТӨХК	ХЗА “ЭУДТ С” ОНӨХ К	Гадаадын зээл, Улсын төсөв	1.548.620 ам.доллар	2 тарифт тоолуур-24000 ш	-	-	Дэлхийн банкны санхүүжилт 5100.0	Дэлхийн банкны 1.5 сая долларын санхүүжилтээр 2021 оноос он дамжин хийгдэж байгаа Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэмжээнд айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх нийт ажил 71.5 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Энэ ажлын хүрээнд орон сууцны хороололд 6028ш тоолуур суурилуулахаас 5688ш тоолуур, гэр хорооллын айл өрхөд 14484ш тоолуур суурилуулахаас 8002ш тоолуур, аж ахуйн нэгж байгууллагуудад 877 тоолуур суурилуулахаас 294 тоолуур суурилуулаад байна.	65.4%
166	5.5.Гэр хорооллын багуудын дахин төлөвлөлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, багийн төвүүд болон айл өрхийг төвлөрсөн шугам (халаалт, цэвэр бохир)-д холбож барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Дахин төлөвлөх үйл ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулж, төлөвлөлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээн авах	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ГХБХ БГ ХББЗ А	-	-	-	Төсөл хэрэгжилт	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Аймгийн хэмжээнд Цагаанчулуут багт 11.9 га, Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийг хийж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор батлуулсан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхлүүлснээр хэрэгжилт 30 хувьтай, Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл хийгдэж байна. Дахин төлөвлөх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлын хүрээнд Эрдэнэ багт 2.5 га талбайд дахин төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулалт зарласан. Оюут багийн Сархиа уулын энгэрт 4 га	70%

											талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна. Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багт Уурхайчин-1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10га талбайд хийлгэж байгаа ба зураг төсөл боловсруулах ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.		
167		Гэр хорооллын багийн төвүүд болон айл өрхийг төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХЗА	ГХБХ БГ ХББЗ А	Улсын төсөв	12000.0	-	3.1 км	Улсын төсөв	Улсын төсөв 1200.0	Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн УДХТ хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлын нийт төсөвт өртөг 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Тус ажлын хүрээнд Ф273мм диаметртэй 1.7 км урттай дулааны хос ган яндан хоолой, Ф200мм диаметртэй цэвэр усны шугам цайрдсан ган яндан угсралт хийгдэнэ. Мөн Их залуу багт төв дулаан, цэвэр усны шугам, ус дулаан дамжуулах төвийн барилга, 1.7 км 3 хос гадна инженерийн шугам сүлжээний ажлын нийт төсөвт өртөг 1.37 тэрбум төгрөгийн дүнтэй ажил 98%-ийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна. Дээрх 2 ажил хийгдсэнээр Цагаанчулуут, Наран, Их залуу багийн айл өрхийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээний холбогдох нөхцөл бүрдэнэ. Хотын нийтийн орон сууцнууд болон аж ахуйн нэгж, байгууллагыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барих 4.3 тэрбум төгрөгийн төсөвтэй ажил 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	90%
168		Баян-Өндөр сумын гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургын сүлжээг байгуулах	2021-2024	ХБТХ ОХ ХЗА БОАЖ Г ЭМГ	“ЭУДТ С” ОНӨХ К Сумд ын ЗДТГ	Улс болон орон нутгийн төсөв	3.458.8	0 өрх	30 өрх	Иргэн айл өрхийн зардлаар	Улсын төсөв 4100.0	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ариутгах татуургын 3-р коллекторын төв шугамын ажлыг Комфорт Импекс ХХК гүйцэтгэн 2022 онд 10.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2023 онд 4.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр бадлагдан хэрэгжиж Ф200-Ф600мм-ийн гол шугам 3.6км, салбар шугам 2.55км, 1500мм-ийн 73ш худаг шугамын угсралт, дулаалга, нягтруулалт зэрэг үе шатны ажлууд хийгдэж нийт ажлын гүйцэтгэл 65 хувьтай явагдаж байна.	90%
169	5.6.Хотын инженерийн шугам сүлжээний дэд бүтцэд гамшгийн эрсдэлийн	35/6кВ-ын ЦРП-Өмнөд дэд станцыг 2х10000кВА-иар өргөтгөж цахилгааны	2021-2024	“ЭБЦТ С” ТӨХК	ХЗА	Улсын төсөв	3.200.0	-	-	-	Орон нутгийн төсөв 2535.0	2022 онд орон нутгийн 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 35/6кВ-ын ЦРП-Өмнөд дэд станцыг 2х10000кВА-иар өргөтгөх ажлыг "Орхон тек" ХХК хийж дууссан. 2023 онд хуучин Өмнөдийн дэд станцын хэрэглэгчийг шинэ станцад холбох ажил бүрэн хийгдэж ачаалал авч ажиллаж байна.	100%

	үнэлгээг үе шаттайгаар хийж, гэмтэл доголдол аваарыг бууруулах, инженерийн дэд бүтцийг сайжруулах бодлогыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлнэ.	найдвартай ажиллагааг хангах											
170	үнэлгээг үе шаттайгаар хийж, гэмтэл доголдол аваарыг бууруулах, инженерийн дэд бүтцийг сайжруулах бодлогыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлнэ.	Хотын гэр хорооллын цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Эрдэнэ багийн хабитатын хэсэгт 35кВ-ын ЦДАШ, 35/6 кВ-ын дэд станц шинээр барих	2022-2024	“ЭБЦТ С” ТӨХК	ХЗА	Улсын төсөв	900.0	-	-	-	Орон нутгийн төсөв 251.2	2023 онд Орхон аймгийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор Эрдэнэ багт 35кВ-ын ЦДАШ-ыг барих ажлыг ЭБЦТС ТӨХК өөрийн хөрөнгө оруулалтаар ажил 60 хувийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна. Эрдэнэ багт 35/6 кВ-ын дэд станц шилжүүлэн барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарлагдаад байна.	50%
171		Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд дулааны шугам сүлжээнд горимын тооцоог тогтмол хийх	2021-2024	“ЭДЦ С” ТӨХК “ЭУДТ С” ОНӨХ К	ХЗА	“ЭДЦС” ТӨХК “ЭУДТС ” ОНӨХК	Байгууллагын дотоод зохион байгуулалтаар	-	100%	-	Орон нутгийн төсөв 95.0	2021 оны орон нутгийн 95.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хотын хэмжээнд байгаа дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийх зөвлөхөөр ШУТИС-ын судалгааны баг шалгарч ажлыг гүйцэтгэн горим тооцоог боловсруулан хүлээлгэн өгсөн. Мөн хангагч байгууллага "ЭДЦС"ТӨХК, "ЭУДТС"ОНӨХК хотын шугам сүлжээнд жил бүр үзлэг шалгалт, горим тохируулга хийж, тухай бүр хэрэглэгчдийн ачааллын тооцоог хийж ажиллаж байна.	100%
172		Хотын шугам сүлжээнд эрсдэлийн үнэлгээг хийж цаашид авах шаардлагатай ажлын төлөвлөгөөг гаргах	2021-2024	“ЭДЦ С” ТӨХК, “ЭУДТ С” ОНӨХ К	ОБГ	“ЭДЦС” ТӨХК, “ЭУДТС ” ОНӨХК	Байгууллагын дотоод зохион байгуулалтаар	-	40%	-	-	-	2021 онд орон нутгийн төсвөөс 95.0 сая төгрөг зарцуулан ШУТИС-ийн судалгааны багаар хотын хэмжээний дулааны шугам сүлжээнд горимын тооцоог хийлгэснээр эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагагүй болж хотын дулааны шугамын насжилт, өргөтгөл шинэчлэлт хийх шаардлагатай шугам сүлжээнүүдийн тооцоо судалгааг гаргасан. Уг судалгааны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хотын нийтийн орон сууцнууд болон ААНБ-ыг төвлөрсөн дулаан хангамжаар хангадаг 3.5 км төв дулааны шугамыг ф720 мм-ын шугамаар өргөтгөн барихаар 2022 онд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн дүнтэй ажлыг "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэж, ажил 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Мөн Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн ус, дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг шинэчилж сувагт хийх ажлыг 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр "Эрин гүрэн" ХХК гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар Цагаанчулуут, Наран багт УДДТ барих ажил бүрэн хийгдэж дууссан, тоноглол угсрах, хоолойн бэлдэц бэлтгэх ажил хийгдэж, ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж

												байна. Хотын хэмжээний инженерийн шугам сүлжээнд цаашид авах шаардлагатай ажлын төлөвлөгөөг хангагч байгууллага "ЭДЦС"ОНӨХК, "ЭУДТС"ОНӨХК тухай бүр гарган улсын төсөв, орон нутгийн төсөв, болзошгүй аваарын зардал болон өөрсдийн байгууллагын нөөц бололцоогоор шийдвэрлэн ажиллаж байна.	
5.7.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг салбар бүрд нэвтрүүлнэ.													
173	5.7.1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг салбар бүрд нэвтрүүлнэ.	“Ухаалаг-Эрдэнэт” төсөл хэрэгжүүлэх	2021-2022	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв	10.000.0	Шинээр эхлэх төсөл	-	-	Орон нутгийн төсөв 1500.0	Цахим, ухаалаг хот хөгжүүлэх "Цахим Эрдэнэт - 1" хөтөлбөрийг Тогтвортой хот ба олон нийтийн хамтын үйл ажиллагаа - Ухаалаг хотын үзүүлэлтүүд ISO 37122:2019 стандартын шаардлагууд, үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд, хууль эрх зүйн орчинд үндэслэн 5 зорилт, 17 арга хэмжээтэйгээр боловсруулан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 20 дугаар тогтоолоор баталсан. Мөн иргэдийн бизнес эрхлэх, нутгийн удирдлагатай харилцах харилцааг хялбар, шуурхай байх Цахим Эрдэнэт платформ, түүний статистикийн систем, газар зүйн мэдээллийн системийг ашиглалтад оруулсан. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, сумдад E-Mongolia төвийг байгуулан үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэн ашиглагдах тоног төхөөрөмж, интернэтийн эх үүсвэрээр ханган иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвшээд байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд 24 цагийн үйлчилгээ бүхий "Цахим төв"-ийг нээн ажиллуулж байна. Уг төвд 2 ширхэг E-mongolia-аас лавлагаа авах киоск машин, ТҮЦ машин, улсын бүртгэлийн лавлагаа мэдээллийн киоск машин, төлбөр тооцооны gegege-ийн киоск машин, ХААН болон Төрийн банкны АТМ машин тус бүр 1 ширхэгийг байрлуулан ажиллуулж байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх Мастер төлөвлөгөөг батлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж одоогийн байдлаар 10 арга хэмжээ буюу 58.9% нь бүрэн хэрэгжиж дууссан, бусад ажлууд үргэлжлэн хийгдэж байна.	90%
174		“Цахим Эрдэнэт” хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, шинэ суурьшлын бүс захын хорооллын	2021-2023	ХБТХ ОХ	“МЦХ” ХК “МХС” ХХК	Төрийн болон, Хувийн хэвшлийн	60.0	Суурьшлын бүс захын хорооллын айл өрх,	Суурьшлын бүс захын хорооллын айл өрх, иргэдэд	20.0	-	"Юнивишн" ХХК-аас Баян-Өндөр сумын Баянцагаан, Уртын гол, Баянбулаг, Даваат, Дэнж багт гурвалсан үйлчилгээний сүлжээг шинээр ашиглалтад оруулаад байна. Тус сүлжээнд нийт 158 айл өрхийг холбож интернетийн үйлчилгээг	97.4%

[illegible]

176	5.9.1.Дэлхийн банкны төслөөр хэрэгжих Эрдэнэт хотын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хоёр тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх, гэр хорооллын багуудын гудамж хоорондын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих, цахилгааны шугамыг өргөтгөн шинэчилнэ.	Эрдэнэт хотын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хоёр тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх, гэр хорооллын багуудын гудамж хоорондын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих	2021-2022	“ЭБЦТ С” ТӨХК	ХЗА “ЭУДТ С” ОНӨХ К	Гадаад ын зээл, Улсын төсөв	17.500.0	0.4кВ-ын ЦДАШ-266.4км 2 тарифт тоолуур-24000ш Дэд станц -9 ш	-	-	Дэлхийн банкны санхүүжилт 12790.0	Орхон аймагт 2021 оноос Дэлхийн банкны 6.98 сая долларын /19.5тэрбум төгрөг/ санхүүжилтээр он дамжин хийгдэж байгаа Баян-Өндөр сумын гэр хорооллын 16 багийн гудамж хоорондын 0.4кВ-ын цахилгааны модон тулгууруудыг төмөр бетонон шонгоор солих ажлыг "Ричвелл инженеринг" ХХК гүйцэтгэж байна. Одоогоор 0.4кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын гүйцэтгэл 92.14%, хуучин орон сууцны цахилгаан хангамж 85.92%, гэр хорооллын тоолууржуулалт 55.2%, орон сууцны хорооллын тоолууржуулалт 94.3%, 6кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын гүйцэтгэл 39.8%-ийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж байна.	70%
177	5.9.2.БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр барьж байгаа “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийг МВт-ын хүчин чадалтай турбогенератора ар өргөтгөх төслийн ажлыг бүрэн гүйцэтгэнэ.	“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн турбогенераторыг СС-50 мВт-иар өргөтгөх ажлыг дуусгах	2021-2022	“ЭДЦ С” ТӨХК ХЗА	ЭХЯ	Гадаад ын зээл тусламж аар	51.8 сая ам. доллар	36мВт	-	-	-	БНХАУ-ын Засгийн газрын 51.8 сая долларын хөнгөлөлттэй зээлээр энэ төслийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын тогтоол гарч, "Human Industrial Equipment Installation" компани тендерт шалгарч Эрчим хүчний яамтай гүйцэтгэлийн гэрээ байгуулсан. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн өргөтгөлийн ажил 2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс Турбинд эргэлт өгч нэгдсэн сүлжээнд залган ажиллаж эхэлсэн. Ингэснээр "ЭДЦС" ТӨХК нь 7 зуух, 4 машинтай суурилагдсан хүчин чадал 71мВт болсон. Хэвийн үйл ажиллагаатай явж байна.	100%
178	5.9.3.Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр барьж байгаа 2А, 7А, 7, 11-р хорооллуудыг дулааны эх үүсвэрээр хангах “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц”	9-р цэг хүртэл Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих	2021-2023	“ЭДЦ С” ТӨХК	Эрчим хүчний яам	Улсын төсөв	3.692.0	-	-	2.692.0	Улсын төсөв 910.0	2022 онд Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭДЦС ТӨХК-иас 9 дүгээр цэг хүртэлх Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих ажлын гүйцэтгэгчээр “Эрин гүрэн” ХХК шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар тус ажил 65 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	70%

	ТӨХК-иас 9-р цэг хүртэл Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барина.												
179	5.9.4.Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжих “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийг хэрэгжүүлнэ.	“Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн хүрээнд үерийн сувгийг үе шаттай барих	2021-2023	Төслийн нэгж	БХБЯ ЕСБХ Б ХЗА ХТГ	Гадаадын зээл тусламжаар	39.900.0	Одоо байгаа Гэр хорооллын байгалийн гуужалганы нийт 72.8км	-	-	-	2022 онд “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн зөвлөх үйлчилгээний компани Дани улсын “СВЕКО Дэнмарк” ХК шалгарсан бөгөөд Монгол улсын талаас “Мон консалт” ХХК ажлын зураг төслийг боловсруулж батлуулсан. Одоо гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлах бэлтгэл хийгдэж байна. Нийт 14 сая долларын хөрөнгө оруулалтаас 10.65 сая доллар үерийн хамгаалалтын далан, 3.35 сая доллар хотын инженерийн шугам сүлжээний ажилд зарцуулахаар төлөвлөөд байна. 2023 онд инженерийн шугам сүлжээний ажлын тендер зарлагдсан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна.	30%
	ТЭЭВЭР, АВТО ЗАМ												
180	5.10.1.Ухаалаг системд тулгуурласан хотын доторх нийтийн тээврийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангасан, өрсөлдөх чадвар бүхий аюулгүй, ая тухтай, зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлнэ.	Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээнд төлбөрийн цахим карт нэвтрүүлэх	2021-2022	ХБТХ ОХ	АТТ	Хувийн хэвшилтэй хамтарч төсөл арга хэмжээний хүрээнд	500.0	0%	-	-	хувийн хэвшлийн 500.0	Аймгийн Засаг дарга “Сим” ХХК-тай нийтийн тээврийн үйлчилгээнд Цахим картын үйлчилгээ буюу E-Pass төслийг хэрэгжүүлэхээр 2021 оноос хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Төсөл хэрэгжих хугацаанд 36 автобусанд карт унших төхөөрөмж, спикер, 20 буудалд зарлан мэдээлэх төхөөрөмж, 21 автобусанд дэлгэц, 36 автобусанд хяналтын болон хүн тоологч нийт 72 ширхэг камер, дэлгэцийг байршуулсан. Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих иргэдэд Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран 6000 ширхэг картыг олгосон бөгөөд 2 байршилд карт худалдан борлуулах, мэдээлэл өгөх түр төвийг байгуулж иргэдэд карт олгох ажлыг зохион байгуулсан. Эрдэнэт ШУТПарк нь Цахим Эрдэнэт-1 хөтөлбөрийн хүрээнд Smart Erdenet аппликейшнд суусан нийтийн тээврийн цэсийг бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	90%
181		Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автобус парк шинэчлэлтэд дэмжлэг үзүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Хувийн хэвшил, олон улсын зээл, тусламж	зээл, тусламж	20 автобус 55.5%	3 автобус парк шинэчлэлт	зээл, тусламж	Орон нутгийн төсөв 1500.0	2021 онд хувийн хэвшлийн байгууллагууд өөрийн хөрөнгө оруулалтаар 4 ширхэг автобус, 2022 онд нийтийн тээврийн парк шинэчлэлтэд зориулж орон нутгийн төсөвт 2.2 тэрбум төгрөгийг зарцуулж “Хьюндай моторс Монгол” ХХК БНСУ-д үйлдвэрлэгдсэн шинэ 12 ширхэг дунд оврын	90%

											автобусыг хүлээлгэн өгч нийтийн тээврийн үйлчилгээнд явуулж байна. 2023 онд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн хэрэгслийг нийтийн тээврийн парк шинэчлэлтэд нэвтрүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс 1.5 тэрбум төгрөгөөр 6 ширхэг дунд оврын автобус худалдан авахаар худалдан авах ажиллагааг 2 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна.		
182		Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай тээврийн хэрэгслийн төрлийг судлан нийтийн тээвэрт нэвтрүүлэх	2021-2022	ХБТХ ОХ	АТТ	Хувийн хэвшилтэй хамтарч төсөл арга хэмжээн ий хүрээнд	Авто замын тээвр ийг хөгжү үлэх хөтөл бөрий н хүрээ нд	5.0	-	-	-	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглагдах ЭКО тээврийн хэрэгслийг судлах ажлын хүрээнд "Монгол машин байгууламж" үйлдвэр, "Цахилгаан тээвэр" компанийн "J-800 EV", Оросын холбооны улсын "ГАЗ" болон "КАМАЗ" "МАЗ"-ийн үйлдвэрийн Электробус зэрэг тээврийн хэрэгслийг судалж ажилласан. Судалгааны үр дүнд EURO 4 стандартын шаардлагад нийцсэн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг нийтийн тээвэрт ашиглах боломжтой гэж үзсэн. Үүний хүрээнд 2022 онд БНСУ-д үйлдвэрлэгдсэн шинэ 12 ширхэг дунд оврын автобус авч нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1.5 тэрбум төгрөгөөр 6 ширхэг дунд оврын автобус худалдан авахаар худалдан авах ажиллагааг 2 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна. Одоогийн байдлаар хот хооронд болон орон нутаг, хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа 458 тээврийн хэрэгслийн 226 буюу 49.3 % нь байгальд ээлтэй /ЭКО/ хийн түлш хэрэглэж байна.	50%
183		Шинээр бий болж буй суурьшлын бүсэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, маршрут нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Төр, хувийн хэвшил хамтарч	Хөрөн гө шаард лагагү й.	100%	Шинээр бий болсон суурьшлын бүсэд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлсн ээр иргэдийн ая тухтай зорчих боломж бүрдсэн байна.	Хөрөнгө шаардла гагүй	-	Аймгийн хэмжээнд шинээр бий болсон суурьшлын бүс болон асфальтбетон хучилттай авто зам ашиглалтад орсонтой холбогдуулан 2021-2022 онд “Төгөл-Вокзал” чиглэлийг шинээр баталж хэрэгжүүлсэн. 2023 онд аймгийн Засаг даргын А/597 тоот захирамжаар "Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол" чиглэлийг шинээр баталж тус чиглэлд стандарт шаардлага хангасан аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй төслийг зарлаад байна. Одоогийн байдлаар 7 чиглэлд 25 дунд оврын автобус нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна.	100%

184	5.10.2.Сурагчдын автобусны буудал болон хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн авто буудал байгуулж, зорчигч тээвэрлэлтийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлнэ.	Хотын доторх чиглэлийн нийтийн зорчигч тээвэр, сурагчдын автобусны үйлчилгээнд шаардагдах зогсоол, сүүдрэвч барих	2021-2024	ХБТХ ОХ	АТТ	Орон нутгийн төсөв	460.0	75 сүүдрэвч 80%	10 сүүдрэвч 25% /жил бүр/	115.0	Орон нутгийн төсөв 129.7	Аймгийн хэмжээнд нийт 144 автобусны буудал байгаагаас 32 хувь нь сүүдрэвчтэй, иж бүрэн, 10 хувь нь зогсоолын байгууламжтай, 58 хувийг нь шинэчлэн засварлах шаардлагатай байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Наран багт 2 ширхэг, Баянцагаан багийн Өнөр хотхонд 1 ширхэг автобусны буудлыг барьж ашиглалтад бүрэн оруулсан.	30%
185		Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний төвлөрсөн “Орхон” авто буудлыг барьж, иргэдийг ая тухай зорчих нөхцөлөөр хангах	2021-2022	Аймгийн ЗДТГ	АТҮТ	Улсын болон орон нутгийн төсөв	-	Аймгийн хэмжээнд авто буудал байхгүй.	-	-	Улсын төсөв 3900.0	2023 онд улсын төсвийн 3.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шинжүү ХХК нь орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн "Авто буудал"-ын барилгын ажлыг эхлүүлсэн. Одоогийн байдлаар барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэйгээр 2024 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	90%
186	5.10.3.Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замын сүлжээ болон уулзваруудыг өргөтгөж, авто зам ашиглалтын үйлчилгээг сайжруулна.	Хотын доторх хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг эхлүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	436.5	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 92 км хатуу хучилттай авто зам ашиглагдаж байна.	300 м хатуу хучилттай авто зам барьсан байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 5604.6	Хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх, өргөтгөл шинэчлэлтийн ажлын хүрээнд: 2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7.2 км авто зам, 2022 онд 2.1 км авто замыг бүрэн ашиглалтад оруулсан байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Яргуйт багийн авто замыг А1002 авто замтай холбох 299м, 5-17 дугаар байрны авто зогсоолыг 5-18 дугаар байрны авто зогсоолтой хүзүүвч хийх 35.5м, Эко хорооллыг 7-р хорооллын авто замтай холбох 20м, 7-р хорооллын дотор замтай холбох үлдэгдэл замыг хийх орц, гарц 95.6м, Рашаант баг 15, 16, 17, 19, 20-р гудамжинд орц гарц хийх 50м, Их залуу баг, 15-р сургуулийн авто зогсоолоос 23-р цэцэрлэгийн хажуугийн авто замтай холбох 131.4м ажил, Оюут баг, "Ачит" худалдааны төвөөс 2-40А байрны урдуур А1001 замтай холбох 547м авто зам, Захиргааны 4 дүгээр байрны /0.395 км/ уулзварын өргөтгөлийн ажил, Баянбулаг, Булаг багийн нутаг дэвсгэрт ус түгээх 2-р цэг хүртэлх 700м хатуу хучилттай гэрэлтүүлэг, явган хүний зам бүхий иж бүрэн нийт 1.9 км авто замыг дуусгаж ашиглалтад орууллаа. Танил зах орчмын авто замын сүлжээг холбох хатуу хучилттай 2.29 км замын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	100%

											2023 онд Баянцагаан багт 1680 м, Говил багт 475м, Дэнж багт 1000 м, Эрдэнэ багт 1690 м, Даваат баг Ундаргын 3-8-р гудамжинд 1560 м, Яргуйт багт 2710м, Наран багт 2410 м, Рашаант багт 2690 м, Булаг баг 350м, Их залуу багт 9955м, ББ парк хотхоныг асфальтан замаар төв замтай холбоход 550м, Шанд багт 2660 м, Цагаанчулуут багт сайжруулсан шороон зам засварлах 1250 м, Хөшөөт, Айргийн хөндий, Арцат, Согоотын давааны зам засварлах 1.1 км нийт 30 км сайжруулсан шороон замыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн Даваат багийн Зураа хэсэгт 1, Шанд багийн 20 дугаар гудамжны баруун үзүүр, 35, 36 дугаар гудамжны дунд 1ш, Эрдэнэ багийн 2, 25 дугаар гудамжны үзүүрт 1 ширхэг нийт 3 ширхэг авто машины гүүрэн гарцыг ашиглалтад оруулсан.		
187		Хотын доторх авто зогсоолыг нэмэгдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	840.0	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 69650 м.кв авто зогсоол ашиглагд аж байна.	5-6 авто зогсоолыг ашиглалтад оруулсан байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 660.0	2021 онд 8 байршилд 4209 м2, 2022 онд 10 байршилд 7250 м2 авто зогсоолыг ашиглалтад оруулсан байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар авто зогсоолыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Найрамдал өндөрлөг, Их шүтээн цогцолборын 3025 м2 авто зогсоол, Ундаргын 3-р гудамж, 17-р сургуулийн ард тал Соёлын төвийн дэргэд 1395 м2 авто зогсоол, 4-25 дугаар байрны 320 м2 авто зогсоол өргөтгөх, 11-р хороолол "Тамирын 3 чулуу" байрны зүүн талын автомашины 417.5 м2 зогсоол, Орон сууцны 1-р хорооллын 25-р байрны гадна 323 м2 зогсоолыг өргөтгөх, 4-р хорооллын 8 дугаар байрны урд талд 417.5 м2 талбай бүхий 6 байршилд нийт 5898 м2 авто зогсоолыг шинээр барьж ашиглалтад оруулаад байна.	100%
188		Хотын доторх авто замын нөхөөс, тэмдэг тэмдэглэгээг үе шаттайгаар хийх	2021-2024	ХБТХ ОХ	ХЗА ХББЗ А	Орон нутгийн төсөв	299.6	Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 92 км хатуу хучилттай авто замын 15 % -д нь нөхөөс, тэмдэг тэмдэглэгээний ажил	5000 м.кв талбайд нөхөөсний ажил хийгдсэн байна.	Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд	Авто замын сан болон орон нутгийн төсөв 2850.0	Аймгийн хэмжээнд 2021 онд 38 байршилд 3.2 км авто замд 4796м урт хэвтээ тэмдэглэгээ, 105 байршилд шинээр босоо тэмдэг, 217 босоо тэмдгийг сэргээн засварлаж 5073 м2 талбайд авто замын нөхөөсний ажил, 2022 онд 7200 тэмдэглэгээ сэргээх, 50 ширхэг тэмдэг шинээр суулгаж, 5089.7 м.кв талбайд авто замын нөхөөсний ажил тус тус хийж гүйцэтгэсэн байна. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр хорооллын 18 дугаар байрны арын замыг тусгаарлах 160 м тусгаарлах хашаа, Эрдэнэ багт авто зам дагуу 144 м туузан хашлага, авто замын сангийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Орхон АЗЗА" ТӨХК нь Оюут багт 54.42м2, Зэст багт 40.91м2, Уртбулаг багт 63.5м2, Уурхайчин багт 312.67м2, Чандмань багт	100%

190	6.2.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	"Хөх Монгол", "Их шүтээн", "Ёс заншлын өргөө" цогцолборуудын материаллаг бааз, менежментийг сайжруулж, амралтын бүс болгох	2021-2024	Аймаг, Сумдын ЗДТГ	БОАЖГ	Орон нутгийн төсөв	13.0	-	Иргэд чөлөөт цагаа өнгөрөөх боломж бүрэн хангагдсан байна.	5.0	улсын төсөв 100.0 Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд 524.0	БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр Эрдэнэтийн угтах хаалга орчимд түр буудаллах цэгийг бий болгож MNS5924:2015 стандартын шаардлага хангасан 3.5х7м хэмжээтэй эко ариун цэврийн байгууламжийг, гүний худаг, нарны гэрлээр цэнэглэгддэг шон, ангилдаг хогийн савны хамт ашиглалтад орууллаа. Их шүтээн цогцолборт иргэдийн хандив тусламжаар 2021 оноос хойш нийт 82.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 ш суваргыг сүсэгтэн олон, иргэдийн хандив, тусламжаар барьж ашиглалтад оруулсан. Мөн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н зураг, төсвийн дагуу Их шүтээн цогцолборт 2023 онд авто замын зогсоол, 108 шатыг шинэчлэх, гэрэлтүүлэг бүхий ажлыг нийт 524.0 сая төгрөгөөр Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.	100%
191		Зочид буудал, жуулчны баазуудын үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх	2021-2024	БОАЖГ	Сумдын ЗДТГ	Хувийн хэвшил	-	Зэрэглэлтэй Зочид буудал-3 жуулчны баазын тоо-1	Шаардлага хангасан байгууллагын тоо 2	-	-	Аймгийн хэмжээнд 532 ор бүхий 25 зочид буудал, 10 дэн буудал үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 одны зэрэглэлтэй 2 зочид буудал, 1 одны зэрэглэлтэй 1 зочид буудал, 2 цэцгийн зэрэглэлтэй 1 амралтын бааз үйл ажиллагаа явуулж байна. Шинээр Соррег зочид буудал ашиглалтад орж зэрэглэлийн стандартыг хангаж байгаа тул 2024 онд зэрэглэл авах хүсэлтээ өгөхөөр бэлтгээд байна. Зэрэглэл авахаар бэлтгэж буй зочид буудлуудын үйл ажиллагааг орон нутгийн ажлын хэсэг шалгаж стандартын хэрэгжилтийг үнэлж бүрэн хангасан байх зөвлөмжийг өгсөн. Зочид буудлын үйлчилгээ эрхлэгч 9 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 7 буудал, 3 дэн буудалд тохирлын үнэлгээ хийж, стандартын зарим шаардлагыг хангуулан залруулга хийлгэснээр зочид буудлын стандартын хэрэгжилт дунджаар 86.2 хувьд хүрсэн. "Зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудыг чадавхжуулах" сургалтыг МУИС-ийн "Аялал жуулчлалын хөтөлбөр"-ийн багш нартай хамтран салбарын ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зочлох үйлчилгээний салбарын ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний соёл, найрсаг харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалтыг зохион	50%

												байгуулж нийт 73 хүнийг мэргэшүүлэх сургалтад хамрууллаа. "Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага" MNS 5927:2008 стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж буй томоохон зочид буудлуудад орон нутагт зохион байгуулагдсан арга хэмжээний оролцогчид, зочдыг тогтмол байрлуулж хамтран ажиллалаа.	
192	6.3.Орхон аймаг, Эрдэнэт хотын соёлын онцлогт тохирсон шинэлэг, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин, аялал жуулчлалаас орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.	Брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулан, гадаад, дотоодод сурталчлах, худалдан борлуулах боломжийг нэмэгдүүлэх	2021-2024	БОАЖ Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	5 брэнд бүтээгдэхүүн	Худалдан борлуулах боломжийг бүрдүүлсэн байна.	5.0	-	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдан ажиллаж байна. Аймгийн хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, брэнд бий болгох, орон нутгийн онцлог бүтээгдэхүүний бэлгийн багц гаргах зорилгоор бүтээгдэхүүн шалгаруулах болзолт уралдааныг 1 сарын хугацаанд зарлан явуулж, уралдаанд 23 төрлийн бүтээгдэхүүн ирснээс Ачит андага ХХК-ийн артишок цай, "Баярмөнх наран" ХХК-ийн кофе, "Жимст бэйкери" жигнэмэг, "Өндөрлөг урлан" цехийн Итали арьсан түлхүүрийн оосор, картны уут, "Түмэн дархан" цехийн Зэс арсланг шалгаруулан тус бүрт 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих төслөөс аймгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд брэндийн сургалт явуулж, шалгарсан Эрдэнэт өндөг ХХК, Идэр баялаг ХХК, Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо, Ариус дэсерт катеринг ХХК зэрэг 4 аж ахуйн нэгжид тус бүр 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж авах эрх олгосон. Аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд зарласан уралдаанд өндөрлөг брэнд, батаар вүүд, сампин брэнд, аранжин брэнд, сүргийн шим зэрэг бүтээгдэхүүнүүд шалгарч Эрдэнэтэд үйлдвэрлэв худалдааны цэгээр дамжуулан бүх нийтэд хүргэж байна. Бүх ард түмний өвлийн спортын наадмын хүрээнд аймгийн бэлгэдэл болсон арслан, гүег бүхий чихмэлийг орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид худалдаанд гаргаж, улмаар зохион байгуулагдаж буй бүх тэмцээн уралдаанд уг тоглоомыг брэнд болгон гардуулж байна. Мөн "ITM Mongolia 2023" арга хэмжээнд орон нутгийн брэнд Арьсан эдлэл-өндөрлөг брэнд, гар урлал-	100%

											сампин брэнд бүтээгдэхүүнийг оролцуулан худалдан борлуулах боломжоор хангасан. Эрдмин ХХК-ний 2023 оны шинэ загвар олон үйлдэлт залгуурт аймгийн брэнд бүтээгдэхүүний логог олголоо.		
193		Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн маршрутыг шинэчлэн гаргаж мөрдүүлэх, ААНБ, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих	2021-2024	ХБТХ ОХ	БОАЖ Г Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	52.0	14 чиглэлийн маршрут	Хувийн хэвшил, ТББ-д хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.	15.0	-	Хил орчмын аялал жуулчлалын К-3 визний зөвшөөрөл бүхий жуулчдад зориулсан 72 цагийн аялалын маршрутыг гарган БОАЖЯаманд хүргүүллээ. Мөн Баян-Өндөр хайрхан /1.4га/ болон Эрдэнэт хаалга /3.4га/ орчимд аялал жуулчлалын бүс болгох, шинэ маршрут бий болгох ажлын хүрээнд ерөнхий төлөвлөлтийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүллээ. Бүх ард түмний өвлийн спортын наадам, Бүргэдийн баяр, Хамтдаа Эрдэнэтэд хөгжье Эдийн засгийн форум, Зэс фестиваль зэрэг арга хэмжээнүүдэд ирсэн зочид төлөөлөгчдийг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудалд байрлуулах, хооллох, худалдаа үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж, Эрдэнэт хотыг танилцуулах “City tour” аялалыг 5 төрлийн маршрутаар зохион байгуулж ажилласан. Зэс фестиваль эвент арга хэмжээг аймгийн томоохон 5 үйлдвэр, 16 ААНБ-тай хамтран зохион байгуулж 10.0-12.0 мянган хүн үзэж сонирхон, 23.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн.	90%
194	6.4.Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.	Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн төв цэгийг цахим хэлбэрээр байгуулах	2021-2024	Аймгийн ЗДТГ	БОАЖ Г Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв БХАХЗ	18.0	-	Мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулсан байна.	5.0	Орон нутгийн төсөв 18.0	Аймгийн зочид буудал, амралт сувиллын газар, ресторан зоогийн газар, үзвэр үйлчилгээ, тээврийн хэрэгслийн мэдээлэл, маршрут, түүх дурсгал зэрэг мэдээллийг багтаасан аялал жуулчлалын welcome.erdenet.mn веб сайтыг бэлэн болгон мэдээ, мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Байгаль орчин, аялал жуулчлалын газар пэйж хуудсаар дамжуулан Welcome to erdenet видео контент болон аялал жуулчлалын цаг үеийн мэдээ, мэдээлэл, зохион байгуулсан ажлыг нийт 8000 орчим хүнд хүргэн ажиллалаа. Монголд зочлох жилийн хүрээнд БОАЖЯам, АЖХТөвтэй хамтран QR хэлбэртэй мэдээллийг зам дагуух 3 самбарт байршуулан бүх нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байна. ITM-2023 аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн танилцуулга мэдээлэл, видео бичлэгийг цахимаар хүргэх ажлыг киоск, VR төхөөрөмжийн тусламжтайгаар бүх нийтэд хүргэлээ.	90%

195		Өвлийн аялал жуулчлалын материаллаг баазыг нэмэгдүүлж, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ	БОАЖГ Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	30.0	-	Жуулчлалын оператор компаниудтай хамтран ажиллах боломж бүрдсэн байна.	10.0	Орон нутгийн төсөв 13.4	Монголын бүх ард түмний өвлийн спортын 16 дугаар наадам, Монголын хүүхдийн спортын 7 дугаар наадам Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт уриан дор зохион байгуулагдсан ба 12 аймаг нийслэлийн 7 дүүргийн 722 тамирчдыг оролцуулсан тэмцээнд оролцогчдыг нэгдсэн зохион байгуулалттай зочид буудлуудад байрлуулж, нэгдсэн хоол ундаагаар үйлчлэх, Эрдэнэт хотыг танилцуулах “City tour” аялал, 3 цэгт худалдаа үйлчилгээ, Эрдэнэтийн гар урлал бэлэг дурсгалын бүтээгдэхүүн худалдаалах цэгүүдийг тус тус ажиллуулж бүх нийтэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн худалдаа үйлчилгээний байгууллагуудыг уртасгасан цагаар ажиллуулах шийдвэрийг гаргуулан аймгийн ахуйн үйлчилгээний газрууд, зочид буудал, ресторан зоогийн газрууд, хүргэлтийн үйлчилгээний мэдээллээр ханган тамирчид байрласан нийт 20 орчим цэгт хүргэлтийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгууллаа. Казак түмний үндэсний баяр болох Наурызын баярыг тохиолдуулан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 03 дугаар сард Засаг даргын 2023 оны А/142 тоот захирамжийн дагуу Бүргэдийн баяр-2023 эвент арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд 12 бүргэдчин Баян-Өлгий аймгаас хүрэлцэн ирж Орхон аймагт анх удаа хамтарсан арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд 8000 орчим хүн оролцож, орон нутгийн бизнес эрхлэгчид орлого олох боломжийг бүрдүүлэн ажилласан.	90%
ДОЛОО.ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ													
7.1.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.													
196	7.1.1.Металлургийн үйлдвэрлэлийн үндсэн хэсэг болох ширмийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	Хувийн хэвшлийн оролцоотой ширмийн үйлдвэр байгуулах	2021-2022	Хувийн хэвшил	ХБТХ ОХ	Хөгжлийн банк	Төслийн санхүүжилтээр	Үйлдвэр байгуулах	Үйлдвэр байгуулсан байна.	Төслийн санхүүжилтээр	-	Үндсэн болон туслах түүхий эд (төмрийн хүдэр, кокс, шохойн чулуу, галд тэсвэртэй материал) нийлүүлэгч компаниудын судалгаа хийгдсэн. Түүхий эдийн шинж чанарын судалгааг хийж гүйцэтгэж байна. Зуухны галд тэсвэртэй доторлогоог шинэчлэн доторлож, агаар халаах зуухны форсунк, хий дамжуулах шугамд засвар хийсэн. Домен зуухны тоосны байгууламжийн уутан филтерүүдийг шинээр сольж, засвар гагнуур хийж, зуухны хаалтуудад тосолгоо үйлчилгээ хийсэн. Зуухны фурмын нөөц бэлдэх ажил хийж шинээр 20 ширхэг фурм хийж нөөцөд бэлдсэн. Түүхий эд ачаалах автомат систем зураг төсөл хийж, угсрах бэлтгэл ажил хийгдэн 2-р	30%

												ээлжийн 70 м.куб Домен зуухны бүтээн байгуулалт, 70 м.куб-ийн Домен зуухны агаар халаах зуух, материал ачаалах системийн угсралт, гагнуурын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хөгжлийн банкны зээлтэй холбоотой Авилгалтай тэмцэх газраас шалгаж үйлдвэрийг хааж битүүмжилсэн.	
197	7.1.2."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийг дэмжин ажиллах	2021-2024	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	ХБТХ ОХ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Төслийн санхүүжилт зэр	Төслийн хэрэгжилт 50%-д хүрнэ	Төсөл хэрэгжилт 35%	-	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж нь Ерөнхий инженерийн харьяалалд үйлдвэрийн газрын бие даасан бүтцийн нэгж болон өөрчлөгдсөн. Үйлдвэрлэл, технологийн парк дэд бүтцийн шугам татах трассын зураг гаргахад аймаг орон нутгийн зүгээс газрын давхцал бусад инженерийн шугам сүлжээний трассын мэдээллийг солилцон хамтран ажиллалаа. Үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийн ажлууд дараах үед шаттай явагдаж байна. УТП-ийн цахилгаан хангамжийн 220/110/35 кв, 110/35/10 кв дэд станц, ЦДАШ 9 км-ыг барьж байгуулах нарийвчилсан зураг төслийн ажлыг Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэж байгаа бөгөөд УТП-ын төслийн нэгжийн зүгээс шаардлагатай ажлуудыг батлагдсан төсөвт өртөгт багтаан зохион байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих зэрэг ажлын гүйцэтгэл 20.0%, төмөр зам барьж байгуулах ажлын явц 48.0%, авто зам барьж байгуулах ажлын явц 34.0%, УТП-ийг байгуулах газрын хил хязгаарыг тойруулан хашаа барих ажлын явц 85.0%-тай тус тус явагдаж байна.	50%
7.2.Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.													
198	7.2.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдаж хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумын ЗДТГ	Улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	1.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	Хөнгөлөлттэй зээл олгоно.	Батлагдсан төсвийн хүрээнд	ЖДҮС-894.0 Хоршоо хөгжүүлэх сан 533.0 ХААҮДС 14200.0	2021-2022 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 9 аж ахуйн нэгжид 3.1 тэрбум, 53 иргэнд 1.2 тэрбум буюу нийт 4.3 тэрбум төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1 аж ахуйн нэгжид 94.3 сая төгрөг, аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1 аж ахуйн нэгж хамрагдаж 50.0 сая төгрөгийн зээлийг тус тус олгож 33 ажлын байр хадгалагдаж, 4 ажлын байр шинээр нэмэгдсэн. 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас журмын шаардлага хангасан 5 төсөлд 894.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 27 иргэн, аж ахуйн нэгжид 533.0 сая төгрөгийн зээл олгосон.	100%

											Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд нийт 14.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдоод байна.		
199		Бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, батлан даалтын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	24.0	415.5 сая төгрөгийн зээл, 513.0 сая төгрөгийн батлан даалт гаргасан.	Шаардлага хангасан төслийн тоогоор	4.0	Улсын төсөв 5000.0	2022 онд Орхон аймгийн ЗДТГ, Эрдэнэт ШУТП-Бизнес хөгжлийн төв, Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэгийн-Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих "PROGRESS" төсөлтэй хамтран жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 38 иргэн, аж ахуйн нэгжийг нийт 320.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамруулсан. 2023 онд Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, ШУТП-Бизнес хөгжлийн төв, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих GIZ-PROGRESS төслөөс 15 аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилт, "Хөгжлийн шийдэл" Төрийн бус байгууллагын BEST хөтөлбөрөөс 5 аж ахуйн нэгжид 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Жайка төслөөс 4 төсөлд 3.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлэмж, оёдол, гутал, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах зэрэг чиглэлээр өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч 880 иргэн, аж ахуйн нэгжид шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.	100%
200	7.2.2.Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ.	Ахуйн үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	100.0	Суурь судалгаа хийгдсэн.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 60%-д хүргэнэ.	30.0	Орон нутгийн төсөв 10.0	"Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Өөрийгөө хөгжүүлэх нь", "Амжилтын 10000 цагийн төлөвлөгөө" сэдэвт сургалтад 50 гаруй хүн хамрагдаж мэдээлэл авсан. Жаргалант сумын ЗДТГ, мэргэжлийн холбоодтой хамтран "Явуулын ахуйн үйлчилгээ"-г Дулаан-Уул багийн Баруунбулагт зохион байгуулж гутал засвар, цаг засвар, үсчин, маникюр, гар урлалын 5 чиглэлээр 100 гаруй хүнд үйлчилгээ үзүүлэв. Үсчин, гоо засалч, хумс засалч, нүүр будагч мэргэжлээр ажиллаж, сурч хөдөлмөрлөж байгаа иргэдийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, салбарын шинэ чиг хандлагыг таниулан	100%

											сурталчлах, нэвтрүүлэх зорилгоор Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран аймгийн Үсчин, гоо засал, хумс урлалын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, тэмцээнд 17 төрөлд 109 хүн амжилттай оролцсон. Аймгийн хэмжээнд ахуйн үйлчилгээний салбарт 346 цэгт аж ахуйн нэгж, иргэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 4.0 хувь нь нийтийн халуун ус, 23.1 хувь нь үсчин, гоо сайхан 24.6 хувь нь хувцас захиалга, засвар, 1.4 хувь нь гэрэл зураг авах, угаах, 0.9 хувь нь хими цэвэрлэгээ, угаалга, 0.9 хувь нь ахуйн электрон, цахилгаан хэрэгсэл засвар, 6.9 хувь нь гутал захиалга, засвар, 5.5 хувь нь гэр ахуйн модон эдлэл захиалга, засвар, 2.3 хувь нь алт, мөнгө, үнэт эдлэлийн захиалга, засвар, 30.6 хувь нь бусад үйлчилгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна. Ахуйн үйлчилгээ хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласнаар 2023 оны байдлаар 72 хувийн хэрэгжилттэй байна.		
201		Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшин дээшлүүлэхэд сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, тохирлын үнэлгээнд хамруулах	2022-2024	СХЗХ	ХХАА Г Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	6.0	Шаардлага хангасан үйлчилгээний хувь 20%	Жил бүр 10%	2.0	-	2022 онд аймгийн хэмжээнд үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхлэгчид, ажлын байр түрээслэгчдэд "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020, "Гоёлын гоо заслын үйлчилгээ" MNS 5567:2006, "Хумс заслын үйлчилгээ" MNS 6843:2020 стандартын сургалтыг зохион байгуулж 182 хүн, Монголын үсчин, гоо засалчдын холбооны тэргүүлэгч мастер багшийн 5 хоногийн шаталсан сургалтад давхардсан тоогоор 180 үсчин, гоо сайханч хамруулж, давхардсан тоогоор 300 гаруй хүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. 8 багийн 71 цэг салбарын 11 үйлчилгээнд "Баталгаажуулалтын мэдэгдэл" өгч ажилласнаар стандартын шаардлага хангасан "Сэрвэн цахир", "Үзэмж гоо", "Жавхлан", "Сувд гоо", "Болор" зэрэг 5 үсчний газарт тохирлын гэрчилгээ олгосон. 2023 онд ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшинг дээшлүүлэхэд тохирлын баталгаажуулалтад хамрагдах талаар нийт 5 удаагийн мэдээлэл, сурталчилгаа зохион байгуулж, 1 удаагийн сургалтад 3 үйлчилгээ эрхлэгчийг хамруулснаар халуун ус, сауны үйлчилгээ эрхлэгч 2 аж ахуйн нэгжийн 4 үйлчилгээ, 1 иргэний үсчин, гоо сайхны үйлчилгээг баталгаажуулалтад хамруулан гэрчилгээ олгосон нь баталгаажсан үйлчилгээ 10.3 хувиар нэмэгдэж,	70%

												нийт шаардлага хангасан үйлчилгээ 26.3 хувьд хүрсэн.	
202		“Эрдэнэт үйлдвэрлэл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	191.0	Хөтөлбөрийн хэрэгжилт 70%	Хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. Хэрэгжилт 50%	50.0	-	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны Ээлжит Х хуралдаанаар “Эрдэнэт үйлдвэрлэл” дэд хөтөлбөр батлагдсан. Тус хөтөлбөр нь 2018-2021 онд 94.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. “Эрдэнэт үйлдвэрлэл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр “Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор батлуулан 83.5 хувийн хэрэгжилттэй байна.	90%
203	7.2.3.Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.	“Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г Сумдын ЗДТГ	“ШУТ П” ХХҮГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Батлагдсан төсвийн хүрээнд	Хөтөлбөрийн төслийг боловсруулсан.	Хөтөлбөрийн хэрэгжилт 75%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 20.0	Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/02 дугаар тогтоолоор “Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөр” батлуулан 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөн, дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр хөтөлбөрийн хэрэгжилт 83.5 хувьтай байна. Өрхийн үйлдвэр эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, 52 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулснаар өрхийн бизнес загвараа хэрхэн гаргах талаар мэдлэг, мэдээлэлтэй болж зөвлөх үйлчилгээнд хамрагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлэмж, оёдол, гутал, мах болон сүү боловсруулах чиглэлээр өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч нийт 880 иргэнд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. “Бялхам Ивээл” ХХК-тай хамтран дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хүлэмжийн аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор “Хөдөө аж ахуй технологи” сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 45 иргэнийг хамруулснаар хөрсний менежментийн болон суулгац, эрт тариалах, усалгааны, халдварт өвчнөөс сэргийлэх, улаан лооль, өргөст хэмх тариалах технологийн мэдлэгтэй болсон. Мөн Сэлэнгэ аймгийн Баруунхараа суманд хүлэмжийн аж ахуйн туршлага судлах аялалд өрхийн тариаланчдыг хамруулсан. “Хөгжлийн шийдэл” Төрийн бус байгууллагын BEST хөтөлбөрөөс бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж төсөл бичих арга зүйд суралцуулснаар 37 иргэн, аж ахуйн нэгж төсөл	100%

											бичиж арилжааны банкнуудаас 1.9 тэрбум төгрөгийн бизнесийн зээл авч, 6 ажлын байр шинээр нэмэгдэн, 76 ажлын байр хадгалагдсан. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран “Бизнес эрхэлье” сургалтыг бизнес эрхлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгч болон албан бус салбарын 60 залуучуудыг хамрууллаа. "Эрдэнэтэд үйлдвэрлэв-2023" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 45 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч оролцлоо.		
204	7.2.4.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг зээлийн бодлогоор дэмжин ажиллах	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г Сумдын ЗДТГ	ХХҮГ	Улсын төсөв болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	2.000.0	7 төсөл 330.0 сая төгрөгийн хөнгөлөлт тэй зээлд хамрагдсан.	500.0 сая төгрөгийн зээлд хамруулна.	-	-	2023 онд Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс 22 аж ахуйн нэгж, 18 иргэнд нийт 14.2 тэрбум, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 5 аж ахуйн нэгжид нийт 894.0 сая төгрөгийн зээл олгосон. Хоршоо хөгжүүлэх сангаас мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 иргэн, аж ахуйн нэгжид 315.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Эрдэнэт хивс" ХХК нь 8 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортод гаргаж байна. Мөн "Эрдэнэт кашмер" ХХК нь 2023 онд нэхэх, сүлжих цехийн хүчин чадлыг сайжруулсан. "Мөнх баян алт" ХХК нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Progress төслөөс хонины ноосон эсгий тавчик, эсгий дотортой арьсан гутал, ажлын эсгий гутал үйлдвэрлэхээр 9.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг авч, тоног төхөөрөмжөө шинэчлэн бүрэн автомат үйлдэлтэй болгосноор шинээр 6 ажлын байрыг бий болгон 13 ажлын байр хадгалагдаж, жилд 2500-3000 хос эсгий табчик үйлдвэрлэн экспортолж байна.	100%
205		Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд тохирлын	2021-2024	СХЗХ	ХХАА Г МХГ	Орон нутгийн төсөв	20.0	Нийт үйлдвэрлэлийн 20%	Нийт үйлдвэрлэлийн 35%	5.0	-	2023 оны байдлаар аймгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нийт 17 үйлдвэрийн 11 нь буюу 64.7 хувь баталгаажуултад хамрагдаж 26 нэрийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж баталгаажуулсан. Эрдэнэт хивс, Эрдэнэт кашмер ХХК-ийн 4 нэр төрлийн 13 нэрийн бүтээгдэхүүн, мал төхөөрөх, мах боловсруулах 4 үйлдвэрийн 3 нэрийн бүтээгдэхүүн баталгаажуулалтад хамрагдан, тохирлын гэрчилгээ авч бүтээгдэхүүнээ экспортлож байна.	100%

		баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлэх										Аймгийн хэмжээнд 4 үйлдвэрийн 16 нэрийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах тухай бүрд нь тохирлын баталгаажуулалтад хамруулан гэрчилгээжүүлж, гадаад худалдааг хөнгөвчилж байна. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 35.2 хувийг экспортод гаргаж байна.	
7.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.													
206	7.3.1.Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ.	Төмс, хүнсний ногооны техник шинэчлэлийг үргэлжлүүлэн, ашиглалтыг сайжруулан, агропарк байгуулах	2021-2022	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	240.0	Агро үйлчилгээний төвд 41.8 сая төгрөгийг шийдвэрлэн LOVOL-824 трактор худалдан авсан.	-	-	Орон нутгийн төсөв 3600.0	2022 онд Техник дундын төв нь нийт 147 иргэний 196.5 га талбайд 5 төрлийн үйлчилгээ үзүүлсэн. 2023 онд Техник дундын үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн төсвийн 177.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмж худалдан авч 10 төрлийн ажил үйлчилгээг давхардсан тоогоор 257 иргэнд үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 70.0 хувиар өссөн. Агропаркийг түшиглэн Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорийг 2024 онд ашиглалтад оруулахаар барьж байна.	90%
207		Төмс, хүнсний ногооны талбайг хашаажуулах ажлыг зохион байгуулах	2022-2024	ХХАА Г ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Улсын төсөв	84.0	Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 250 га талбайг хашаажуулсан.	Төмс, хүнсний ногооны 20 га талбайг хашаажуулна.	28.0	Орон нутгийн төсөв 234.0	2019-2020 онд улсын төсвийн 200.0 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 193 иргэний эзэмшлийн 257 га төмс, хүнсний ногооны талбайг хашиж хамгаалсан. Үүнд Жаргалант сумын "Бөөн бургас"-т 10.2 км, Мухар буланд 15 км ногооны хашааг ашиглалтад оруулж, сумын Засаг даргын Тамгын газрын өмчид шилжүүлэн өгсөн. 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Жаргалант сумын Бөөн бургастад 3.6 км хашаа шинээр барьж, 36-р тоочигч 1.5 км хашаа сэргээн засварласнаар 49 иргэний эзэмшлийн 51 га талбайг хашиж хамгаалсан.	100%
208	7.3.2.Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн талбай, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.	Усалгааны тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй зээлээр худалдан авахад иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах	2022-2024	ХХАА Г ХААДС	-	Улсын төсөв болон төсөл хөтөлбөр	600.0	1 аж ахуйн нэгж 50 га талбайн инженерийн хийцтэй услалтын системийн дэмжлэгт хамрагдсан.	Аж ахуйн нэгжийг услалтын системийн дэмжлэгт хамруулна.	300.0	Улсын төсвийн 216.0	2022 онд инженерийн хийцтэй худагтай 10 га талбайд хүнсний ногоо тариалж 135 тн буюу га-аас 135 цн, гадаргын усалгаатай 273 га талбайд төмс тариалж 3072 тн буюу га-аас 112.5, хүнсний ногоо 493.2 га талбайд тариалж 5948 тн буюу га-аас 120 цн ургац тус тус хураан авсан. 2023 онд "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 12 ширхэг 1 га талбайг урлах хүчин чадалтай бороожуулах услалтын системийг тариаланчдад олгосноор усалгаатай тариалангийн талбай нэмэгдсэн. Энэ онд төмс 145 га, хүнсний ногоо 455 га талбайд усалгаатай нөхцөлд тариалсан бөгөөд үүнээс гадаргуугийн усалгаатай 510 га буюу 85 хувь, усалгааны тоног төхөөрөмжөөр 90 га буюу 15 хувь байна.	90%

											Усалгаатай нөхцөлд төмс 145 га-аас 1628 тонн буюу га-аас 112 цн, хүнсний ногоо 455 га-аас 9520 тн буюу га-аас 209 цн ургац тус тус хураан авсан.	
209		Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2021-2024	Аймгийн ЗДТГ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	600.0	Жил бүр 1000 өрхийг хөтөлбөрт хамруулсан.	Хөтөлбөрийн хэрэгжилт 80%	150.0	Орон нутгийн төсөв 40.0	100%
											Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, жил бүр шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган ажиллаж байна. 2023 онд орон нутгийн төсөвт 40.0 сая төгрөг тусгаснаар хөтөлбөрт хамрагдсан Баян-Өндөр сумын 26 багийн 500 өрхөд 5 төрлийн үрийн багц олгож, төмс, хүнсний ногоо тариалах гарын авлагаар ханган, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон 13 төрлийн 2.6 тн үрийг 235 өрх, аж ахуйн нэгжид олгосноор нийт 735 өрх, аж ахуйн нэгж 8 га талбайд төмс, 140 га талбайд хүнсний ногоо тариалсан. Улсын төсвийн хөрөнгөөр "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд 90 ширхэг, "Шинэ хөдөө-Орхон" төслийн хүрээнд 10 ширхэг, нийт 100 ширхэг хүлэмжийг иргэн, аж ахуйн нэгжид олгосноор хүлэмжийн талбай 1.2 га талбайгаар нэмэгдсэн. Энэ онд 5.1 га талбайд хүлэмжийн тариалалт хийж, 305 тн ургац хураан авснаар өмнөх оноос 55 тн-р нэмэгдсэн. Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран зохион байгуулсан "Хөдөө аж ахуйн технологи"-ийн сургалтад 45 өрхийн тариаланчийг хамруулсан. Тус хөтөлбөрийн хэрэгжилт 98.0 хувьтай хэрэгжиж байна.	
210	7.3.3.Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	30.0	-	2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.	10.0	Орон нутгийн төсөв 5.8	100%
											2023 онд аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж өмнөх оноос 27.0 хувиар өссөн байна. Үүнд: 30 иргэн мах, сүүний чиглэлийн 370 толгой үхэр, 11 иргэн махны чиглэлийн 414 толгой үхэр, 2 иргэн 269 толгой махны чиглэлийн нарийн ноост хонь, 12 иргэн 590 толгой гахай, 78 иргэн 3195 толгой шувуу, 15 иргэн 329 бүл зөгий, 4 иргэн 96 толгой туулайг тус тус өсгөн үржүүлж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад 4 иргэн хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн. "Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн"-д	

	хөгжлийг дэмжинэ.										махны үхрийн аж ахуй эрхэлдэг, эрхлэх сонирхолтой 9 иргэн, аж ахуйн нэгж, "Төв түмний сүүн соёл -2023" арга хэмжээнд сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 5 иргэн, мах-ноосны чиглэлийн Суффолк үүлдрийн хонины аж ахуйтай танилцах аялалд 9 иргэн, нийт 23 иргэн, аж ахуйн нэгжийг тус тус хамруулан туршлага судлуулсан. Энэхүү ажилд орон нутгийн төсвөөс 5.8 сая төгрөгийг зарцуулсан. "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран "Сүүний технологи, эрүүл ахуйн зохистой дадал" сэдэвт сургалтыг зохион байгуулж эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 иргэн, аж ахуйн нэгж оролцуулан мэдээллээр хангасан.		
211		Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх	2021-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	220.0	өвс 190 тн, тэжээл 70 тн	Аюулгүйн нөөцийг 100% бэлтгэнэ.	60.0	Орон нутгийн төсөв 175.0	2022 онд аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 37.5 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 118 тн өвс, 35.9 тн тэжээл, нийт 218 тн өвс, 73.4 тн тэжээл бэлтгэж аймаг, сумын аюулгүйн нөөцийг 100 хувь бэлтгэсэн. Аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын 32 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ жил аймгийн аюулгүйн нөөцөд өвс 200 тн, тэжээл 86.1тн-ыг бүрдүүлэхээр төлөвлөж, аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 100 хувь бүрдүүллээ. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, Баян-Өндөр, Жаргалант сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлдэхэд орон нутгийн төсвөөс тус бүр 50.0 сая төгрөг зарцуулсан.	100%
212		Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх ажлыг өргөжүүлэн, фермерүүдийг дэмжих	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	1.800.0	Үхрийн фермер 15, гахай фермер 1, тахианы аж ахуй 5, зөгийн 14 аж ахуйн нэгж	Төсөл хөтөлбөрт хамруулан дэмжсэн байна.	600.0	-	2021-2022 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 5 иргэн, аж ахуйн нэгжид 332.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2023 онд "Хоршоо хөгжүүлэх сан"-аас мах, сүүний чиглэлийн үхэр сүргийн чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд 6 иргэнд 138.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч фермерүүдийг дэмжих ажлын хүрээнд "Эрдэнэт хот орчмын сүүний үхрийн фермерүүдийн холбоо"-нд ногоон тэжээл боох төхөөрөмж худалдан авахад орон нутгийн төсвөөс 8.0 сая, Прогресс төслөөс 7.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг	100%

												дэмжих хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд нийт 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 168 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа нь өмнөх оноос 27.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
213	7.3.4.Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг тогтвортой байлгана.	Худаг уст цэгийг шинээр гаргах болон сэргээн засварлаж малчдад эзэмшүүлэх	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	270.0	Бэлчээрт 71 худаг ашиглагд аж, малчин өрхийн 80% усаар хангагдсан.	2 худаг шинээр, 2 худаг сэргээн засварлана.	90.0	Улсын төсөв 60.0 Орон нутгийн төсөв 230.9	Аймгийн хэмжээнд бэлчээрийн зориулалттай 86 уст цэг байгаагаас инженерийн хийцтэй 80, усан сан 6 байна. Энэ онд улсын төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2, орон нутгийн төсвийн 230.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 худаг шинээр гаргаснаар 63 өрхийн 17.8 мянган толгой мал усаар хангагдсан. Бэлчээрийн усан хангамж 86.1 хувьтай болоод байна.	100%
214		Бэлчээрт үлийн цагаан оготны тандалт судалгаа хийх	2022-2024	ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	6.0	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 30%-д хийсэн байна.	Бэлчээрийн тандалт, судалгааг бэлчээрийн 10%-д хийсэн байна.	2.0	-	Манай аймаг нийт 39.3 мянган га бэлчээрийн талбайтай ба үлийн цагаан оготны тандалт судалгааг 4000 га газарт хийж гүйцэтгэхэд үлийн цагаан оготны тархалт илрээгүй.	100%
215	7.3.5.Орон нутгийн онцлогт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн цөм сүргийн малаар сайжруулна.	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх	2022-2024	ХБТХ ОХ	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	150.0	496 толгой хуц, ухна тоологдсоноос 81% буюу 402 толгой хуц, ухныг 3 суурьт ялган төвлөрүүлсэн.	Бог малын хээлтүүлэгчийн 80-аас дээш хувийг ялган төвлөрүүлнэ.	50.0	-	Аймгийн хэмжээнд 2023 оны эхэнд 848 хуц, ухна тоологдсоноос бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлын хүрээнд 724 толгой хуц, ухна буюу 85.4 хувийг 4 суурьт ялган суурилж, мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авч үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт, ялган тэмдэглэгээ хийж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.	100%
216		Мал сүрэгт үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ хийх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	2021-2024	ХХАА Г ХБТХ ОХ ХХАА Г	Сумдын ЗДТГ	Орон нутгийн төсөв	24.0	35.8 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаа жуулалт хийсэн.	Нийт богийн хээлтүүлэгчийг 100, богийн хээлтэгчийн 60 хүртэлх хувийг хамруулна.	6.0	Орон нутгийн төсөв 9.5	Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. 2022 онд аймгийн хэмжээнд 37000 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн бөгөөд 668 толгой хээлтүүлэгч, 36332 толгой	100%

											хээлтэгчийг хамруулсан. Нийт 5.6 мянган толгой малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. 2023 онд аймгийн хэмжээнд 37.5 мянган толгой малд үзлэг ангилалт, 2.0 мянган толгой үхэрт ялган тэмдэглэгээ хийсэн. Нийт богийн 848 толгой хээлтүүлэгчид буюу хээлтүүлэгчийг 100 хувь, нийт богийн 58.9 мянган толгой хээлтэгчийн 36.8 мянган толгой буюу 62.4 хувийг хамруулан малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.		
217	7.4.Татвар төлөгчдөд чиглэсэн сургалт, зөвлөгөөг тогтмол явуулж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан сургалт, үйлчилгээг үзүүлнэ.	Иргэд, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх цахим сургалтын төвийг тохижуулах	2021-2024	Татварын хэлтэс	СТСХ	Орон нутгийн төсөв	12.0	Иргэд, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх цахим сургалт хийх боломж бүрдсэн байна.	Иргэд, татвар төлөгчдөд цахим сургалтын төвөөр дамжуулан 20 удаа сургалт зохион байгуулна.	0.5	Орон нутгийн төсөв 10.0	2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг “Цахим татварын жил”-ийн болон Орхон аймаг, Эрдэнэт хот 2023 хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж батлуулсны дагуу холбогдох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, татварын ерөнхий газраас баталсан стандартыг ханган биелүүлэхэд онцгойлон анхаарч ажиллалаа. Татвар төлөгчийн ангилал тус бүрийн зан хандлага, хэрэгцээ шаардлага тодорхойлох санал асуулга авч “Шинэ татвар төлөгч”, Шинэ НӨАТ-ын суутган төлөгч, Татварын хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчил, Татварын албаны цахимжилт, Тайлан хоцроодог татвар төлөгчдөд зориулсан сургалт, Татвараа төлж хэвшээгүй татвар төлөгч, Хасагдах зардалд тавих хяналтыг сайжруулах нь, Малчид, тариаланч нарт татварын харилцаа, анхаарах асуудлууд, ХХОАТ зэрэг үндсэн 9 сэдвийг цахим хичээл болгон сургалтууд явуулсан. Сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр явуулсан. Мөн дээрх сургалтуудыг бүрэн QR үүсгэн android болон iOS үйлдлийн системтэй утаснаас сургалтыг бүрэн судлах боломжтой цаасгүй, цахим сургалтын материал үүсгэн татвар төлөгчдөд хүргэж ажилласан. Татвар төлөгчдөөс авсан зан хандлага, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгааны үр дүнд нийцүүлэн сургалтыг танхимаар 52, ажлын байраар 82, цахимаар 41 удаа нийт 175 удаагийн сургалт зохион байгуулж, эдгээр сургалтад давхардсан тоогоор дунд сегмент 72, жижиг сегмент 887, бичил сегмент 5342, хувь хүн 19263 нийт 25564 татвар төлөгчийг хамруулсан. Татвар төлөгчийг мэдээллээр хангах зорилгоор давхардсан тоогоор 20135 татвар төлөгчид масс мессеж илгээсэн.	100%

												Орхон аймгийн ИТХурал, СХТСХэлтэс, Жаргалант сумын ЗДТГ газар, Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Гэр бүл хүүхэд, залуучуудын газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ, Мал эмнэлгийн газар болон төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалтуудыг зохион байгуулсан. Орхон аймгийн татварын хэлтсийн пэйж хуудас, or.mta.gov.mn вэб сайт, “Ибаримт-Буцаан олголт, шинэ мэдээ мэдээлэл” болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл “Тусгал”, “Номин”, ETV, Хотын шуудан сонин, “Гэрэг” TV “Арвис” сайтаар сургалт сурталчилгааг явуулж, телевизэд давхардсан тоогоор 126 , вэб сайтад 112, FM-д 5 удаагийн ярилцлага, мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа хийсэн. Олон нийтийн цахим сүлжээнд 696 сургалт сурталчилгаа, мэдээ байршуулснаар нийт 458959 хүнд хүрч, 9243 лайк, 68178 иргэн хуваалцсан байна.	
НАЙМ.НАЙДВАРТАЙ ЗАСАГЛАЛ													
	“ЦАХИМ ЭРДЭНЭТ” ТӨРИЙН ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ												
	8.1.Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.												
218	8.1.1.“Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөр хэрэгжүүлж төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас шаарддаг байдлыг зогсоож, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хүрээнд “Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх	2020-2024	ТЗУХ	Холбогдох байгууллагууд	Улсын болон орон нутгийн төсөв	200.0	16%	70%	50.0	Орон нутгийн төсөв 1371.0	Аймгийн ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжаар Мастер төлөвлөгөөг батлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 17 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байгаагаас одоогийн байдлаар 10 арга хэмжээ буюу 58.9 хувь нь бүрэн хэрэгжиж дууссан байна. Үүнд: Смарт Эрдэнэт платформ, аймаг болон сумдын веб сайт, газарзүйн мэдээллийн систем, эмнэлгийн түргэний үйлчилгээнд ухаалаг таблет, багийн төвүүдэд ухаалаг төхөөрөмж, шилэн кабелийн хайгуул, Цахим Эрдэнэт сервер, хөдөлгөөнт холбоо, гадаад гарц, мэдээллийн аудит, дугаар илрүүлэгчтэй камер байна. Санхүүжилтэд 1.37 тэрбум төгрөг зарцуулсан ба үүний 62.5 хувь нь программ хангамж, 25.5 хувь нь тоног төхөөрөмж, 12 хувь нь ажил үйлчилгээний төлбөр байна. Төслийн нэгж, мэдээлэл сурталчилгаа, Ухаалаг байгууллага аян өрнүүлэх гэсэн 3 арга хэмжээ үргэлжлэн бизнес хөгжүүлэлт хийгдэж байгаа ба 2023 онд тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд 227.0 сая төгрөг зарцууллаа. 2024 онд шинээр Эрчим хүчний Скада систем, явган хүний ухаалаг гарц, Камерийн ухаалаг хяналтын систем, Нийтийн	90%

												тээврийн цахим системд холбох ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
219		Иргэд, байгууллагууд төрийн үйлчилгээг цахимаар авдаг болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2020-2024	ТЗУХ	-	Улсын төсөв	-	16%	70%	-	Улсын төсөв 84.0	Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хоёр суманд E-Mongolia төвийг байгуулан үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэн ашиглагдах тоног төхөөрөмж, интернэтийн эх үүсвэрээр ханган иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвшээд байна. Мөн. Уг төвөөр төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний цахим (ТУЦ) машинаар иргэн хуулийн этгээдийн 16 төрлийн 37 үйлчилгээ, E-Mongolia Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс иргэн, хуулийн этгээдийн 73 төрлийн үйлчилгээг, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаар 9 төрлийн 72 үйлчилгээг тус тус үзүүлж байна. ХААН банкны АТМ болон киоск машин, Төрийн банкны АТМ, төлбөр тооцооны киоск машинаар төрийн үйлчилгээ, үүрэн холбоо, авто тээвэр гэх мэт 5 төрлийн 33 үйлчилгээг цахимаар хүргэн иргэдэд үйлчилж байна. Одоогийн байдлаар Цахим төвөөр нийт 7000 гаруй иргэн үйлчлүүлж, цахим үйлчилгээ авсан байна.	100%
220		Төрийн байгууллагуудын И-Оффис системийн хөгжүүлэлтийг сайжруулах	2021-2023	ТЗУХ	-	орон нутгийн төсөв	30.0	20.0%	100%	-	Орон нутгийн төсөв 54.5	Төрийн байгууллагуудын албан хэргийн үйл ажиллагаанд И-Оффис систем ашиглагдаж байна. Улсын хэмжээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлагууд, төрийн байгууллагуудтай албан бичиг солилцох дундын https://docx.gov.mn/ системд интеграци хийж албан бичиг солилцох хөгжүүлэлт бүрэн хийгдэж ашиглалтад орсноор тус системд холбогдсон 1374 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломж бүрдээд байна. Системийг 154 байгууллагын 1675 хэрэглэгч албан хэргийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. И-оффис системийн ашиглалтыг өмнөх онтой харьцуулахад байгууллага 13.0 хувь, хэрэглэгч 17.0 хувиар тус тус өссөн байна.	100%
221	8.1.2.Иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахимаар хянадаг	Иргэд, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг цахимаар хянах боломжийг бүрдүүлэх	2021-2023	ТЗУХ	-	Орон нутгийн төсөв	50.0	20.0%	80.0%	-	-	Аймгийн хэмжээнд И-оффис системийг ашиглан иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2021-2022 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албад, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 21666 өргөдөл, гомдол ирснээс 19823 буюу 91.5 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. 2023 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албад, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 10140 өргөдөл,	100%

	тогтолцоог улам сайжруулна.										гомдол ирсний 85 буюу 0.8 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 10055 буюу 99.2 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Ирсэн өргөдөл, гомдлын 157 нь гомдол, 284 нь талархал, 115 нь санал, 1 нь мэдэгдэл, 9583 нь хүсэлт байна. Үүнд: Аймгийн Засаг даргын Тамгын газарт "Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах"-70353511 дугаарын утсыг аймгийн захиргааны байранд ажиллуулан тус төвд биечлэн, www.irgen.erdenet.mn цахимаар болон утсаар иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна. Тайлангийн хугацаанд тус төвд нийт 4026 өргөдөл, гомдол ирснээс 4001 нь буюу 99.4 хувь нь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн, 25 нь буюу 0.6 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Тус төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Орхон аймгийн иргэд irgen.erdenet.mn вэб системийг ашиглаж цахимаар төрийн байгууллагуудад илгээж шийдвэрлэлтийг иргэд хянах боломжтой болсон.		
222	8.1.3.Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд хүн амын тоо, байршлыг харгалзан Баян-Өндөр сумын зарим багуудыг хувааж шинээр баг нэмж байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.	“Багийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2020-2024	ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	260.0	-	80%	65.0	Орон нутгийн төсөв 100.0	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 22 дугаар тогтоолоор Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 2021-2024 онд үргэлжлүүлэхээр шинэчлэн батлуулсан. 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говил, Баянцагаан баг, 2022 онд Яргуйт багийн цогцолбор төв, 2023 онд Зэст багийн цогцолбор төвийн барилгыг ашиглалтад хүлээн авсан. 2021-2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумын нийт багуудыг шаардлагатай техник тоног төхөөрөмж, эд хогшлуудаар хангах, интернетийн хурдыг нэмэгдүүлэх, зарим багийн байруудад урсгал засвар хийх, "Иргэний цахим булан"-г байгуулах зэрэг хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор баг бүрт нутаг дэвсгэрээ хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд нээлттэй хаалганы өдөр, баг сурталчлах арга хэмжээнүүдийг жилд 2-3 удаа зохион байгуулж, Баг, Цагдаа, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, сургалт	90%

												сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг тогтмол зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна. Багийн үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор ажлын байран дахь сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж байгаа ба ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагатай хамтран 200 гаруй албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, багийн хэсгийн ахлагчид, хөршийн холбоо, бүлэг хоршоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг эрчимжүүлэн ажиллалаа. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2021-2023 онд улсын төсвөөс 8.0 тэрбум, сумын ОНХС болон орон нутгийн төсвөөс 560.0 гаруй сая төгрөгийг зарцуулсан бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.	
223		Хүн амын тоо, байршлыг харгалзан Баян-Өндөр сумын зарим багийг хувааж, баг нэмж байгуулах асуудлыг шийдвэрлэх	2021-2023	ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	2.500.0	-	100%	-	-	Аймгийн ИТХ-ын 2022 оны Элжит 8-р хуралдаанаар хүн амын тоо, байршлыг харгалзан төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Баян-Өндөр сумын Эрдэнэ, Яргуйт, Цагаанчулуут багийг хувааж Чингэл, Баян-Овоот, Найрамдал, Чандмань багуудыг шинээр зохион байгуулж, 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж байна.	100%
224	8.1.4.Иргэдийн санал, хүсэлт, санаачилгыг дэмжин бүртгэх, хүлээн авах, бодлого шийдвэрт тусгах нэгдсэн цахим платформ бий болгоно.	Нэгдсэн платформтой болох	2022-2024	ХЗА ТЗУХ	-	Улсын болон орон нутгийн төсөв	80.0	-	75%	-	-	"Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэлтийн явц болон шийдвэрлэлт нь иргэдэд нээлттэй, ил тод харагддаг байдлаар төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн И-Оффис системтэй уялдаж ажилладаг байхаар нэгдсэн вэб системийг 2022 оны 10 дугаар сараас ашиглаж эхэлсэн. Уг системд Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд хувийн нууцад хамаарах асуудлаар гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг зөвхөн өргөдөл гомдол гаргагч иргэнд өөрт нь харагдахаар, нийтэд хамаарал бүхий асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг нийтэд харагдаж байхаар зохион байгуулагдсан. "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн иргэдэд зориулсан Смарт Эрдэнэт платформ байгуулах ажлыг "Монгол контент" ХХК гүйцэтгэж дуусган хэрэглээний туршилтын шатанд төслэгдэн ажиллаж эхлээд	100%

												байна. Платформ хэрэглээнд нэвтэрснээр мэдээллийн веб сайт, статистик судалгааны бааз, иргэдийн орон нутгийн төрийн үйлчилгээ авах, харилцах, ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх, бизнесийн харилцааг дэмжих боломж бүрдэнэ.	
ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА													
8.2 Аймгийн хэмжээнд төрийн албаны хүний нөөцийн чадавхийг улам сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.													
225	8.2.1Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх системийг үлгэр жишээ хэрэгжүүлнэ. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	Аймгийн хэмжээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, дүгнэх системийг бий болгож И-Оффис системд холбох	2021-2022	ТЗУХ	-	Орон нутгийн төсөв	65.0	-	-	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 216, 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зохион байгуулалтын нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг программ хангамж ашиглан түргэн шуурхай, хялбар байдлаар төлөвлөх, тайлан гаргах, хяналт үнэлгээ хийж, үйл явцыг автоматжуулах программ хангамжийг И-Оффис цахим системд холбосон бөгөөд программ хангамжийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Төрийн захиргааны байгууллагууд Стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зохион байгуулалтын нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшээд байна.	100%
226	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохион байгуулалтын арга хэмжээ авах	2020-2024	ТЗУХ	Нийт төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжү үд	-	-	30%	90%	-	Орон нутгийн төсөв 5.0	Аймгийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдад иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр тогтмол ханган ажиллаж байна. Аймгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг байгууллага тус бүрээр бэлтгэн төрийн байгууллагуудад хүргүүлээ.	90%

												Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн танилцуулга, хууль хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлууд сэдвээр Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороотой хамтран сургалтад 38 төрийн байгууллагын удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт 61 албан хаагчийг хамрууллаа.	
227	8.2.2.Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	Хүний нөөцийн программыг цалингийн нэгдсэн системтэй холбох ажлыг хийх	2020-2021	ТЗУХ СТСХ	-	Орон нутгийн төсөв	167.0	20%	-	-	-	Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нэвтрүүлэх сургагч багшаар бэлтгэгдсэн 5 багш баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн болон Баян-Өндөр, Жаргалант сумдын нийт 96 байгууллагын хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг хянан явцын засвар өөрчлөлтийг байгууллага, албан хаагч бүрээр хийж өгч, ажилтан, алба хаагчдын үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний шинэчлэлтийг бүрэн хийлгэж гүйцэтгэсэн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын цалингийн нэгдсэн систем нь нууцын зэрэглэлд байдаг тул тус системд хамрагдаагүй болно. Сургалтыг төлөвлөгөөний дагуу байгууллагын цалингийн загвар үүсгэх, цалингийн загварт багануудын үзүүлэлтийг зөөвөрлөн байршуулж хадгалах, ур чадварын нэмэгдлийг тооцож оруулах, амралтын цалин бодох, цалингийн түүх оруулах, цалингийн суутгал тохируулж хийх, кодын блок үүсгэх, Хүний нөөцийн нэгдсэн сангийн системд цалингийн сүлжээний зэрэглэл, шатлал өөрчлөх, алба хаагчийн цалингийн мэдээллийн өөрчлөлтийг татах, цалингийн загварт шинээр нэмэгдэл болон суутгал нэмж оруулах, ээлжийн амралт хэрхэн тооцох, загвар файл хэрхэн үүсгэх, зэрэг зааврыг өгч ажиллаж байна. Төрийн албаны цалингийн нэгдсэн систем болон Хүний нөөцийн удирдлагын системийг Орхон аймгийн төсвийн байгууллагын хэмжээнд 100 хувь хамруулж ажилласан.	100%
228	8.2.3.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг тухайн байгууллагуудын жил бүрийн төлөвлөгөөнд тусган	2020-2024	ТЗУХ	Төрийн байгууллагууд	Улсын болон орон нутгийн төсөв	-	20%	50%	-	Улсын болон орон нутгийн төсөв 104.9 Орон нутгийн	Төрийн байгууллага бүр албан хаагчдыг дэмжих нийгмийн хамгааллын болон сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн дагуу судалгааг хагас, бүтэн жилээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна.	90%

	хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллана.	шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах									төсөв /TAX хөтөлбөр/ 300.0	2021-2022 онд аймгийн хэмжээнд нийт төрийн байгууллагуудын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд давхардсан тоогоор 4484 төрийн албан хаагчид 1.9 тэрбум төгрөг, 2023 онд хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөрт 271 төрийн албан хаагчид 45.4 сая төгрөг, орон байраар хангагдахад 2 төрийн албан хаагчид 15.0 сая төгрөг, ажиллах хугацаандаа мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдсан 16 төрийн албан хаагчид 44.5 сая төгрөгийг тус тус олгосон. 2023 онд аймгийн хэмжээнд "Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр"-ийг батлан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн ажиллах журмыг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 300.0 сая төгрөг батлуулан тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 10-аас доошгүй жил ажилласан 9 албан хаагчид 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний дэмжлэгт 61.3 сая, орон нутгийг хөгжүүлэхэх эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, тухайн бүтээл нь орон нутагт бодит үр дүнд хүрч олон нийтэд эерэг өөрчлөлт, сайн үр дүнд хүрсэн 4 албан хаагчид 11.5 сая төгрөг, донорын үүрэг гүйцэтгэж буй болон эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаанд орж буй 2 албан хаагчийн эмчилгээний зардалд 30.0 сая, өрхийн орлого буурч хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй 3 албан хаагчид 6.0 сая төгрөг, төрийн албанд тогтвор суурьшилтай болон үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдыг амины орон сууц барих, худалдан авах болон нөхцөл сайжруулахад 14 албан хаагч, нийт 46 төрийн албан хаагчид 281.1 сая төгрөг, төрийн албан хаагчдын сургалтын зардалд 18.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд тогтвор суурьшилтай, ажлын амжилт гаргасан 8 байгууллагын 13 төрийн албан хаагчдыг гадаад улсад туршлага судлуулах дэмжлэгт хамруулсан. Тус хөтөлбөрийн санхүүжилтээр Монгол Улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "Алсын хараа 2050 сэдэвт богино хугацааны танхимын ажлын байран дахь сургалтыг Ерөнхий сайдын зөвлөх, ЗГХЭГ, Удирдлагын академийн багш нартай хамтран зохион байгуулж тус	
--	-------------------------------------	--------------------------------------	--	--	--	--	--	--	--	--	----------------------------	---	--

												сургалтад 40 байгууллагын 212 төрийн албан хаагч хамруулан суралцах явцад хяналт тавин ажилласан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 29 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр 95.4 хувийн хэрэгжилттэй байна.	
229		Төрийн албан хаагчдыг богино, зорилтот, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар төрөл бүрийн хэлбэрээр хамруулах	2020-2024	ТЗУХ	Төрийн албаны салбар зөвлөл	Улсын болон орон нутгийн төсөв	145.0	10.0	80%	35.0	Орон нутгийн төсөв 14.0	2021-2022 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран нийт 132 төрийн албан хаагчийг сургалтад хамруулан суралцах явцад хяналт тавин ажилласан. 2023 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь" богино хугацааны сургалтын Сургагч багш бэлтгэх сургалтад 2 байгууллагын 3, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 7 байгууллагын 11, дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 15 байгууллагын 15 төрийн албан хаагч, цаашид ажиллах ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 9 байгууллагын 12 төрийн албан хаагч, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 1 төрийн албан хаагчийг тус тус хамруулсан. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ "Алсын хараа 2050" сэдэвт богино хугацааны танхимын ажлын байран дахь сургалтыг Ерөнхий сайдын зөвлөх, ЗГХЭГ, Удирдлагын академийн багш нартай хамтран зохион байгуулж тус сургалтад 40 байгууллагын 212 төрийн албан хаагчдыг танхимаар хамрууллаа. Мөн Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх цахим сургалтыг 2 удаа зохион байгуулан 82 төрийн байгууллагын 2178 төрийн албан хаагч хамрагдан гэрчилгээгээ авсан. Төрийн албаны зөвлөл, "Мерит" төслөөс хамтран "Хувь хүний хөгжил"-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт 10 цагаас цахим сургалт 32 удаа цахимаар зохион байгуулагдан давхардсан тоогоор нийт 1580 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан.	100%
230	8.2.4.Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн	Аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт	2021-2024	ХШҮХ НБХ АОЭХ	ХХҮГ МХГ	Үйл ажиллагааны	-	2019-2020 оны хамтын хэлэлцээр	Хэлэлцээрийн хэрэгжилт	-	-	Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрт 7 бүлгийн 81 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны байдлаар	88.6%

	хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцоог нэмэгдүүлнэ.	хэлэлцээрийг байгуулан ажиллах		ОАҮЭ Х		чиглэлэ эр		ийн хэрэгжилт 92.6%-тай байна.	90%-тай байна.			Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээрийн биелэлт 79.8 хувьтай хэрэгжиж байна.	
231	хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцоог нэмэгдүүлнэ.	Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллах	2021-2024	ХБТХ ОХ	Аймгийн ЗДТГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	2020 онд 28 ТББ 87.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан	14 чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 79.1	2021-2022 онд 30 төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж нийт 120.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. 2023 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас ТББ-уудтай гэрээ байгуулахад 80.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу 17 төрийн бус байгууллагатай хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хоршоо хөгжүүлэх, байгаль экологи, хүнсний аюулгүй байдал, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг олгох, үнийн асуудал зэрэг 14 чиг үүргийн хүрээнд гэрээ байгуулан хамтран ажиллаж 79.1 сая төгрөгийг зарцуулаад байна.	100%
АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ ХОТ													
8.3.Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.													
232	8.3.1.Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлж, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах	2021-2024	ХЭЗХ	МШУТ	Орон нутгийн төсөв	361.5	-	Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	100.0	Орон нутгийн төсөв 90.0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 90 сая төгрөгийн үнэ бүхий камерын засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай тусгай зориулалтын автовишктай автомашиныг худалдан авч Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэж авсан. Автовишктай болсноор давхардсан тоогоор нийт 100 орчим камерын шон дээр 250 гаруй камерыг, дагалдах хэрэгслийн хамт бүрэн шинэчилж засварласан. Мөн гэр хороололд агаарын баганаар татагдсан кабелийн гэмтлийг засварлан 3км шилэн кабель татаж, унжсан аюултай байдал бий болсон 7 цэгт шилэн кабелийг дээш нь татах, сойх ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.	90%
233	удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Хотын гудамж, зам талбайн камержуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2021-2024	ХЭЗХ	МШУТ ЦГ	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Ажиллаж буй камерын тоо 183	Камерын тоог нэмэгдүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 609.7	Баян-өндөр сумын багуудын Засаг дарга, ажлын алба, хэсгийн байцаагч, иргэдийн төлөөлөл нартай уулзалт зохион байгуулж гэмт хэрэг ихээр гардаг хар цэгийн судалгаанд үндэслэн камер суурилуулах байршил, цэгийг 26 багаар нарийвчлан гаргасан. Судалгааны дагуу 2023 онд аймаг, сумын хөрөнгө оруулалтаар Уурхайчин багт 17, Цагаанчулуут багт 12, Эрдэнэ багт 36, Булаг багт 35, Хүрэнбулаг багт 26, Зэст багт 7 ширхэг, нийт 133 ширхэг камерыг шинээр нэмж суурилуулан хүлээн авсан. Дэвшилтэт технологид боловсруулсан өгөгдлийг ашиглан хяналтын камеруудыг үр ашигтай, эдийн засгийн үр өгөөжтэй ашиглаж хиймэл оюун ухаанд	100%

												суурилсан системийг нэвтрүүлэх туршилтыг амжилттай хийсэн. Уг систем нь энгийн камераар авто машины дугаар илрүүлэх, хүний биометрик мэдээлэл, царай төрхөөр олж илрүүлэх боломжтой. Орхон аймгийн хэмжээнд 25 багт нийт 649 камер бүртгэлтэй байгаагаас нэг чиглэлийн 530 ширхэг, PTZ хөдөлгөөнт 107 ширхэг, хэт ягаан туяаны 2 ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 10 ширхэг камер тус тус ажиллаж байна. Камерын хяналтын нэгдсэн төвд 577 иргэн, 40 албан хаагчийн хүсэлтээр 617 удаагийн камерын бичлэг шүүж иргэд, аж ахуйн нэгжид учирсан 352.1 сая төгрөгийн хохирлоос 238.7 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон хохирлыг барагдуулж ажилласан.	
234	8.3.2.Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байр байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.	Түр хамгаалах байрыг байгуулах	2021	ХЭЗХ ХБТХ ОХ	ГБХЗ ХГ ЦГ ЭМГ	Улсын болон орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	-	-	Улсын төсөв 1261.0	2023 онд түр хамгаалах байранд 63 хүнийг хүлээн авч түр байрлуулах, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцаа зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр 10 төрлийн үйлчилгээг үзүүлж, тус ажилд орон нутгийн төсвөөс 35.6 сая төгрөгийг зарцуулсан. Шинээр стандартад нийцсэн хамгаалах байрны төсөл боловсруулан газрын асуудлыг шийдвэрлэж, зураг төсвийг боловсруулан улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлын гүйцэтгэл 75.0 хувьтайгаар барилгын ажил удаашралтай явагдаж байна.	70%
235	8.3.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	30.0	-	Урьдчилан сэргийлэх ажлын хамралтын хувь нэмэгдсэн байна.	8.0	Орон нутгийн төсөв 2.5	Аймгийн хэмжээнд мансууруулах эм худалдах зөвшөөрөлтэй 5, сэтгэцэд нөлөөт эм худалдах зөвшөөрөлтэй 9 эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагын эмийн хяналт, хадгалалт, хамгаалалтад 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж зөвлөмж хүргүүлсэн. 2023 онд нууц далд аргаар үйлдэгдсэн 13 холбогдогчтой 7 гэмт хэрэг, 16 холбогдогчтой 4 зөрчлийг илрүүлэн шалгаж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Анзаар" болон "Туншил" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хорт зуршлаас ангид байлгах сэдэвт сургалт мэдээллийн ажлыг ерөнхий боловсролын 44 төрийн болон төрийн бус байгууллагын нийт 4101 албан хаагчид мэдээлэл	90%

											хүргэн, цахимаар 83 мэдээлэл, постер бэлтгэн мэдээлснээр нийт 47061 иргэн хандаж мэдээлэл авсан байна. Дээрх нэгдсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хамралт өмнөх оноос 25 дахин өссөн өссөн байна. Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангитай хамтран хорих ангийн алба хаагч нарт “Мансуурсан этгээдэд илрэх шинж тэмдэг, биедээ авч явж болзошгүй, хэрэглүүрийг шалгах эсэх” талаар сургалт, мэдээлэл өгч, хоригдогч нарын эд зүйл, биед үзлэг шалгалтыг хийсэн. "Тархцын хяналт-2023" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2017 оноос хойш Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэрэг, мансуурсан гэх зөрчилд холбогдсон этгээдүүдийн судалгааг гаргаж, эмзэг цэгийг тогтоох чиглэлээр хяналт тавьж ажиллалаа.		
236		Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх зорилгоор зориулалтын шаардлага хангасан тестийг үйл ажиллагаандаа ашиглах	2022-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	9.0	-	Гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулсан байна.	3.0	-	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх зорилгоор зориулалтын шаардлага хангасан 150 ширхэг тестийг Цагдаагийн газарт олгосон. 2023 онд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 150 хүнд "Multi drug screen cup" тест ашиглан мөрдөн шалгах ажиллагаа явуулахад 14 хувь нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болох нь тогтоогдож илрүүлэлт 22.2 хувиар өссөн. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Хорих 437 дугаар нээлттэй хорих ангийн хяналтад байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт холбогдон хорихоос өөр төрлийн ял шийтгэл авсан 7 иргэнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгаж ажилласан. Түргэвчилсэн тестийг ихэвчлэн бага насны хүүхэд холбогдсон, хохирсон гэмт хэрэг, зөрчилд ашиглаж байна.	90%
237		Мансууруулах төрлийн ургамлыг устгах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЭЗХ ЦГ	-	Орон нутгийн төсөв	31.0	-	Ургамлын тархцын хэмжээ багассан байна.	8.0	Орон нутгийн төсөв 18.0	Аймгийн нутаг дэвсгэрт ургасан зэрлэг олсны ургамлын тархцыг Аймгийн прокурорын газар, Цагдаагийн газар хамтран судлан тогтоож, "Устгал-2023" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, Баян-Өндөр суманд 15 га, Жаргалант суманд 90 га талбайд ургасан олс /каннабис/-ны ургамлыг устгахад орон нутгийн төсвөөс 18.0 сая төгрөгийг зарцууллаа.	100%

											Жаргалант сумын нутаг дэвсгэрт газар, тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад ногооны талбайн ойр орчимд ургасан сэтгэцэд нөлөөт бодисын агууламжтай каннабисын ургамлын тархцын талаар тайлбарлан ойлгуулж, устгах талаар мэдэгдэл өгч ажилласнаар газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 9 аж ахуйн нэгж 65 га талбайд зэрлэг олсны ургамлыг устгах ажлыг хийсэн байна.		
238	8.3.4.Ял эдэлж буй иргэдийг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нөхцөл боломжийг хангана.	ШШГГ-ын үйлдвэрлэлийн хэсэгт шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хөдөлмөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх	2021, 2024	ХЭЗХ ШШГГ	-	Орон нутгийн төсөв	75.0	-	-	-	Орон нутгийн төсөв 60.0	Хоригдлыг ажлын байраар хангах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, үйлдвэрлэлийн төрөл чиглэлийг өргөжүүлэн хоригдлын мужаан цехэд сийлбэртэй шатар, эмээлийн тавиур, морин хуур, сийлбэртэй цаг бусад бэлэг дурсгалын зүйлс, гар урлал, суран эдлэл, хазаар ногт, чөдөр, ажлын баяжмалын шуудай зэргийг үйлдвэрлэж байна. Төлбөртэй хоригдлыг ажлын байраар хангах чиглэлээр оёдлын цехэд шаардлагатай оёдлын тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлж хоригдлын нийгэмд учруулсан хохирлыг барагдуулахаар ажиллаж байна. Хоригдлыг ажлын байраар хангах чиглэлээр оёдлын цехэд шаардлагатай оёдлын тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж орон нутгийн төсвөөс 60.0 сая төгрөгийг шийдвэрлэн 20 ширхэг оёдлын машин авч, 20 хоригдлыг оёдол, эсгүүрийн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан. 2023 онд нийт давхардсан тоогоор 118 хоригдлыг цалинтай ажлын байраар хангаж 99.2 сая төгрөгийн цалин бодогдож, 54 хоригдлын нэрийн дансанд 11.9 сая төгрөгийг шилжүүллээ. Гэм хорын хохирлын төлбөрт 25 хоригдлын 5.7 сая төгрөг, 2 хоригдлын хүсэлтээр ар гэрт нь 340.0 мянган төгрөг шилжүүлж 86.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж байна.	100%
239	8.3.5.Үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, иргэдэд архивын баримтын	Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалт, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх	2022-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 251.7	Орон нутгийн төсвийн 26.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар архивын баримтын бүртгэлийн ухаалаг тоологчийн төхөөрөмж болон 14900 ширхэг соронзон чип, 5.0 сая төгрөгөөр баримтыг сэргээн засахад шаардлагатай тоног төхөөрөмж, худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төрийн архивын хадгаламжийн сангийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын шинээр баригдсан өргөтгөлийн барилгад 69 м.кв хадгаламжийн сангийн 1 өрөөг	100%

	лавлагаа мэдээллээр шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.											шинээр тохижуулан 220.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2500х900х560 хэмжээ бүхий 13 ширхэг ухаалаг нягтруулсан шүүгээ, галын дохиолол гал унтраах техник хэрэгслээр хангаж сан хөмрөгийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлсэн. Мөн 6 ширхэг иж бүрэн компьютерээр хангаж, баримтыг цахимжуулах болон лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.	
240		Архивын баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд	Цахимжуулалтын хувь 20%	Цахимжуулалтын хувь 40%	Батлагдсан төсвийн хүрээнд	-	"Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 31.9 сая төгрөгийг тусган батлуулснаар нийт 4 гэрээт ажилтан архивын баримтыг цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна. 2021-2023 онд 62 хөмрөгийн 89 дансны 1646 хадгаламжийн нэгжийн 196364 хуудас баримтыг нягтлан шалгаж, скайнаардаж, цахим хувь үүсгэсэн. Үүнээс 62 хөмрөгийн 89 дансны 2646 хадгаламжийн нэгжийн 196364 хуудасны 446441 хүний нэр, 94271 байгууллагын нэр, 49289 газар зүйн нэр, 113167 заалтыг архивын AMS болон E-DOC программд шивж цахим холболт хийн мэдээллийн сан үүсгэн лавлагаанд ашигласнаар иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилж байна. E-DOC программд шивж цахим холболт хийн мэдээллийн сан үүсгэн лавлагаанд ашигласнаар иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилж байна. E-DOCUMENT программд малын А дансыг нягтлан шалгаж, цахим холболтыг хийж, малын А данс бүрэн цахимжсан. Ингэснээр нийт баримтын 40 хувийг цахим хэлбэрт оруулаад байна.	100%
241		Архивд хадгалагдаж буй баримтыг сэргээн засварлах лаборатори байгуулах	2022	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	5.0	-	-	-	Орон нутгийн төсөв 5.0	Архивын баримтыг сэргээн засварлах лаборатори байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангахад зориулж 5.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгаж батлуулсны дагуу зориулалтын ширээ, багаж хэрэгслээр хангагдсан. Тайлангийн хугацаанд нийт 3512 хуудас баримтыг сэлбэн зассан.	100%
242		Архивын байр барих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	2021-2024	ХЭЗХ	Архивын тасаг	Улсын төсөв	Батлагдсан төсвийн	-	Байрыг барих хөрөнгийг	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Төрийн архив болон аймгийн ЗДТГ-ын архивын хадгаламжийн сангийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын шинээр баригдсан өргөтгөлийн барилгад	50%

							хүрээнд		шийдвэрлүүлсэн байна.			138 м.кв хадгаламжийн сангийн 2 өрөөг шинээр тохижуулан 441.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2500х900х560 хэмжээ бүхий 26 ширхэг ухаалаг нягтруулсан шүүгээ, галын дохиолол гал унтраах техник хэрэгслээр хангаж сан хөмрөгийн өрөөний багтаамжийг нэмэгдүүлсэн. Аймгийн хэмжээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар үйлдвэрийн төрөлжсөн архивын зориулалтын байрыг барьж ашиглалтад оруулаад байна. Төрийн архивын байр барих газрын асуудлыг шийдвэрлэж, архивын зориулалтын барилга, өрөө тасалгаанд тавигдах шаардлага, стандарт шинээр батлагдсаны дагуу стандартад нийцсэн барилгын зураг төсвийг 2024 онд хийхээр төлөвлөөд байна.	
243		Архивын баримтын бүртгэлийн UF TAG систем, соронзон кодын бүртгэл, баримтын цахим ухаалаг тоолох систем нэвтрүүлэх	2022	ХЭЗХ	Архивын тасаг	Орон нутгийн төсөв	30.0	-	-	-	Орон нутгийн төсөв 26.0	Архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа байнга хадгалах баримтыг тоолох ажиллагаанд автоматжуулалт нэвтрүүлэх, баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн 26.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зайнаас унших андройд үйлдлийн системтэй тооллогын төхөөрөмж болон тоологчийн соронзон чип худалдан авч үйл ажиллагаандаа ашигласнаар нийт 14900 хадгаламжийн нэгжийг кодлон программд холбосон.	100%
244	8.3.6.Зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол түүнээс үүдэх хор уршгийг бууруулах ажлыг хэрэгжүүлнэ.	“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	2021-2024	ХЭЗХ ЦГ	БШУГ ГБХЗ ХГ	Орон нутгийн төсөв	1.003.0	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь 80%	Батлагдсан төсвийн хүрээнд	Орон нутгийн төсөв 18.0	Аймгийн хэмжээнд 2021-2024 онд хэрэгжүүлэх 3 зорилт 24 арга хэмжээ бүхий "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв, дадал, мэдлэг олгох, эцэг эх асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 17 сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2023" тэмцээнийг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 9.3 сая төгрөг зарцууллаа. "Уусан бол бүү жолоод" нэгдсэн арга хэмжээг 17 удаа зохион байгуулж, өдөр тутмын хяналт шалгалтаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 625 жолоочийг илрүүлэн гарч болзошгүй зам тээврийн осол хэргээс урьдчилан	100%

												сэргийлэх арга хэмжээг авсан. Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 20 удаа сэрэмжлүүлэг болон мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд олон нийтэд өгсөн. Мөн "Erdenet Traffic Paragazzi" цахим хаягт байршуулсан замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 28 жолоочид арга хэмжээ тооцон ажилласан. Тайлант хугацаанд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 45603 зөрчил илрүүлэн 43769 жолоочийг 1009.0 сая төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1571, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 263 жолоочийг илрүүлэн торгуулийн арга хэмжээг тус тус авч ажилласнаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон зөрчил өмнөх оноос 27.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тээврийн хэрэгслийн хурд хэмжигч ТРСАМ багажийг худалдан авч, албан хэрэгцээнд ашиглаж байна. 2023 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласнаар хөтөлбөрийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.	
245	8.3.7.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээг үйлчилгээг сайжруулна.	Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	2021-2024	ХЭЗХ ЦГ	Сумд ын ЗДТГ	Орон нутгийн төсөв	27.0	Гэмт хэргийн тоо 197	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн бууралтын хувь 5%	7.0	Орон нутгийн төсөв 6.0	Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр бүр гудамж талбай, олон нийтийн газруудад хөдөлгөөнт болон явган эргүүлийн 8-10 чиглэлд 16-20 алба хаагчийг тогтмол ажиллуулж, хяналт тавин ажиллаж байна. Мөн Гэрээт цагдаагийн хэлтсээс долоо хоног бүрийн 3, 4, 5 дахь өдрүүдэд нэмэлтээр 10 алба хаагч эргүүл шалгалтад ажиллаж байна. Тайлант хугацаанд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж 45 төрлийн мэдэгдлийг давхардсан тоогоор 221 аж ахуй нэгж байгууллагад хүргүүлэн ажилласан. Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Шаг", "Ахуй хүрээний архидалт", "Хяналт" зэрэг 34 тусгай арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан. Хүйтний эрч чангарч байгаатай холбогдуулан архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэд осгож амь нас, эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баян-Өндөр сумын нутаг	70%

												дэвсгэрт гудамж талбайд эргүүл шалгалтыг зохион байгуулж байна. Эргүүл шалгалтын хүрээнд архи согтууруулах ундаа худалдан үйлчилдэг 254 хүнсний дэлгүүр, 39 бар, ресторан, караоке, паб нийт 293 аж ахуйн нэгж байгууллагад 190 мэдэгдлийг хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан. Хууль тогтоомж зөрчин гар дээрээс согтууруулах ундаа худалдсан, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар хориглосон газар, хугацаанд үйл ажиллагаа явуулж архи согтууруулах ундаа худалдан борлуулсан 34 зөрчил илрүүлэн 21 иргэн, 13 хуулийн этгээдийг 71.0 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авч, 20 литр архи, 70 литр пиво, 112.8 мянган төгрөгийн хууль бус орлогыг хураан авсан. Орон нутагт согтуугаар үйлдсэн 204 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оноос 7.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
246		Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ сайжруулах, албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	2021-2024	ХЭЗХ ЦГ	ЭМГ Сумд ын ЗДТГ	Орон нутгийн төсөв	15.0	Хамрагдсан хүний тоо 20	Шаардлагатай иргэдийг эмчилгээнд хамруулах	5.0	Орон нутгийн төсөв 6.0	Орон гэргүй, тэнэмэл, архи согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэж, гудамж талбайд зөрчил үйлддэг иргэдийн судалгааг гарган нийгэмшүүлэх байранд 30 иргэнийг байршуулсан. Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаагийн сургалт зохион байгуулж нийт 44 иргэнийг хамруулсан. Архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг, орон гэргүй 75 иргэний судалгааг гарган архи согтууруулах ундааны хор уршгийн талаар ухуулга, яриа хийж, архины албадан эмчилгээнд хамруулахад орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөгийг зарцуулаад байна. Мөн "Уяралын бичээс", "Аминчхан яриа" ТББ-уудтай хамтран Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хяналтад байдаг 15 иргэнийг "Зан үйлд нөлөөлөх" 2 удаагийн сургалтад хамруулж, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Сэтгэц, наркологийн төвтэй хамтран 10 иргэнийг албадан, "Ариунсаруулбат" НҮТББ-тай хамтран 20 иргэнийг тус тус сайн дурын эмчилгээнд хамрууллаа. Нийгэмшүүлэх үйлчилгээнд хамрагдалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 иргэнээр буюу 26.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100%

247	8.3.8.Хууль сахиулах байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг сайжруулах замаар иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Хуулийн байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх	2021-2024	ХЭЗХ	ЦГ ШШГГ ШША УБХ МШУТ	Орон нутгийн төсөв	1.864.0	-	Шаардлагат ай техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	500.0	Орон нутгийн төсөв 829.3	2021-2022 онд хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж нийт 2140.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар техник, тоног төхөөрөмжийг олгосон. 2023 онд аймгийн Прокурорын газарт тоног төхөөрөмж худалдан авахад 50.0 сая, Улсын бүртгэлийн хэлтэст киоск машин худалдаж авахад 28.0 сая, Архивын тасагт байнга хадгалах баримтыг сэргээн засварлахад 5.0 сая төгрөг, Мэдээлэл шуурхай удирдлагын төв автовишка худалдан авахад 90.0 сая төгрөг, ШШГГ-ын үйлдвэрлэлийн хэсэгт оёдлын машин худалдан авахад 65.2 сая төгрөг, Цагдаагийн газарт олон нийтийн цагдаагийн цалин, тоног төхөөрөмж худалдан авахад 504.0 нийт 829.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдлээ. Үүнд: ШШГГ-т эмнэлгийн багаж хэрэгсэл худалдан авч өвчтөн хоригдол, хоригдогч, баривчлагдсан этгээдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 18.0 сая төгрөг шийдвэрлүүлж зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн ялтнуудад техникийн хяналт тогтоох, сургалтад шаардагдах 2 ширхэг ухаалаг дэлгэцийг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Шүүх шинжилгээний хэлтэст Баян-Өндөр сумын Уртын гол багт шинээр ашиглалтад орж буй орон сууцнаас 2 өрөө байр олгож сэлгэнээр томилогдон ажиллаж буй алба хаагчдыг байрлуулан нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Малын тамганы цахим сан бүрдүүлэхэд орон нутгийн төсвөөс 4.9 сая төгрөгийг шийдвэрлэснээр "Малын тамганы цахим бүртгэл" SUREG.MN системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, аймгийн адууны тамганы санг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн иргэдэд үйлчлэх төлбөрт үйлчилгээг явуулахад ашиглах Гэрэгэ смарт пос машины төлбөр 1.0 сая төгрөгийг шийдвэрлэн Улсын бүртгэлийн хэлтэст иргэний бүртгэлийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, гэрээт ажилтан ажиллуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 25.2 сая төгрөгийг батлуулж, ажилтны цалин, НДШ-ийг төлж байна. Цагдаагийн газарт Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог 40 орон тоогоор батлуулж,	100%
-----	---	---	-----------	------	----------------------	--------------------	---------	---	---	-------	--------------------------	--	------

											цалингийн хэмжээг нэмэгдүүлэн, цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 459.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, өдөр тутмын удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Замын цагдаагийн тасагт замын хяналт хэрэгжүүлэхэд шаардагдах пүүг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, хуульд заасан үйлчилгээ үзүүлэхэд 35.6 сая төгрөгийг зарцууллаа.		
	БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ												
248	8.4.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, Батлан хамгаалах чадавхыг дээшлүүлнэ.	Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог, бэхжүүлж, томилгоот нэгжийн бэлтгэлжилтийг хангах, нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх	2021-2024	Цэргийн штаб	Сумдын ЗДТГ Хүчний байгууллагууд	Орон нутгийн төсөв	16.2	Томилгоот бүрэлдэхүүний 0%	Томилгоот бүрэлдэхүүний 25%	5.5	Орон нутгийн төсөв 8.1	Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалахын Сайдын 2020 оны А/133 дугаар тушаалын дагуу жил бүр аймгийн Засаг даргын захирамж, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөг удирдлага болгон орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний сургалтыг 1 удаа, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг 3 удаа тус тус Зэвсэгт хүчний 110, 186 дугаар анги дээр гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд томилгоот нэгж нь онц болон дайны байдлын үеийн орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлтгэлийг хангах, иргэн, хуулийн этгээд, албан тушаалтныг гүйцэтгэх үүрэгт нь сурган дадлагажуулах, жигдрэлтийг хангах чиглэлээр томилгоот нэгжийн удирдлага, бие бүрэлдэхүүнтэй тайван цагт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж томилгоот бүрэлдэхүүний бэлтгэл нөөц 30 хувьтай болсон. Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын томилгоот бүрэлдэхүүнийг тодотгох ажлыг үүрэн телефон утас болон биет холбоочноор дамжуулан холбоо зохион байгуулалтыг 100 хувь зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх тусгай байрыг тохижуулж, хувцас хэрэглэлийн нөөцийг бүрдүүлээд байна.	100%
249		Эх оронч үзэл хүмүүжлийн үндэс байх, бодлогыг хэрэгжүүлж иргэн цэргийн харилцааг бэхжүүлж иргэдэд цэргийн боловсрол олгох	2021-2024	Цэргийн штаб БШУГ	БШУГ аймагдахь МЦНХ-ны салбар	Орон нутгийн төсөв	186.0	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 5%	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 20%	38.0	-	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, Их эзэн Чингис хаан мэндэлсний 860 жилийн ойн хүрээнд хүүхэд, залуучуудад тусгаар тогтнол, үндэсний эрх, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх орноороо болон Монгол хүн болж төрснөөрөө	100%

											бахархах, эх байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах ухамсартай, эх оронч иргэнийг төлөвшүүлэх зорилго бүхий “Бидний бахархал” хөтөлбөрийн хүрээнд олон талт арга хэмжээг зохион явуулж байна. Үүнд 2021-2023 онд Монгол цэргийн өдөр, Олон улсын энхийг сахиулагчдын өдөр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол Улсын төрийн далбааны өдөр, Олон улсын ахмадын баярын өдөр, Монгол бахархлын өдөр, Бүгд найрамдах улс тунхагласны өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр, нээлтэй хаалганы өдөр гэх мэт тэмдэглэлт өдрүүдэд аймаг, орон нутагт Батлан хамгаалах хууль тогтоомж сурталчлах, иргэн цэргийн харилцаа, бэхжүүлэх, хүүхэд залуучуудад цэрэг эх орон үзэл төлөвшүүлэх зэрэг 32 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 190800 иргэнд хүргэн, нийт хүн амын 60 хувьд сурталчилсан. 2023 оны байдлаар “Бидний бахархал” үндэсний хөтөлбөр 60 хувийн хэрэгжилттэй байна.		
250	8.5.Дайчилгааны төлөвлөгөөг боловсронгуй болгон, дайчилгааны бэлтгэл нөөцийн бие бүрэлдэхүүний тоо чанарыг нэмэгдүүлнэ.	Дайчилгааны төлөвлөгөөг өнөөгийн нийгэмд эдийн засгийн нөхцөлд тулгуурлан шинэчлэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, бие бүрэлдэхүүний тоо, чанар материаллаг баазыг сайжруулах	2021-2024	ЗХЖ Ш, Цэргийн штаб	Аймгийн ЗДТГ Цэргийн штаб Зэвсэгт хүчний 186 дугаар анги	Улсын болон орон нутгийн төсөв	86.6	Дайчилгааны бэлтгэл нөөц 20%	Дайчилгааны бэлтгэл нөөц 20%	25.8	-	“Баян-Өндөр, Жаргалант сумдын дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, Цэргийн штаб, сум багийн удирдлагатай харилцан ажиллах дарааллыг тогтоож, зарлан мэдээлэх холбоо зохион байгуулалтын журмыг харилцан тодотголоо. Дайчилгааны даалгавартай Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудтай тогтоосон хугацаанд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөөнд тодотгол хийсэн. Цэргийн штабын сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалт бэлтгэлийг төлөвлөгөөний дагуу тасралтгүй зохион явуулж байна.	90%
251	8.6.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Орон нутгийн хэмжээнд тохиолдож болох гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Гамшгаас хамгаалах алба.	2021-2024	ОБГ	Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүн	Орон нутгийн төсөв	100.0	Гамшиг осолд ажиллах хүн хүч техник хэрэгслийн бэлтгэл бэлэн	Аймгийн гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний иж бүрэн	15.0	Орон нутгийн төсөв 37.0	Аймгийн Засаг даргын 2022 оны А865 дугаар захирамжаар батлагдсан хуваарийн дагуу Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний газар хөдлөлтийн гамшигын үед удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хохирол багатай даван туулах, гамшгийн үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны онолын мэдлэгийг олгож, дадлагажуулах команд	100%

		мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах зорилгоор үе шаттайгаар сургалтуудыг зохион явуулах, шаардлагатай хүн хүч техникийн нөөц бүрдүүлэх						байдал хангах	шалгалт зохион байгуулах			штабын сургуулийг 2023 оны 3 дугаар сард зохион байгууллаа. Сургалтад Гамшгаас хамгаалах Барилга, хот байгуулалтын алба, Хот байгуулалтын мэргэжлийн анги, Нүүлгэн шилжүүлэх мэргэжлийн анги, Тохижилт үйлчилгээний мэргэжлийн анги, Хорогдох байрны мэргэжлийн ангийн удирдлага нийт 34 ажилтан, алба хаагч хамрагдсан. Сургалтын үйл ажиллагааг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний техник хэрэгслийн бэлэн байдал болон хүн нэг бүрийн хээрийн үүргэвчинд үзлэг хийсэн. Танхимын сургалтаар - Гамшгаас хамгаалах тухай хууль, - Гамшгийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, - Мэргэжлийн ангийн дүрэм, мэргэжлийн ангийн удирдлага зохион байгуулалт, Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ, - Гамшгийн үеийн холбоо зохион байгуулалт, - Анхны тусламж сэдвүүдээр штабын дадлага сургалтыг гамшгийн үеийн цагийн байдал дээр ажиллуулан дадлагажуулсан. Стратегийн команд штабын сургуулийг Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож "онц байдал" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа сэдвээр зохион байгуулж, гамшгаас хамгаалах 12 алба, 22 мэргэжлийн ангийн 680 албан хаагчийн аранз, хувийн бэлтгэлийг 1 удаа яаралтай цуглах дохиогоор ажиллуулан шалгаж, 132 удирдах албан тушаалтныг гамшгийн үеийн цагийн байдалд ажиллуулсан. Аймгийн хэмжээнд гамшгийн зарлан мэдээлэх дуут дохиогоор 32700 хүн оролцож ажилласан.	
	Нийт дүн											91.5%	

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР
--oOo--